



НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ



# ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА

ЦУВРАЛ 3



НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ

# ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА

**ЦУВРАЛ 3**

Улаанбаатар 2021

ННА 67.404  
ДАА 347  
Ш-978



## ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА ЦУВРАЛ 3

### СУДЛААЧИД:

1. Б.Баялагмаа
2. Б.Наранцэцэг
3. Э.Энхцэцэг
4. Б.Уянга
5. Б.Анхзаяа
6. Ц.Уянга

Дугаар хариуцсан редактор Н.Отгончимэг

© Нээлттэй Нийгэм Форум, 2021.

Энэхүү цувралд багтсан судалгаануудын дүгнэлт, санал нь судалгааг хийж гүйцэтгэсэн судлаачдын байр суурь, үзэл бодол бөгөөд Нээлттэй Нийгэм Форумын албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

ISBN 978-9919-9812-6-6

# Шүүхийн шийдвэрийн судалгаа

## ЦУВРАЛ 3



# 1

**ИРГЭНИЙ ХЭРЭГ ҮҮСГЭХ АЖИЛЛАГАА ДАХЬ  
ШҮҮХЭД МЭДҮҮЛЭХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ**

НЭХЭМЖЛЭЛИЙГ ХҮЛЭЭН АВАХААС ТАТГАЛЗАХ  
ЗАХИРАМЖИЙН ЖИШЭЭН ДЭЭР

9

# 2

**ЦАЛИН ХӨЛСНИЙ МАРГААНЫГ  
ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН  
ШИНЖИЛГЭЭ**

111



## ӨМНӨХ ҮГ

Шүүхийн шийдвэрийн судалгааг шинэ үеийн судлаачид илүү сонирхож байгаа нь эхний цувралуудаас ажиглагдаж байна. Энэ удаагийн цувралд багтсан тайлангуудын онцлог нь иргэний хэргийн шүүхийн практикт тулгарч буй сорилтод хүний эрх талаас нь анхааран дүгнэлт хийж, иргэдэд төвөг, чирэгдэл учруулж байгаа бодит асуудлыг сонгон авч судалсан явдал юм.

Шүүхийн тухай хууль шинэчлэгдэн, олон нийтийн дунд өндөр хүлээлт үүссэн энэ цаг мөчид шүүхийн захиргаа, шүүгчийн зүгээс иргэнээс гаргаж буй нэхэмжлэлийг хүлээн авахаас удаа дараа татгалзах явдал цөөнгүй байна. Энэ асуудлын хууль зүйн үндэслэл, гаргалгааг энэхүү цувралд багтаав. Түүнчлэн иргэдийн амьжиргааны үндсэн эх үүсвэр цалин, орлоготой холбоотой маргааныг ул суурьтай шийдвэрлэхэд хэрэг болохуйц санал зөвлөмж, арга замыг уг цувралаас унших боломжтой.

Нээлттэй Нийгэм Форумын Шүүхийн шийдвэрийн судалгааны редакцын зөвлөлийн гишүүн, судлаач, хуульч Н.Отгончимэг тус дугаарыг эрхлэн өөрийн туршлага мэдлэгийг залуу судлаачидтай харамгүй хуваалцаж, судалгааны тайланг хянан тохиолдуулж ажилласанд гүн талархал илэрхийлье. Мөн энэ цувралд багтсан судалгааны тайлангуудыг хэвлэлтийн өмнө уншин, шүүмж өгсөн МУИС-ийн ХЗС-ийн багш, доктор, дэд

профессор С.Болормаа, ХУД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ц.Оюунбилэг нарт талархал илэрхийлье.

Энэхүү цувралд орсон судалгааны тайлангууд нь иргэний хэргийн шүүхээс хэрэг маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг хүртээмжтэй, хуулийн хэрэглээг нэг мөр болгоход тус дөхөм болно гэж найдаж байна. Эрхэм хуульч, судлаач Та бүхэн эдгээр судалгааны талаарх санал, шүүмжээ бидэнтэй харамгүй хуваалцаж, шүүхийн практикийн судалгааг хөгжүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулахыг хүсье.

П.Эрдэнэжаргал  
ННФ-ын Гүйцэтгэх захирал

## **РЕДАКТОРЫН ЗУРВАС**

“Шүүхийн шийдвэрийн шинжилгээ” эмхэтгэлийн энэ удаагийн цувралд “Иргэний хэрэг үүсгэх ажиллагаа дахь шүүхэд мэдүүлэх эрхийн хэрэгжилт” (нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах захирамжийн жишээн дээр), “Цалин хөлсний маргааныг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ” сэдвээр иргэний хэргийн шүүхийн шийдвэрүүдийг сонгон судалж, анализ шинжилгээ хийсэн судалгааг толилуулж байна.

Зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо шүүхэд хандан хамгаалуулах нь Монгол Улсын Үндсэн хуулиар иргэдэд олгосон үндсэн эрх билээ. Энэ эрхийг иргэдэд явдал чирэгдэлгүй, түргэн шуурхай үйлчлэх замаар хангах, мөн нэхэмжлэл хүлээн авах, хэрэг үүсгэх талаарх зохицуулалтыг нэхэмжлэлийг буцаах шалтаг, боломж болгон хэрэглэхгүй байх нь аливаа шүүхийн үүрэг мөн. Судлаач Б.Баялагмаа, Б.Наранцэцэг, Э.Энхцэцэг, Б.Уянга нар шүүхэд мэдүүлэх иргэний энэхүү үндсэн эрхийн хэрэгжилтийг нэхэмжлэл хүлээн авахаас татгалзах захирамжийн практикт үндэслэн судалснаар энэхүү сэдэв нь шүүхэд итгэх иргэдийн итгэлийг дээшлүүлэхэд цаг үеийн анхаарал татсан асуудал мөн болохыг нотлон харуулжээ.

Хөдөлмөрийн маргааны зонхилох хэлбэрийн нэг болох цалин хөлстэй холбоотой маргааныг судлаач Б.Анхзаяа, Ц.Уянга нар



“Цалин хөлсний маргааныг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ” сэдвийн хүрээнд авч үзжээ. Энэ судалгаагаар сүүлийн үед түгээмэл ажиглагдах болсон богино хугацаагаар ажиллуулж, хөдөлмөр эрхлүүлсний дараа ажил олгогч цалин хөлс олгохгүй бусдын хөдөлмөрлөх эрхийг зөрчиж байгаад, мөн цалин хөлстэй холбоотой нэмэгдэл хөлс, ажилгүй байсан хугацааны олговор, сахилгын давтан зөрчил зэрэгт тухайлан анхаарал хандуулсан нь онцлог байв.

Судлаачид дээрх сэдвүүдийн хүрээнд шүүхийн шийдвэрт анализ шинжилгээ хийж, холбогдох чиглэлээр гадаад улсын эрх зүйн зохицуулалтыг судлан дүгнэлт, санал дэвшүүлсэн нь шүүхийн практик судлалыг хөгжүүлэх, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах, бодлогын шийдлийн хувилбар боловсруулах зэрэгт хувь нэмэр болно гэдэгт итгэлтэй байна.

Цувралын редактор  
Н.Отгончимэг

# 1

## ИРГЭНИЙ ХЭРЭГ ҮҮСГЭХ АЖИЛЛАГАА ДАХЬ ШҮҮХЭД МЭДҮҮЛЭХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ НЭХЭМЖЛЭЛИЙГ ХҮЛЭЭН АВАХААС ТАТГАЛЗАХ ЗАХИРАМЖИЙН ЖИШЭЭН ДЭЭР

### СУДЛААЧДЫН ТАНИЛЦУУЛГА



#### БАЯРААГИЙН БАЯЛАГМАА

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн  
НЭЗТ-ийн дадлагажигч багш, хуульч  
(LL.M of Kutafin Moscow State Law University).

Б.Баялагмаа нь банк санхүүгийн салбарт 2015-2017 онд хууль зүйн мэргэжлээрээ ажилласан ба иргэний болон захиргааны хэрэг маргаануудад хууль зүйн туслалцаа үзүүлдэг. Тэрээр одоогоор Монгол Улс дахь цахим шүүхийн ажиллагаа, цахим нотлох баримт, мэдээллийн технологи болон эрх зүйн чиглэлээр харьцуулсан судалгаа дээр ажиллаж байна.



#### БАТСАЙХАНЫ НАРАНЦЭЦЭГ

Өмгөөллийн “Фиделитас Партнерс” ХХН-ийн  
Гүйцэтгэх захирал, партнер хуульч, нягтлан  
бодогч, өмгөөлөгч.

Хөрөнгийн зах зээл, хөрөнгө оруулалтын бүртгэл, татварын эрх зүйн чиглэлээр зөвлөгөө өгдөг бөгөөд 2015 оноос хойш захиргааны эрх зүйн чиглэлээр өмгөөлөл хийж байгаа. Одоогоор мэдээллийн технологийн компаниудад зөвлөгөө өгөх, виртуал хөрөнгө, цахим арилжааны эрх зүйн орчныг судлах чиглэлд нөхөрлөлийн үйл ажиллагааг удирдан явуулж байна.

Судлаачдын  
багийн ахлагч:


Б.Баялагмаа (LL.M)

Судлаачид:

Б.Наранцэцэг (LL.B)

Э.Энхцэцэг (LL.B)

Б.Уянга (LL.B)



### ЭНХБААТАРЫН ЭНХЦЭЦЭГ

Өмгөөллийн “Фиделитас Партнерс” ХХН-ийн  
партнер хуульч, өмгөөлөгч.

Иргэний болон дампуурлын хэрэгт хууль зүйн  
туслалцаа үзүүлдэг. Компанийн засаглал,  
франчайз, компанийн эрх зүй, хөдөлмөрийн  
эрх зүй, эдийн бус хөрөнгө, оюуны өмчийн  
чиглэлээр зөвлөгөө өгдөг. Тэрээр виртуал  
хөрөнгийн эрх зүйн орчин, олон улсын  
туршлагыг судалж байна.



### БЭГЗЖАВЫН УЯНГА

Өмгөөллийн “Фиделитас Партнерс” ХХН-ийн  
өмгөөлөгчийн туслах.

Эрх зүйч, сэтгүүлч мэргэжилтэй. Мэдээлэл  
технологийн үйл ажиллагаа явуулдаг хуулийн  
этгээдүүдэд компанийн эрх зүйн чиглэлээр  
зөвлөгөө өгдөг. Одоогоор компанийн  
засаглал, гэрээний эрх зүйн чиглэлээр  
практик судалгаа хийж гүйцэтгэж байна.

## ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ .....	12
УДИРТГАЛ .....	13
НЭГ. ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА ДАХЬ ШҮҮХЭД МЭДҮҮЛЭХ ЭРХ БА ТУЛГАМДСАН АСУУДАЛ .....	21
1.1. Шүүхэд мэдүүлэх эрхийн ойлголт, хамрах хүрээ .....	21
1.2. Шүүхэд мэдүүлэх эрхийг хэрэгжүүлж буй хэлбэр ....	27
ХОЁР. НЭХЭМЖЛЭЛ ХҮЛЭЭН АВАХААС ТАТГАЛЗАХ ЗОХИЦУУЛАЛТЫГ ХЭРЭГЛЭЖ БУЙ ШҮҮХИЙН ПРАКТИК .....	33
2.1. Нэхэмжлэл хүлээн авахаас татгалзах эрх зүйн үндэслэл ба шүүхийн практикийн дүн шинжилгээ ...	33
2.2. Нэхэмжлэл хүлээн авахад саад болсон зөрчлийг хэрхэн засахыг заах шүүхийн үүргийн хэрэгжилт ....	91
2.3. Нэхэмжлэл хүлээн авахаас татгалзсан захирамжид гомдол гаргасан, түүнийг шийдвэрлэсэн байдал .....	93
ДҮГНЭЛТ .....	98
САНАЛ .....	104
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ .....	107

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ИХШХШтХ	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
ИХ	Иргэний хууль
ХХША	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа
УТХ	Улсын тэмдэгтийн хураамж
БЗДИХАШШ	Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх
БГДИХАШШ	Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх
ХУДИХАШШ	Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх
СХДИХАШШ	Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх
ОХУ	Оросын Холбооны Улс
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

## УДИРТГАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 14-т “шүүхэд мэдүүлэх эрх”-ийг “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх...” гэж, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (ИХШХШТХ)-ийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Монгол Улсын хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлоо зөрчигдсөн гэж үзэж байгаа аливаа этгээд уг эрхээ хамгаалуулахаар энэ хуульд заасан журмын дагуу шүүхэд нэхэмжлэл, хүсэлт, гомдол гаргах хэлбэрээр мэдүүлэх эрхтэй” гэж тус тус тодорхойлсон. Энэ эрхийн дагуу иргэн, хуулийн этгээдээс зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл (хүсэлт, гомдол) гарган, маргаантай асуудлаа шүүхийн журмаар хуулийн дагуу, үндэслэлтэй шийдвэрлүүлэх боломж бүрдсэн.

Шүүхэд гаргасан нэхэмжлэл, хүсэлт, гомдлыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх журмын дагуу хэрэг үүсгэн шийдвэрлэхээс өмнө нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах тохиолдол цөөнгүй байна. Монгол Улсын хэмжээнд 2018 онд иргэний хэргийн шүүхэд нийт 64,518 нэхэмжлэл гаргасны

10,397 буюу 16.1 хувийг<sup>1</sup>, 2019 онд нийт 62,010 нэхэмжлэл гаргасны 9,737 буюу 15.79 хувийг хүлээн авахаас татгалзжээ.<sup>2</sup> Эдгээр тоон үзүүлэлтээс харахад иргэний 10 нэхэмжлэл тутмын нэгээс хоёрыг хүлээн авахаас татгалзаж байна гэсэн үг юм. Тодруулбал, иргэний хэргийн шүүхээс 2019 онд хүлээн авахаас татгалзсан нийт 9,737 захирамжийн 67 хувьд “нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангаагүй” гэсэн үндэслэл дурдан хүлээн авахаас татгалзсан байна (Нэхэмжлэл хүлээн авахаас татгалзсан үндэслэлийн дэлгэрэнгүйг График 1-д харуулав).<sup>3</sup>



Эх сурвалж: ШЕЗ, Шүүн таслах ажиллагааны тайлангийн тоон мэдээлэл

<sup>1</sup> Монгол Улсын Дээд шүүхийн албан ёсны цахим хуудас, Улсын Дээд шүүхээс гаргасан 2018 онд улсын хэмжээнд хянан шийдвэрлэсэн иргэний хэрэг, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тойм.  
<http://www.supremecourt.mn/act/view/260> 2021.04.15-ны өдөр хандав.

<sup>2</sup> Шүүн таслах ажиллагааны 2019 тайлан. Мэдээллийг 2020.11.03-ны өдөр Шүүхийн ерөнхий зөвлөлөөс авав.

<sup>3</sup> Шүүн таслах ажиллагааны 2019 тайлан. Мэдээллийг 2020.11.03-ны өдөр Шүүхийн ерөнхий зөвлөлөөс авав.

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс эрхлэн гаргасан Шүүн таслах ажиллагааны тайлангийн тоон мэдээлэл (График 1)-ээс үзвэл иргэний хэргийн анхан шатны шүүхээс дээрх нийтлэг хууль зүйн дөрвөн үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан шүүгчийн захирамж гарсан байна. Мөн нэхэмжлэл хүлээн авахаас татгалзах хуулийн зохицуулалт, түүнийг хэрэглэж байгаа шүүхийн практик тойрсон дараах бүрхэг асуудлуудын шалтгаан нөхцөлийг судлах зайлшгүй хэрэгцээ, шаардлага үүсээд байна. Үүнд:

- ижил төрлийн шаардлага, үндэслэл бүхий нэхэмжлэлийг дүүргийн анхан шатны шүүхүүдэд гаргахад хүлээн авах эсхүл хүлээн авахаас татгалзах байдлаар ИХШХШТХ-ийн зохицуулалтыг ялгаатай тайлбарлан, хуулийг нэг мөр хэрэглэхгүй байх;
- нэг үндэслэлээр олон удаа татгалзах;
- дахин шүүхэд хандах тухай тайлбарлахгүй байх;
- нэхэмжлэл хүлээн авахад ямар зөрчил саад болж, түүнийг хэрхэн арилгавал хүлээн авахыг дурдахгүй байх, дурдсан ч ойлгомжгүй, тодорхойгүй байх.

Улсын Дээд шүүхээс гаргасан “2018 онд улсын хэмжээнд хянан шийдвэрлэсэн иргэний хэрэг, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тойм” мэдээлэлд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад залруулах боломжтой ялимгүй зөрчлийн үндэслэл зааж нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах нь иргэн, хуулийн этгээдэд цаг хугацаа, шаардлагагүй өртөг зардал үүсгэж байна. Үүнээс гадна талуудын эрх ашигт сөргөөр нөлөөлөх үр дагавар үүсгэх нөхцөл бүрдүүлдэг тул шүүх хүлээн авахаас татгалзаж буцаасан нэхэмжлэлийн тоо жил тутам өссөн дүнтэй гарч байгаад анхаарал хандуулах



шаардлагатай талаар дурджээ.<sup>4</sup> Гэсэн хэдий ч өнөөдрийг хүртэл иргэн, хуулийн этгээд олон удаа шүүхэд нэхэмжлэл гаргах, тэр бүрд улсын тэмдэгтийн хураамж (УТХ) төлөх, төлөх боломжгүй тохиолдолд УТХ-ийг буцаан гаргуулахаар хүлээж цаг хугацаа алдах, цаашлаад шүүхэд хандахаас залхах, шүүхэд итгэх итгэл буурах зэрэг олон сөрөг үр дагавар дагуулсаар байна.

Иргэн, хуулийн этгээдийн шүүхэд мэдүүлэх эрхийг хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хязгаарлаж буй эсэхийг иргэний шүүх дэх нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан шүүгчийн захирамжид дүн шинжилгээ хийх замаар судалж, шүүхийн практикт үүсэж буй асуудлын үндсэн шалтгаан, нөхцөлийг илрүүлснээр зохистой шийдвэрлэх арга замыг тодорхойлох боломжтой болох юм.

Бид иргэний хэргийн шүүхээс нэхэмжлэл хүлээн авахаас татгалзсан шүүгчийн захирамжийн жишээ, тоон үзүүлэлтэд үндэслэн иргэний хэрэг үүсгэх ажиллагаа дахь шүүхэд мэдүүлэх эрхийн хэрэгжилт болон ИХШХШТХ-ийн 62, 65 дугаар зүйлийн хэрэглээг харьцуулан судалж, уг судалгааг судлаач, шүүгчдийн анхааралд оруулах замаар практик асуудлуудыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулахыг зорилоо.

Судалгааны багийн зүгээс уг судалгааг хийж гүйцэтгэхдээ формаль-хууль зүйн (цэвэр хууль зүйн талаас нь үнэлэлт дүгнэлт өгөх) болон эрх зүйн харьцуулсан судалгааны арга ашиглаж, дараах хүрээнд мэдээлэл цуглуулан боловсруулав. Үүнд:


- Шүүхэд мэдүүлэх эрхийн талаарх онолын үзэл баримтлал, судлаачдын байр суурь, хууль зүйн салбарын өгүүлэл, илтгэл, материаллаг ба процессын хуулийн

<sup>4</sup> Улсын Дээд шүүхээс гаргасан 2018 онд улсын хэмжээнд хянан шийдвэрлэсэн иргэний хэрэг, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тойм. <http://www.supremecourt.mn/act/view/260> мэдээллийг 2021.04.15-ны өдөр татаж авав.

тайлбар, ХБНГУ, ОХУ болон Япон Улсын эрх зүйн зохицуулалт, нэг сэдэвт бүтээлүүдээс судлан формаль-хууль зүйн аргад үндэслэн үнэлэлт дүгнэлт өгөв.

- Иргэний хэргийн шүүхээс “Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах” процессыг зохицуулсан Монгол Улсын хууль тогтоомж, Монгол Улсын Дээд шүүхийн Иргэний хэргийн танхимаас гаргаж буй тайлбар, зөвлөмжийн уялдаа холбоог харьцуулан судлав.

Монгол Улсын хэмжээнд 2019 онд иргэний хэргийн анхан шатны шүүхээс нийт 9,737 нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзжээ. Үүний 75.2 хувь буюу 7,324 нь нийслэлийн зургаан дүүргийн шүүхээс гаргасан татгалзал байна (График 2-ыг харна уу).<sup>5</sup>



<sup>5</sup> Шүүн таслах ажиллагааны 2019 тайлан. Мэдээллийг 2020.11.03-ны өдөр Шүүхийн ерөнхий зөвлөлөөс авав.

Нийслэлийн зургаан дүүргийн иргэний хэргийн шүүхэд гаргасан нэхэмжлэл, түүнийг хүлээн авахаас татгалзсан тоон мэдээллийг харьцуулан үзвэл иргэн, хуулийн этгээдээс зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар шүүхэд гаргасан нэхэмжлэлийн дунджаар 19 хувийг хүлээн авахаас татгалзжээ.

Нийслэлийн зургаан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн архивд буй 2019 онд гаргасан шүүгчийн нийт захирамжаас “Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах тухай” захирамжуудыг ялган авч, биечлэн танилцах замаар практикийн судалгаа хийлээ. Судалгааны хүрээнд дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхүүдэд шүүгчийн захирамжуудтай танилцах хүсэлтээ 2020 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр хүргүүлсэн бөгөөд Чингэлтэй болон Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газруудаас татгалзсан хариу өгсөн болно.

Иймд судалгааны багийн зүгээс нэхэмжлэл хүлээн авахаас татгалзаж буй шүүхийн практикийг 2019 оны тоон үзүүлэлт (График 3)-д үндэслэн хийж гүйцэтгэлээ. Ингэхдээ хамгийн өндөр татгалзалтай буюу нийт нэхэмжлэлийн 21-ээс дээш хувийг хүлээн авахаас татгалзсан Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүдийн иргэний хэргийн анхан шатны шүүх, нийт нэхэмжлэлийн дунджаар 19 хувиас дээш нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх, хамгийн бага хувьтай татгалзсан Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийг тус тус сонгон авч судалсан юм.



2019 онд гаргасан шүүгчийн нийт захирамжаас “Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах тухай” шүүгчийн 714 захирамжийг ялган, 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрөөс хойш гурван сарын хугацаанд танилцаж, практик судалгаа хийв.

Нэхэмжлэл хүлээн авахаас татгалзсан захирамжийн үндэслэл бүрийн 13 хувьтай танилцсанаар судалгааны арга зүйн хувьд тухайн үндэслэл дээр 95 хувийн итгэх магадлал (зөвшөөрөгдөх алдаа 5 хувь)-тай дүгнэлт хийх боломжтой гэж үзсэн. Тодруулбал, улсын хэмжээнд нэхэмжлэл хүлээн авахаас татгалзсан 9,737 тохиолдлоос нийслэлийн дөрвөн дүүрэгт хамаарах 5,264 тохиолдлыг эх олонлог гэж үзнэ. Эх олонлогийн 13 хувь болох 685 захирамжтай танилцах тооцоолол хийсэн нь 95 хувийн итгэх магадлалд хүрэх тооцоолол юм.

Судалгаагаар ИХШХШТХ-ийн 62, 65 дугаар зүйлд заасан нэхэмжлэл хүлээн авахаас татгалзах зохицуулалтын хэрэглээний нэгдмэл бус байдал буюу тодорхой тохиолдлуудад

ИРГЭНИЙ ХЭРЭГ ҮҮСГЭХ АЖИЛЛАГАА ДАХЬ  
ШҮҮХЭД МЭДҮҮЛЭХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ

шүүгчээс хуулийг ялгаатай тайлбарлан хэрэглэж буй практикт дүгнэлт хийн, бусад улс орны иргэний процессын хууль тогтоомжийг харьцуулан судлах замаар иргэний хэрэг үүсгэх ажиллагаа дахь нэхэмжлэл хүлээн авахаас татгалзах зохицуулалтыг боловсронгуй болгох дүгнэлт, санал боловсруулснаа энэхүү судалгаанд оруулав.

## **НЭГ. ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА ДАХЬ ШҮҮХЭД МЭДҮҮЛЭХ ЭРХ БА ТУЛГАМДСАН АСУУДАЛ**

### **1.1. ШҮҮХЭД МЭДҮҮЛЭХ ЭРХИЙН ОЙЛГОЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ**

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 12-т зааснаар хүн бүр төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй, мөн 14-т зааснаар Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах эрхтэйг өмнө дурдсан. Монгол Улсын хууль төдийгүй олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах эрх нь эрүү, иргэн, захиргааны болон эрх зүйн бусад хэм хэмжээ, иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны Үндсэн хуулиар илэрхийлэгдсэн тулгуур эх сурвалж юм.<sup>6</sup>

Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан шүүхээр хамгаалуулах эрхийг иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэгжүүлэх суурь нөхцөл болгож ИХШХШТХ-ийн 3 дугаар зүйлд “Шүүхэд мэдүүлэх эрх” гэж зохицуулсан. Тодруулбал, Монгол Улсын хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны

<sup>6</sup> Ханнс Зайделийн сангийн дэргэдэх Эрх зүйн боловсролын академи, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, УБ., 2009, 94 дэх тал.

ашиг сонирхлоо зөрчигдсөн гэж үзэж байгаа аливаа этгээд уг эрхээ хамгаалуулахаар энэ хуульд заасан журмын дагуу шүүхэд нэхэмжлэл, хүсэлт, гомдол гаргах эрхтэй.

Эрхээ хамгаалуулахаар шүүхэд мэдүүлэх эрх нь хувь хүний процессын үндсэн эрх бөгөөд эрх зүйт аль ч төрийн шүүхийн ажиллагааны салшгүй нэг хэсэг юм.<sup>7</sup> Зөвхөн Монгол Улсын иргэн, хуулийн этгээдээр хязгаарлагдахгүй эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн гадаадын иргэн, харьяалалгүй хүн шүүхэд мэдүүлэх эрхийн дагуу зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр иргэний хэргийн шүүхэд хандах хууль зүйн боломжийг Монгол Улсын Үндсэн хуульд баталгаажуулжээ. Эрхээ хамгаалуулахаар шүүхэд мэдүүлэх эрх нь зөвхөн анхан шатны шүүхэд хандах замаар биш, мөн иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны бусад үе шатанд давж заалдах болон хяналтын шатанд хэрэгжинэ.<sup>8</sup> Тодруулбал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа (ХХША)-ны явцад хэргийн оролцогчдын эрх ашиг зөрчигдсөн тохиолдолд холбогдох зөрчлийг арилгуулахаар гомдол гаргах эрхийг хэрэгжүүлэх, хуулийн дагуу ХХША-нд оролцогчийн эрхийг хангуулахаар тухайн шатны шүүхэд эсхүл давж заалдах шатны шүүхэд хандахыг ойлгоно. “Шүүгчийн ёс зүйн Бангалорын зарчмуудыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх арга хэмжээ” тунхгийн<sup>9</sup> тавдугаар зүйлд зааснаар шүүхэд хандах эрх нь эрх зүйт ёсыг хэрэгжүүлэхэд ач холбогдолтой бөгөөд шүүх нь олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд энэ эрхийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн процессыг бүрдүүлнэ.

Харьцуулсан эрх зүйн судалгааны хүрээнд ХБНГУ, ОХУ, Япон Улсын хууль тогтоомжуудад шүүхэд мэдүүлэх болон

<sup>7</sup> Б.Буянхишиг, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй, УБ., 2021, 30 дахь тал.

<sup>8</sup> Монгол Улсын Дээд шүүхийн Иргэний хэргийн танхим, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар, УБ., 2014, 20 дахь тал.

<sup>9</sup> ШЕЗ, Шүүхийн хараат бус байдал: Олон улсын баримт бичиг, УБ., 2019, 283 дахь тал.

шүүхээр хамгаалуулах эрхийн үндсийг хэрхэн зохицуулж буйг авч үзье.

ХБНГУ-ын Үндсэн хуульд шүүхэд мэдүүлэх эрхийн талаар нарийвчлан заагаагүй ч энэ нь нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн Үндсэн хуулийн ерөнхий зарчмуудаас гаралтай эрх юм.<sup>10</sup> Энэхүү эрх нь (i) хараат бус шүүхээр маргаан шийдвэрлүүлэх; (ii) жижиг нэхэмжлэл эсэхээс үл хамаарч үр дүнтэй хууль зүйн хамгаалалтыг Үндсэн хуулиар баталгаажуулах асуудал багтана.<sup>11</sup> Шүүхэд мэдүүлэх эрхийг бүр нарийвчилбал энэхүү эрх нь хууль зүйн ажиллагааг тодорхой, хурдан гүйцэтгэх явдлыг баталгаажуулахад чиглэсэн хууль тогтоогчийн хязгаарлалт болон шаардлагатай холбогддог.<sup>12</sup> Гэхдээ энэхүү хязгаарлалт болон шаардлага нь хамгаалалт хүсэж буй иргэнд хэт ачаалал болох ёсгүйг анхаарах нь зүйтэй. Иймд шүүхэд мэдүүлэх эрх нь нэхэмжлэл гаргах процесс иргэнд хүндрэл учруулахгүй, хялбар байхтай шууд холбогдох бөгөөд энэ нь цаашлаад нэхэмжлэгчийн зөрчигдсөн эрхийг сэргээх, түүнийг аль болох хурдан хамгаалахад нөлөөлөх чухал хүчин зүйлсийн нэг болно.

ХБНГУ-ын иргэний хэрэг шийдвэрлэх ажиллагаанд талуудын диспозитив зарчмын хүрээнд тэдэнд туслах, зөвлөх шүүхийн үүргийг нэмэгдүүлэх нь зүйтэй гэх хандлага байдаг.<sup>13</sup> Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удирдаж явуулах шүүхийн үүрэг нь хууль зүйн хамгаалалтаар дамжуулж материаллаг тэгш байдлыг хангах болон социал төрийн үндсэн

<sup>10</sup> For comprehensive surveys cf. Dütz, Rechtsstaatlicher Gerichtsschutz im Privatrecht, 1970; Lorenz, Der grundrechtliche Anspruch auf effektiven Rechtsschutz, AöR 105 (1980), 623; Papier, §176: Justizgewähranspruch, in: Isensee/Kirchhof (Hrsg.), Handbuch des Staatsrechts, Bd. VIII, 3. Aufl., 2010, дам эшилсэн.

<sup>11</sup> Rosenberg/Schwab/Gottwald, Zivilprozessrecht, 17. Aufl. 2010, §3 Rn. 1 with further references, дам эшилсэн.

<sup>12</sup> BVerfGE 88, 118 (124); Maunz/Dürig/Grzeszick, Grundgesetz-Kommentar, 69, Ergänzungslieferung 2013, Art. 20 Rn. 134, BVerfGE 88, 118 (124), дам эшилсэн.

<sup>13</sup> Murray/Stürner, German Civil Justice (2004), pp. 166-177 with further references, дам эшилсэн.



хуулийн зарчмуудаас үүсэлтэй.<sup>14</sup> Цаашлаад ажиллагаа нь ердийн түвшинд шударга байх ёстой.<sup>15</sup> Тодруулбал, шүүх нь хэрэгт хөндлөнгийн, ашиг сонирхлын холбоогүй<sup>16</sup> бөгөөд талуудын тэгш эрхийг хангах шаардлагатай.<sup>17</sup> Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь бүхэлдээ шударга байх, тэгш эрхийг хангах, зөвлөх, туслах шинжтэй байх гэсэн зарчим, хандлага нь ХБНГУ-ын иргэний процесст иргэний шүүхэд мэдүүлэх эрхийг хангалттай түвшинд хэрэгжүүлэх үндэс суурь болж байна гэж дүгнэх боломжтой.

Япон Улсын Үндсэн хуулийн 32 дугаар зүйлд “Шүүхэд хандах хэний ч эрхийг үгүйсгэж/хориглож болохгүй” гэж заан, шүүхэд мэдүүлэх эрхийг баталгаажуулсан. Энэхүү эрх нь өөрийн үзэл бодлыг шүүхэд сонсгох, шүүхийн ажиллагаанд эсрэг талтайгаа тэгш эрхтэй оролцох, тохиромжтой цаг хугацааны дотор шүүхийн шийдвэрийг хүлээн авах болон шударга процесст оролцох зэрэгт хамаарна. Шүүхэд мэдүүлэх эрх нь хэн нэгний эрх болон үүргийг нөгөө этгээд эсэргүүцэхтэй холбогдсон бодит маргааныг холбогдох хуулиар бүрэн шийдвэрлэж байгаагаар баталгааждаг.<sup>18</sup>

ОХУ-ын Үндсэн хуулийн<sup>19</sup> 46 дугаар зүйлийн 46.1-д “Хүн бүр өөрийн эрх, эрх чөлөөг шүүхээр хамгаалуулах эрх баталгаажсан байна”, тус хуулийн 46.2-т “Төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн бус байгууллага ба албан тушаалтны шийдвэр, үйлдэл (эс үйлдэхүй)-тэй

<sup>14</sup> Gaier, Der moderne liberale Zivilprozess, NJW 2013, 2871 f, дам эшилсэн.

<sup>15</sup> BVerfGE 69, 381 (385 f.); 91, 176 (181); 101, 397 (404). For controversies about the extent of this constitutional fair trial guarantee cf. Rosenberg/Schwab/Gottwald (note 4), §1 Rn. 30, дам эшилсэн.

<sup>16</sup> BVerfGE 35, 263 (279); 52, 131(144), дам эшилсэн.

<sup>17</sup> 14 BVerfGE 14, 56 (69); 37, 57 (65), дам эшилсэн.

<sup>18</sup> National Report: Japan, the Right to Access to Justice and Public Responsibilities, by Tkuya Hatta, International Association of Procedural Law Seoul Conference, 2014, p.288.

<sup>19</sup> Конституция Российской Федерации (принята всенародным голосованием 12.12.1993). <https://legalacts.ru/doc/Konstitucija-RF/razdel-i/glava-2/statja-46> (дата обращения: 13.03.2021)

холбоотой гомдлыг шүүхэд гаргаж болно” гэж заасан байдаг ажээ. Түүнчлэн ОХУ дахь хүний эрхийг хамгаалах дотоодын механизм аливаа этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээж чадаагүй тохиолдолд тухайн этгээд ОХУ-ын олон улсын гэрээний дагуу эрхээ хамгаалуулахаар олон улсын байгууллагад хандах эрхтэй болохыг Үндсэн хуулийнхаа 46.3 дахь хэсэгт баталгаажуулжээ. Үндсэн хуулиар шүүх эрх мэдлийн бие даасан, хараат бус байдлыг баталгаажуулснаас гадна шүүгчид тавигдах хууль зүйн шаардлага, ардчиллын үнэт зүйлд тулгуурласан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчмууд, зөрчигдсөн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар шүүхэд хандах аливаа этгээдийн хууль зүйн мэргэжлийн туслалцаа авах хууль зүйн боломжийг баталгаажуулсан байна.<sup>20</sup> Аливаа этгээдээс шүүхэд мэдүүлэх эрхээ хэрэгжүүлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох дараалал, журмыг холбогдох процессын хуулиар зохицуулна. ОХУ-ын шүүхийн тогтолцооны онцлогтой холбоотойгоор иргэний эрх зүйн маргааныг иргэний хэргийн шүүх шийдвэрлэхээс гадна хуулийн этгээд, хувиараа бизнес эрхлэгчдийн аж ахуйн болон эдийн засгийн бусад үйл ажиллагаатай холбоотой иргэний эрх зүйн маргаан, дампуурал болон хуулиар харьяалуулсан захиргааны эрх зүйн маргааныг арбитрын дагнасан шүүх шийдвэрлэнэ. Иймд аливаа этгээдийн шүүхэд мэдүүлэх эрхийг хангахтай холбоотойгоор ОХУ-ын Арбитрын процессын кодексын<sup>21</sup> 4.1 дэх хэсэгт зааснаар аливаа этгээд зөрчигдсөн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар, мөн хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа болон шүүхийн шийдвэр биелүүлэх хугацааг зөрчсөнтэй холбоотойгоор учирсан хохирлоо нөхөн төлүүлэх шаардлагыг энэ хуульд

<sup>20</sup> С.М.Шахрай, А.А.Клишас, Конституционное право Российской Федерации, М., 2011, с. 245-246.

<sup>21</sup> Арбитражный процессуальный кодекс Российской Федерации, 24.07.2002, N. 95-ФЗ. [http://www.consultant.ru/document/cons\\_doc\\_LAW\\_37800](http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_37800) (дата обращения: 13.03.2021).

заасан журмын дагуу арбитрын шүүхэд мэдүүлэх эрхтэй. Мөн ОХУ-ын Иргэний процессын кодексын<sup>22</sup> 3.1 дэх хэсэгт заасны дагуу аливаа этгээд нь өөрийн зөрчигдсөн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлоо шүүхээр хамгаалуулах эрхийг тус тус процессын хуулиар баталгаажуулжээ.

Монгол Улсын ИХШХШтХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт зааснаар шүүхэд мэдүүлэх эрхийн хүрээнд иргэн, хуулийн этгээд нь эдийн болон эдийн бус баялагтай холбоотой эрх нь зөрчигдсөн буюу уг эрхээ сэргээлгэхээр, эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоолгохоор, захиргааны хэргийн шүүх харьяалан шийдвэрлэхээс бусад байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа болон тэдгээрийн гаргасан шийдвэрийг эс зөвшөөрч тус тус иргэний хэргийн шүүхэд хандах эрхтэй.

Иргэн, хуулийн этгээдээс шүүхэд мэдүүлэх эрхийг ямар хэлбэрээр хэрэгжүүлж байгаагаас хамааран шүүхэд хандахдаа хуулиар тогтоосон журмыг баримтлах шаардлагатай. Тухайлбал, ажилтны цалин хөлснөөс үндэслэлгүйгээр суутгал хийсэн гэж үзэн, ажил олгогчийн шийдвэрийг эс зөвшөөрч, шууд шүүхэд хандсан тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 63.4-т заасны дагуу ажилтан нь түүний цалин хөлснөөс суутгал хийх тухай шийдвэр буюу суутгалын хэмжээг эс зөвшөөрвөл гомдлоо хөдөлмөрийн маргаан таслах комисст гаргах зохицуулалттай. Энэ дагуу шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлүүлэх ажиллагааг хийж гүйцэтгэх хуулиар тогтоосон журмыг баримтлан шүүхээс гомдлыг хүлээн авахаас татгалзах үндэслэл бүрддэг. Иймд иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүхэд мэдүүлэх эрхийг хэрэгжүүлэх хэлбэр, түүний онцлогт үндэслэсэн ХХША-ны журмыг хуулиар тодорхойлдог.

<sup>22</sup> Гражданский процессуальный кодекс Российской Федерации, 14.11.2002, N. 138-ФЗ.  
[http://www.consultant.ru/document/cons\\_doc\\_LAW\\_39570](http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_39570) (дата обращения: 13.03.2021).

## 1.2. ШҮҮХЭД МЭДҮҮЛЭХ ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ ХЭЛБЭР

ИХШХШТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт аливаа этгээд нь өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар шүүхэд мэдүүлэх эрхээ нэхэмжлэл, гомдол, хүсэлт гаргах гэсэн гурван хэлбэрээр хэрэгжүүлэх боломжтойг тодорхойлсон. Тэдгээрийг тус бүрд нь авч үзвэл:

1. *Нэхэмжлэл*: ИХШХШТХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2-т заасны дагуу аливаа этгээд өөрийн эдийн болон эдийн бус баялагтай холбоотой эрх нь зөрчигдсэн тохиолдолд эсхүл бусдын эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг хамгаалж шүүхэд мэдүүлэх эрх нь хуулиар олгогдсон этгээдээс шүүхэд хандах тохиолдолд нэхэмжлэл гаргана.

Нэхэмжлэл гаргах хэлбэрээр шүүхэд мэдүүлэх эрхээ хэрэгжүүлж байгаа тохиолдолд ИХШХШТХ-ийн 61 дүгээр зүйлд заасан хэлбэрийн шаардлага, тус хуулийн 62, 63 дугаар зүйлд заасан нэхэмжлэлийн бүрдүүлбэр, нэхэмжлэлийн үнийг тодорхойлох зэрэг хуулиар тогтоосон журамд нийцүүлж нэхэмжлэлээ гаргах шаардлагатай. ИХШХШТХ-ийн 62 дугаар зүйлд “Нэхэмжлэлийн бүрдүүлбэр”-ийг хангаагүй буюу ИХШХШТХ-ийн 65 дугаар зүйлийн 65.11 дэх хэсэгт заасан үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан тохиолдолд тухайн захирамжийн үндэслэлийг эс зөвшөөрч, хуульд заасан үндэслэлээр дахин хянуулахаар гомдол гаргах эрхгүй байгаа нь иргэний хэрэг үүсгэх ажиллагаа дахь шүүхэд мэдүүлэх эрх хязгаарлагдах гол шалтгаан болж байна.

2. *Хүсэлт*: Эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдал, үйлдлийг тогтоолгох буюу ИХШХШТХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1.3-т заасны дагуу онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлүүлэхээр сонирхогч этгээдээс хүсэлт гаргана.

Шүүхэд хүсэлт гаргах тохиолдолд ИХШХШТХ-ийн 133-135 дугаар зүйлд заасныг үндэслэн эрх зүйн ач холбогдол бүхий ямар үйл явдал болон үйлдлийг тогтоолгохоор хүсэж байгаа хүсэлт, түүнд хавсарган нотлох баримтыг бүрдүүлнэ. Шүүхэд гаргасан хүсэлтийг хүлээн авахаас татгалзах хууль зүйн үндэслэлийг ИХШХШТХ-ийн 65 дугаар зүйл, 136 дугаар зүйлийн 136.4 дэх хэсэгт тус тус зохицуулсан. Шүүхийн практикт эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоолгох хүсэлтийг хүлээн авахаас татгалзах тохиолдолд ИХШХШТХ-ийн 136 дугаар зүйлийн 136.4 дэх хэсэгт заасан хүлээн авахаас татгалзах зохицуулалтыг удиртгал болгон хэрэглэж хэвшээгүй байгаа нь хууль хэрэглээний нэгдмэл бус байдлыг бий болгож байна.

3. Гомдол: ИХШХШТХ-ийн 156 дугаар зүйлийн 156.1.1, 156.1.3-т заасан шүүх, прокурор, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллага болон захиргааны хэргийн шүүх харьяалан шийдвэрлэхгүй байгууллага, аж ахуйн нэгж, тэдгээрийн албан тушаалтны шийдвэрийн улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзэж, зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр шүүхэд гомдол гаргана.

Гомдлоор авч хэлэлцэх хэргийн хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг ИХШХШТХ-ийн 156-160 дугаар зүйлд зохицуулсан. Шүүхэд мэдүүлэх эрхээ гомдол гаргах хэлбэрээр хэрэгжүүлж буй аливаа этгээд нь зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр шүүхэд хандаж буй тохиолдолд УТХ-ийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.5-д заасны дагуу тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгдөнө. Гомдлыг хүлээн авахаас татгалзах журмыг тусгайлан хуулиар зохицуулаагүй тул ИХШХШТХ-ийн 65 дугаар зүйлд заасан нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах журмыг баримтална.

ИХШХШТХ-ийн гуравдугаар зүйлд заасны дагуу аливаа этгээдээс зөрчигдсөн эрхээ хамгаалуулах, сэргээлгэх зорилгоор

нэхэмжлэл, гомдол болон хүсэлтийн аль нэгийг хуульд заасан шаардлагад нийцүүлэн, холбогдох баримтуудыг хавсарган шүүхийн мэдээлэл, лавлагааны ажилтанд хүлээлгэж өгнө. Шүүхийн мэдээлэл, лавлагааны ажилтан түүнийг хүлээн авч системд оруулснаар нэхэмжлэл нь тухайн шүүхийн аль нэг шүүгчид хуваарилагддаг. Хуваарилж авсан шүүгч долоо хоногийн хугацаанд (ИХШХШТХ-ийн 66.1) тухайн нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл байгаа эсэхийг шалгаад үндэслэл илрүүлбэл татгалзаж, илрэхгүй бол иргэний хэрэг үүсгэн ажиллагааг эхлүүлдэг.

Шүүгч нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл байгаа эсэхийг шалгаж, илрүүлэх долоо хоногийн хугацаанд нэхэмжлэгчтэй холбогдон, ямар арга хэмжээ авах талаар хууль тогтоомжоор тусгайлан зохицуулаагүй. Өөрөөр хэлбэл, нэхэмжлэлийг хянан шалгах дээрх хугацаанд тухайн нэхэмжлэл хуваарилагдаж очсон шүүгч нь л ямар ажиллагаа хийхийг шийдвэрлэдэг тул шүүхийн практик янз бүр тогтсон байна. Тухайлбал, аливаа этгээдээс гаргасан нэхэмжлэлийн шаардлага, үндэслэл тодорхойгүй тохиолдолд нэхэмжлэлийг хүлээн авснаас хойших нэг долоо хоногт багтаан шүүгч нэхэмжлэлийн шаардлага, үндэслэлийг тодруулах ажиллагааг хийж гүйцэтгэх бөгөөд тодруулах боломжгүй тохиолдолд нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах<sup>23</sup> байдлаар шийдвэрлэх практик байна. Нөгөө талаас, нэхэмжлэлийг хүлээн авснаас хойш нэг долоо хоногийн хугацаанд нэхэмжлэгчтэй утсаар холбогддоггүй, тэр ч байтугай холбогдох шаардлагагүй гэж үздэг, иргэний хэрэг үүсгэсэн эсэх талаарх мэдээллийг нэхэмжлэгчид өгдөггүй шүүхийн практик өргөн тархсан байна. Нэхэмжлэл хүлээн авснаас хойш нэг долоо хоногийн хугацаанд шүүгч нэхэмжлэлийн хэлбэрийн алдааг хэт явцуу хүрээнд, хуулийг өөр өөрөөр тайлбарлан, түүнийгээ үндэслэн

<sup>23</sup> Монгол Улсын Дээд шүүх, Шүүгчийн 2013 оны сургалтын гарын авлага: Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй, УБ., 2013, 13 дахь тал.

хүлээн авахаас татгалзсан тохиолдлууд цөөнгүй гарч байгаа нь иргэний хэрэг үүсгэх ажиллагаанд шүүхэд мэдүүлэх эрх бүрэн хэрэгжихгүй байх нөхцөл бүрдүүлж байна.

Шүүгчдийн Магна Харт (суурь зарчмууд)-ын 15 дугаар зүйлд шүүгчид нь хэрэг маргааныг түргэн шуурхай, үр дүнтэй, иргэдэд зохих боломж бололцоо олгосон байдлаар шийдвэрлэхээр<sup>24</sup> заасан байдаг. Түүнчлэн Европын шүүгчдийн зөвлөлдөх зөвлөгөөнөөс 2004 онд “Хэрэг маргааныг боломжит түргэн хугацаанд шийдвэрлэх, шүүхийн бус журмаар маргаан хянан шийдвэрлэхэд шүүгчийн гүйцэтгэх үүргийн асуудалд Европын зөвлөлийн сайд нарын хорооны анхаарлыг хандуулах тухай” зургаадугаар зөвлөмжийг баталсан. Тус зөвлөмжийн<sup>25</sup> 18-р зүйлд Европын шүүгчдийн зөвлөлдөх зөвлөл нь шүүхэд хэрэг үүсгэх, шүүхийн процессыг үргэлжлүүлэн явуулахад шаардагдах бичиг баримтын стандартыг хялбаршуулах, нэг стандартад оруулах явдлыг дэмжин сайшаах талаар дурдсан. Шүүхээр эрхээ хамгаалуулахаар хандаж буй аливаа этгээдээс гаргасан нэхэмжлэл, хүсэлт, гомдлыг шийдвэрлэх явцад илэрсэн зөрчлийг нэхэмжлэгчид мэдэгдэж, тодорхой хугацаанд зөрчлийг арилгуулах боломж бололцоо олгох талаар зохицуулалт хийх, шүүхээс хуулийг ялгаатай тайлбарлан хэрэглэж буй асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

Хууль хэрэглээний нэгдмэл байдлыг төлөвшүүлэхэд шүүхийн гүйцэтгэх үүргийн талаарх Европын шүүгчдийн зөвлөлдөх зөвлөлийн 2017 оны 20 дугаар зөвлөмжид<sup>26</sup> “Хууль хэрэглээний нэгдмэл байдал нь хүн бүр хуулийн өмнө тэгш байх зарчмын тулгуур бөгөөд шүүхийн шийдвэр өөр хоорондоо

<sup>24</sup> Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн хараат бус байдал: Олон улсын баримт бичиг, УБ., 2019, 13 дахь тал.

<sup>25</sup> Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн хараат бус байдал: Олон улсын баримт бичиг, УБ., 2019, 54 дэх тал.

<sup>26</sup> Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн хараат бус байдал: Олон улсын баримт бичиг, УБ., 2019, 258-259 дэх тал.



зөрчилтэй байснаар эрх зүйт ёсны үндсэн тулгуур нь болсон хууль зүйн тодорхой байдал алдагдах, улмаар шүүхэд итгэх иргэдийн итгэл сулрах аюултай. Хууль хэрэглээний нэгдмэл байдал нь шүүхэд итгэх олон нийтийн итгэл, шударга ёсны талаарх иргэдийн төсөөллийг бэхжүүлэх ач холбогдолтой” гэж тодорхой заажээ. Иргэн, хуулийн этгээдийн шүүхэд гаргасан нэхэмжлэл, гомдол, хүсэлтийг хүлээн авахаас татгалзах шийдвэр гаргахдаа зөвхөн хуульд заасан үндэслэлийг баримтлах, хуулийн заалтыг үндсэн агуулгаас нь өөрөөр тайлбарлаж хэрэглэхгүй байх, хүсэлт, гомдлоор авч хэлэлцэх хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны нийтлэг журмын дагуу хүлээн авахаас татгалзах тохиолдолд холбогдох хуулийн зохицуулалтыг хэрэглэх нь зүйтэй. Учир нь нэхэмжлэл хүлээн авахаас үндэслэлгүйгээр татгалзсан шийдвэрийн улмаас хууль хэрэглээний ялгаатай байдал бий болж, иргэдийн хувьд зөрчигдсөн эрхээ шүүхийн журмаар хамгаалуулах боломжгүй, цаг хугацааны болоод эдийн засгийн хувьд давхар хохирол амсахад хүргэж байна. Энэ нь өөрөө иргэн, хуулийн этгээдийн шүүхэд мэдүүлэх эрх зөрчигдөх үндэслэл болж байна.

Харьцуулсан эрх зүйн судалгааны хүрээнд ХБНГУ, Япон Улсын хууль тогтоомжуудад шүүхэд нэхэмжлэл гаргах замаар эрхээ хамгаалуулах зохицуулалтыг авч үзье.

ХБНГУ-ын иргэний шүүхийн шүүгчдэд хэргийн оролцогчдод тусламж үзүүлэх онцгой үүргийг хуулиар ногдуулсан байдаг. Энэ талаар онцгойлон тусгасан заалт нь Иргэний процессын хуулийн 139 дүгээр зүйл юм. Энэ нь ХБНГУ-ын иргэний процессын чухал үүрэг бөгөөд шүүх талуудад мэдэгдэх болон зөвлөх үүрэг хэрэгжүүлэхээр заасан. Иргэний хэргийг шүүхээс удирдах эрх мэдлийг хатуу үйлдэл болгон зааснаар процесст төвлөрөх, процессыг түргэсгэх, цаашилбал хэргийн үр дүн шүүгчээс шалтгаалах өндөр хариуцлага оногдуулан, хэргийг үр дүнтэй шийдвэрлэхэд шүүхээс түлхэц үзүүлдэг байна.



Мөн бичгээр гаргасан нэхэмжлэлийг процессын хуулиар шаарддаг ч аман хэлбэрийг зөвшөөрөх тохиолдол байдаг. Амаар нэхэмжлэл гаргахыг зөвшөөрөх зорилго нь боловсрол, туршлага багатай, хуульчаас үйлчилгээ авах боломжгүй хүмүүст маргаан үүсгэхэд нь туслахад чиглэнэ. Тиймээс амаар гаргасан нэхэмжлэл нь ихэвчлэн бага үнийн дүн бүхий маргаанд хүлээн зөвшөөрөгддөг. Тухайлбал, ХБНГУ-д нэхэмжлэгч шүүхийн захиргаан дээр очиж амаар гаргасан нэхэмжлэлийг шүүгчийн нарийн бичгийн дарга буулгаж, бичмэл нэхэмжлэл болгодог. Энэ нь Иргэний процессын хуулийн 495а-д “Шүүхийн тэгш хандах эрхийн хүрээнд гүйцэтгэх ажиллагаа” гэж тодорхой зохицуулагдсан байдаг. Тус зүйлд “600 еврогоос хэтрэхгүй үнийн дүнтэй нэхэмжлэлийн хувьд шүүхийн тэгш хандах эрхийн хүрээнд уг хэргийн шийдвэрлэх ажиллагааг хэрхэн хэрэгжүүлэхийг шүүхээс тодорхойлж болно. Амаар гаргасан шийдвэрлэх асуудлыг бичмэл нэхэмжлэлийн хуулийн шаардлагад нийцүүлнэ” гэж заасан нь иргэн шүүхэд хандах ажиллагааг хялбар болгож буйн нэг тод жишээ юм.

Шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удирдан чиглүүлж, хуульд заасан шаардлагыг хугацаа тогтоон талуудаар хангуулж, зөвхөн хэрэг маргаанаа тодорхойлон үндэслэл, нотлох баримтаа гаргахад талуудын анхаарлыг хандуулж байгаа нь шүүхийн ажиллагааг талуудад илүү хялбар болгон, маргааныг шуурхай шийдвэрлэх боломж бүрдүүлж байна. Учир нь талууд шүүхийн процессын ажиллагааг шүүгчээс илүү мэдэх боломжгүй тул түүний заавар, зөвлөгөөний дагуу оролцох нь хамгийн зохистой арга юм. Харин шүүгч процессыг удирдах, талуудад заавар зөвлөгөө өгөхдөө хөндлөнгийн, хараат бус, тэгш эрхийг ханган, шударга байх үүргээ чанд мөрдсөнөөр дээрх зохицуулалтууд үр дүнтэй хэрэгжих боломж бүрджээ.

## **ХОЁР. НЭХЭМЖЛЭЛ ХҮЛЭЭН АВАХААС ТАТГАЛЗАХ ЗОХИЦУУЛАЛТЫГ ХЭРЭГЛЭЖ БУЙ ШҮҮХИЙН ПРАКТИК**

### **2.1. НЭХЭМЖЛЭЛ ХҮЛЭЭН АВАХААС ТАТГАЛЗАХ ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ БА ШҮҮХИЙН ПРАКТИКИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

Шүүхэд мэдүүлэх эрхээ хэрэгжүүлэхээр иргэн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллагаас шүүхэд гаргасан нэхэмжлэл, хүсэлт, гомдлыг ИХШХШТХ-ийн 65 дугаар зүйлд заасан 11 үндэслэлээр<sup>27</sup> хүлээн авахаас татгалзана. Нийслэлийн Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул, Баянгол дүүргүүдийн иргэний хэргийн анхан шатны шүүхээс

<sup>27</sup> ИХШХШТХ-ийн 65-р зүйл. Шүүгч дараах тохиолдолд нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана. Үүнд:

- Хэргийн харьяалал зөрчсөн;
- Шүүхийн харьяалал зөрчсөн;
- Шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлүүлэх талаар хуульд заасан журмыг нэхэмжлэгч зөрчсөн ба энэ журмыг хэрэглэх боломжтой байвал;
- Нэхэмжлэгч нь эрх зүйн бүрэн чадамжгүй этгээд байвал;
- Нэхэмжлэгчийг төлөөлөх бүрэн эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан;
- Нэхэмжлэлд дурдсан үйл баримт, зохигчийн гэм буруугийн талаар хуулийн хүчин төгөлдөр шүүхийн болон арбитрын шийдвэр эсхүл нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан, түүнчлэн хэргийг хэрэгсэхгүй болгосон хуулийн хүчин төгөлдөр шүүхийн болон арбитрын шийдвэр буюу шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж байгаа;
- Зохигчийн маргаж байгаа зүйл ба түүний үндэслэлийн талаарх өөр хэргийг шүүх шийдвэрлэж байгаа;
- Уг нэхэмжлэлтэй холбоотой хэргийг эрүүгийн журмаар шалгаж байгаа;
- Хариуцагчийн хаяг тодорхойгүй;
- Зохигч болох хүн нас барсан, хуулийн этгээд татан буугдсан тохиолдолд маргаж байгаа шаардлага буюу маргаантай үүрэг нь эрх залгамжлагчид шилжээгүй;
- ИХШХШТХ-ийн 62 дугаар зүйлд заасан “Нэхэмжлэлийн бүрдүүлбэр”-ийн шаардлагыг хангаагүй байвал.

2019 онд гаргасан нэхэмжлэл хүлээн авахаас татгалзах тухай шүүгчийн захирамжуудын үндэслэлийг харьцуулж (График 4) үзвэл нэхэмжлэл хүлээн авахаас татгалзсан нийт захирамжийн 50-иас дээш хувийг ИХШХШТХ-ийн 65 дугаар зүйлийн 65.1.11-д заасныг үндэслэн тус хуулийн 62 дугаар зүйлд заасан “Нэхэмжлэлийн бүрдүүлбэрийн шаардлагыг хангаагүй” гэх үндэслэлээр хүлээн авахаас татгалзсан байна.



Нэхэмжлэл хүлээн авахаас татгалзсан үндэслэлийг График 4-т харуулсанчлан ИХШХШТХ-ийн 65 дугаар зүйлийн 65.1.11, 65.1.2, 65.1.5 болон бусад үндэслэл гэсэн дөрвөн бүлэгт хуваан, хууль зүйн үндэслэлтэй байдлыг хуулиар тогтоосон урьдчилсан нөхцөл хангасан эсэхэд тулгуурлан судалж, дараах дөрвөн дэд хэсэгт хуваан тус бүр судлаачдын дүгнэлт гаргасан болно. Үүнд:

1. “Нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангаагүй” үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан захирамжид хийсэн дүн шинжилгээ

Нийслэлийн дөрвөн дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхээс нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж буй хууль зүйн нийтлэг үндэслэлүүдийг харьцуулж үзвэл:



ИХШХШтХ-ийн 62 дугаар зүйлийн 62.3 дахь хэсэгт заасан “Нэхэмжлэлийг хариуцагчийн тоогоор хувилж өгнө”, мөн хуулийн 62.1.4-т заасан “Нэхэмжлэлийн үндэслэл, шаардлага, түүнийг нотлох баримт хавсаргаагүй” гэсэн үндэслэлээр

нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж буй нийтлэг тохиолдлууд, түүнд хийсэн хууль зүйн дүгнэлтийг Хүснэгт 1-д харуулав.

### **Хүснэгт 1. Нэхэмжлэлд холбогдох баримтыг хавсаргаагүй гэх үндэслэлээр гаргасан захирамж**

<b>Татгалзлын үндэслэл</b>	<b>Хууль зүйн дүгнэлт</b>
Нэхэмжлэлд холбогдох баримтыг хавсаргаагүй (ИХШХШТХ-ийн 62.1.4)	Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх (БЗДИХАШШ)-ийн 2019.01.29-ний өдрийн 2001 тоот захирамжаар “...Нэхэмжлэгч нь цалин хөлс гаргуулахаар хүссэн боловч нэхэмжлэлд хавсаргасан нотлох баримтаас харахад нэхэмжлэгч нь хариуцагч компанийн ажилтан мөн эсэх нь тодорхойгүй байна” гэж хүлээн авахаас татгалзсан. Шүүхийн 2019.05.02-ны өдрийн 7045 тоот захирамжаар “Нэхэмжлэгч Б нь нэхэмжлэлийн үндэслэлдээ Самсунг-4 маркийн гар утас, аккумулятор зэргийг худалдан борлуулсан гэх боловч ИХШХШТХ-ийн 44.2-т заасан нотлох баримтын шаардлага хангахгүй байна. Мөн 100,000 төгрөг зээлсэн нь баримтаар тогтоогдохгүй байна. Иймд нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэлтэй байна” гэжээ.

*Дүгнэлт:* Нэхэмжлэгчээс нэхэмжлэлд хавсарган хүргүүлж буй нотлох баримтууд нь ИХШХШТХ-ийн 44 дүгээр зүйлийн 44.2 дахь хэсэгт заасны дагуу нотлох баримтын шаардлага хангуулахыг шүүхээс шаардах эрхтэй. Харин шүүхээс нэхэмжлэлд бичигдсэн үйл явдлыг нотлох баримт хавсаргаагүй гэсэн үндэслэлээр нэхэмжлэл хүлээн авахаас татгалзаж байгаа нь хуульд үндэслэгдээгүй шийдвэр гэж үзнэ. ИХШХШТХ-ийн 62.1-д нэхэмжлэлийн агуулгад ямар мэдээлэл тусгах шаардлагатайг тодорхойлсон байдаг. Нэхэмжлэлийн шаардлага, түүний үндэслэлийг нотолж буй нотлох баримтыг нэхэмжлэл гаргахдаа заавал хавсаргах шаардлага хуулиар тавигдаагүй. Иргэний хэрэг үүсгэсний дараа ХХША-ны явцад ИХШХШТХ-ийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэг, 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэгт заасны дагуу нэхэмжлэгч нь нэхэмжлэлийн шаардлага, үндэслэлийг нотолсон баримт гаргаж өгөх боломжтой бөгөөд шүүхээс нэхэмжлэлд хавсаргасан баримтын хүрээнд хэргийг шийдвэрлэхгүй. Иймд нэхэмжлэлийн шаардлага, үндэслэлийг нотлох баримт хавсаргаагүй гэсэн үндэслэлээр хүлээн авахаас татгалзаж байгаа нь иргэний шүүхэд мэдүүлэх эрхийг зөрчиж байна.

Нэхэмжлэлд  
холбогдох  
баримтыг  
хавсаргаагүй  
(ИХШХШТХ-  
ийн 62.1.4, 62.1.6)

Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх (БГДИХАШШ)-ийн 2019.02.19-ний өдрийн 2296 дугаар шүүгчийн захирамжийн үндэслэх хэсэгт “ИХШХШТХ-ийн 62.1 дэх хэсэгт заасан шаардлагыг бүрэн хангаагүй байна. Нэхэмжлэгч нь хариуцагч Я, О нарт холбогдуулан ... төгрөг гаргуулах, уг үүргийг барьцаа хөрөнгөөр хангуулахаар нэхэмжлэл гаргасан бөгөөд нэхэмжлэлд хавсаргасан баримтаар зээлийн гэрээний үүрэгт барьцаалсан үл хөдлөх эд хөрөнгө нь Х-гийн өмчлөлийн эд хөрөнгө байна. Нэхэмжлэгч шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ нэхэмжлэлийн шаардлагыг хариуцагчаар бүрэн татах, нэхэмжлэлийг хариуцагчийн тоогоор хувилж ирэх шаардлагатай байх тул ИХШХШТХ-ийн 65.1.11-д заасны дагуу нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзав” гэжээ.

*Хүснэгт 1-ийн үргэлжлэл*

---

БГДИХАШШ-ийн 2019.04.11-ний өдрийн 4562 дугаар шүүгчийн захирамжийн үндэслэх хэсэгт “Нэхэмжлэлд компанийг төлөөлөн Б гарын үсэг зурсан байх ба монгол хэлээр бичигдсэн нэхэмжлэлийн үр дагаврыг ойлгосон эсэх, нэхэмжлэлд нэхэмжлэгчийн хүсэл зоригийг бүрэн илэрхийлсэн эсэхийг иргэний хэрэг үүсгэхээс өмнө шүүх тогтоох боломжгүй. ИХШХШТХ-ийн 7.2-т зааснаар “Э” ХХК-ийн захирал Б нэхэмжлэлийг өөрийн эх хэл буюу мэддэг хэлээр үйлдэж, монгол хэл рүү орчуулах, баталгаат орчуулгаар баталгаажсан байхыг мэдэгдэх нь зүйтэй. Иймд нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангаагүй үндэслэлээр хүлээн авахаас татгалзав” гэжээ.

---

БГДИХАШШ-ийн 2019.08.01-ний өдрийн 9571 дугаар захирамжийн үндэслэх хэсэгт “Хариуцагч хуулийн этгээдийн төлөөлөгч БНСУ-ын иргэн байх бөгөөд нэхэмжлэлийг хариуцагчийн тоогоор хувилж, орчуулга хийгдээгүй, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн итгэмжлэл хуулийн шаардлага хангаагүй, мөн нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангаагүй байх тул нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах нь зүйтэй байна” гэжээ.

---

*Дүгнэлт:* Нэхэмжлэгч хариуцагчийг өөрөө тодорхойлох иргэний процессын зарчмын хүрээнд нэхэмжлэлд “хариуцагчийг бүрэн татах” гэсэн шаардлага байхгүй. Гэтэл шүүхээс хуульд заагаагүй шаардлага “бий болгож” түүнийг хангаагүй гэх үндэслэлээр нэхэмжлэл хүлээн авахаас татгалзсан тохиолдлууд гарсан. Тодруулбал, нэхэмжлэгч хэнээс юуг шаардах вэ гэдгээ өөрөө тодорхойлох эрхтэй, шүүхээс түүнийг нь хязгаарлах, нөлөөлөх оролдлого хийхгүй буюу хөндлөнгийн байх гэдэг үндсэн зарчим алдагдсан байна.

---

Гадаадын иргэн эсхүл хуулийн этгээд нь нэхэмжлэл гаргах тохиолдолд өөрсдийн мэддэг хэлээр бичиж, монгол хэл рүү баталгаат орчуулагчаар хөрвүүлүүлэн шүүхэд гаргаснаар хүлээн авах боломж бүрдэнэ (ИХШХШТХ-ийн 7.2, 7.4). Харин Монгол Улсын иргэн эсхүл хуулийн этгээдээс Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй гадаад улсын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газар эсхүл гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, оршин суугаа гадаадын иргэнд холбогдуулан гаргаж буй нэхэмжлэлийг заавал тухайн хүний мэддэг хэл рүү нь баталгаат орчуулагчаар орчуулуулан өгөх үүрэг хүлээхгүй юм. Дээр дурдсан хуулийн заалтууд нь зөвхөн гадаад хэлээрх баримт бичгүүдийн хүрээнд хэрэглэгдэх тул монгол хэлээр гаргаж буй баримт бичгээ шүүхэд гаргахдаа орчуулж өгөөгүй гэх үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэсэн нь үндэслэлгүй байтал дээр нь шүүгч тухайн захирамжид гомдол гаргах эрхгүй талаар дурдсан байна. Эдгээр нь шүүгчийн мэдлэг, ур чадварын дутмаг байдлын үр дагавраар шүүхэд мэдүүлэх эрх зөрчигдөж байгаагийн жишээ болж байна.

Нэхэмжлэлийг хариуцагчийн тоогоор хувилж өгөөгүй (ИХШХШТХ-ийн 62.3)

Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх (ХУДИХАШШ)-ийн 2019.03.20-ны өдрийн 3446 дугаар захирамжаар “ИХШХШТХ-ийн 62.3-т нэхэмжлэлийг хариуцагчийн тоогоор хувилж өгнө гэж заасан байх бөгөөд нэхэмжлэгч тал нэхэмжлэлийн хувийг дутуу ирүүлсэн байна. Иймд ИХШХШТХ-ийн 65.1.11-д зааснаар нэхэмжлэгч нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангаагүй байх тул нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах нь зүйтэй” гэжээ.



*Хүснэгт 1-ийн үргэлжлэл*

---

ХУДИХАШШ-ийн 2019.08.27-ны өдрийн 9635 дугаар захирамжаар “ИХШХШТХ-ийн 3.1-д зааснаар хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзэж байгаа аливаа этгээд шүүхэд нэхэмжлэл гаргах хэлбэрээр мэдүүлэх эрхтэй боловч шүүхэд хандахдаа уг хуулийн 62 дугаар зүйлд заасан нэхэмжлэлийн бүрдүүлбэрийг хангаж өгнө. ИХШХШТХ-ийн 62.3-т зааснаар хариуцагчийн тоогоор хувилж өгнө гэж заажээ. Нэхэмжлэгч шүүхэд ирүүлсэн нэхэмжлэлээ хариуцагчийн тоогоор хэвлэн өгөх ёстой атал нэг хувь ирүүлсэн байна. ИХШХШТХ-ийн 65.1.11-д зааснаар нэхэмжлэлийн бүрдүүлбэрийг хангаагүй тул нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана” гэжээ.

---

*Дүгнэлт:* ИХШХШТХ-ийн 62 дугаар зүйлийн 62.3 дахь хэсэгт нэхэмжлэлийг хариуцагчийн тоогоор хувилж өгнө гэж заасныг зөрчсөнийг “нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангаагүй” гэсэн үндэслэлд хамааруулж, хүлээн авахаас татгалзах тохиолдол цөөнгүй гарсан. Хуулиар журамласан шаардлага боловч уг шалтгаанаар нэхэмжлэл хүлээн авахаас татгалзаж буй нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад засварлах боломжтой нөхцөл байдлыг үгүйсгэж, “хэлбэрийн төдий” шалтгаанаар аливаа этгээдийн шүүхэд мэдүүлэх эрхийг хязгаарлаж байна.

---

ИХШХШТХ-ийн 62 дугаар зүйлийн 62.1.4-т заасан “Нэхэмжлэлийн шаардлага, үндэслэл тодорхойгүй” гэсэн үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж буй нийтлэг тохиолдлууд, тэдгээрт хийсэн хууль зүйн дүгнэлтийг Хүснэгт 2-т нэгтгэн харуулав.

## Хүснэгт 2. Нэхэмжлэлийн шаардлага, үндэслэл тодорхойгүй гэх үндэслэлээр гаргасан захирамж

Нэхэмжлэлийн шаардлага, үндэслэл тодорхойгүй (62.1.4)	БЗДИХАШШ-ийн 2019.01.24-ний өдрийн 1757 тоот захирамжаар “...Нэхэмжлэгч нь хүүхэдтэйгээ хүссэн үедээ чөлөөтэй уулзах, тодорхой өдөрт уулзах гэсэн хоёр өөр төрлийн шаардлага гаргаж байгаа нь ойлгомжгүй болжээ. Нэхэмжлэлийн шаардлагыг тодруулах нь зүйтэй байх тул нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулахаар татгалзаж шийдвэрлэх нь үндэслэлтэй байна” гэж хүлээн авахаас татгалзсан.
---	--

*Дүгнэлт:* Нэхэмжлэлийн шаардлага, үндэслэл, түүнийг нотлох баримтын талаар нэхэмжлэлд тусгах шаардлагыг ИХШХШТХ-ийн 62.4-т зохицуулсан. Нэхэмжлэгч шүүхээс юу хүсэж байгаагаа өөрөө тодорхойлох эрхтэй буюу нэхэмжлэлийн шаардлагыг нэхэмжлэгч өөрөө тогтооно. Нэхэмжлэгч хүүхэдтэйгээ уулзахыг хүсэж байгаа учраас шүүхэд хандсан нь нэхэмжлэлийн шаардлагаас тодорхой харагдаж байна. Тодруулбал, нэхэмжлэлийн шаардлага нь хоёрдмол утгатай буюу нэг нэгнийгээ үгүйсгэсэн утгыг илэрхийлээгүй тул тодруулах боломжтой.

Аливаа этгээдээс шүүхэд мэдүүлэх эрхийн хүрээнд гаргасан нэхэмжлэлтэй холбоотойгоор хуваарилагдсан шүүгч нь долоо хоногийн дотор иргэний хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэхээр зохицуулсан. Иргэний хэрэг үүсгэх долоо хоногийн хугацаанд нэхэмжлэлийн үндэслэл, шаардлагыг тодруулахтай холбоотойгоор шүүхээс хийж гүйцэтгэх тодорхой ажиллагааг зохицуулаагүй учраас нэхэмжлэлийг хүлээн авснаас хойш долоо хоногийн дараа нэхэмжлэлийн үндэслэл, шаардлага “тодорхойгүй”, “ойлгомжгүй” байсан гэсэн үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж буй тохиолдол буурахгүй байна.

Нэхэмжлэлийн шаардлага, үндэслэл тодорхойгүй (62.1.4)	БЗДИХАШШ-ийн 2019.02.04-ний өдрийн 2375 тоот захирамжаар “Нэхэмжлэлд төлөгдөөгүй үндсэн зээл, хүү, алдангийн хамт 2,300,000₮ гаргуулахаар нэхэмжилсэн боловч уг мөнгөн дүнд үндсэн зээл, хүү, алданги тус бүрд хэдэн
---	--

төгрөг нэхэмжилж буй нь тодорхойгүй байна. Эдийн болон эдийн бус баялагтай холбоотой зохицуулалт тодорхой байх ёстой.

Нэхэмжлэлийн бүрдүүлбэр дутуу байх тул хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэв” гэжээ.

БЗДИХАШШ-ийн 2019.04.29-ний өдрийн 6717 тоот захирамжаар “...нэхэмжлэгч нь 2017.06.30-2019.04.30-ны өдрийг хүртэлх хугацаанд 906,000₮ нэхэмжилсэн байх бөгөөд уг төлбөрт ямар төлбөр орж байгаа, сар бүрийн задаргаа тодорхой байх шаардлагатай. Өөрөөр хэлбэл, нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл тодорхой бус байна. Иймд нэхэмжлэлийн шаардлага тодорхой бус буюу нэхэмжлэлийн бүрдүүлбэрт тавигдах шаардлагыг хангаагүй байх тул нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах нь зүйтэй” гэжээ.

БЗДИХАШШ-ийн 2019.06.03-ны өдрийн 9056 тоот захирамжаар “Нэхэмжлэгч сар бүр төлөх СӨХ-ийн төлбөрийн хэмжээг 47,547₮ гэж тодорхойлон, уг төлбөрийн задаргааг бичсэнээр засвар үйлчилгээ 11,000₮, цэвэрлэгээ 5,000₮, лифт 7000₮, хог 2500₮ гэсэн нь нэг сарын төлбөрийн хэмжээтэй тохирохгүй, түүнчлэн СӨХ-ны төлбөрийн хэмжээг тогтоосон Х хотхоны ТУЗ-ийн шийдвэрт лифт ашиглалтын төлбөрт 5,000₮ гэсэн атлаа нэхэмжлэлд 7,000₮-өөр тооцож нэхэмжилсэн зэргээс үзвэл нэхэмжлэлийн шаардлагыг тодруулах шаардлагатай байна.

Нэхэмжлэлийн шаардлага тодорхой бус гэж үзэн нэхэмжлэлийн бүрдүүлбэрт тавигдах шаардлагыг хангаагүй байх тул нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах нь зүйтэй” гэжээ.

БЗДИХАШШ-ийн 2019.08.19-ний өдрийн 12723 тоот захирамжаар “Нэхэмжлэлд хариуцагчийг зээлийн гэрээний үүргээ биелүүлээгүй гэж дурдсан байх боловч нэхэмжилж буй зээлийн дүн анх олгосон хэмжээнээс багассан байгаагаас үзэхэд тодорхой төлөлт хийгдсэн байхаар байна. Иймд хариуцагчийн зүгээс зээлийн гэрээний дагуу төлбөр төлсөн бол энэ талаар нэхэмжлэлд тусгах нь зүйтэй. ИХШХШТХ-ийн 62.1.4-т зааснаар энэ нь шүүхээс хэргийг хянан шийдвэрлэхэд нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд байх, хариуцагч талын зүгээс нэхэмжлэл, түүний үндэслэл шаардлагын дагуу мэтгэлцэх, шүүхийн шийдвэр тодорхой байх, ойлгомжтой, биелэгдэх боломжтой байх зэрэгтэй шууд холбоотой. ИХШХШТХ-ийн 65-р зүйл, тус хуулийн 62-р зүйлд заасан нэхэмжлэлд тавигдах шаардлагыг хангаагүй тохиолдолд нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзахаар заасныг баримтлан шийдвэрлэв” гэжээ.

*Дүгнэлт:* ИХШХШТХ-ийн 62 дугаар зүйлийн 62.1.4-т заасан нэхэмжлэлийн шаардлага гэдэгт тухайн үндэслэлд тулгуурлан нэхэмжлэгч шүүхээс юу хүсэж байгааг илэрхийлдэг.<sup>28</sup> Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж буй дээрх захирамжуудаас үзвэл нэхэмжлэгч нь хариуцагчаас тодорхой хэмжээний (шаардаж буй

<sup>28</sup> Монгол Улсын Дээд шүүхийн Иргэний хэргийн танхим, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар, УБ., 2014, 179 дэх тал.

мөнгөн дүн тодорхой) мөнгөн төлбөр гаргуулахаар шаардсан боловч шүүхээс “төлбөрийн задаргаа”, “тооцоолол байхгүй” гэсэн үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж байгаа нь шүүхэд мэдүүлэх эрхийг зөрчиж байна гэж үзэж байна. Зээлийн, СӨХ-ны, түрээсийн төлбөр гэх мэт мөнгөн төлбөр гаргуулах нэхэмжлэлийн хувьд нэхэмжлэгч нь хариуцагчаас шаардаж буй төлбөрийн хэмжээг тодорхойлсон тооцооллыг нэхэмжлэлд тусгахаар ИХШХШТХ-д зохицуулаагүй байна.

Нэхэмжлэлийн шаардлага, үндэслэл тодорхойгүй (62.1.4)

БЗДИХАШШ-ийн 2019.03.12-ны өдрийн 3924 тоот захирамжаар “Нэхэмжлэгчийн ажиллаж байсан байдал тогтоолгох хүсэлтээс үзэхэд нэхэмжлэгч ямар эрх зөрчигдсөн гэж үзэж, ямар үндэслэлээр шүүхээр ажилласан жилээ зайлшгүй тогтоолгохоор хандаж байгаа үндэслэл тодорхойгүй байна.

ИХШХШТХ 62.1-ийг хангахгүй байна. Иймд 65.1.11-д заасан үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан” гэжээ.

*Дүгнэлт:* Ажилласан жил тогтоох буюу ажиллаж байсан байдлыг тогтоох хүсэлтийг ИХШХШТХ-ийн 135.2.6-д заасны дагуу онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэнэ. Хүсэлт нь иргэнд холбогдох эрх зүйн ач холбогдол бүхий байдлыг тогтооход чиглэж байгаа тул хуулиар хамгаалсан эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн байхыг шаардахгүй. Хүсэлт гаргагчаас зөрчигдсөн эрх, түүний үндэслэлийг тодруулах шаардлагатай гэж үзэж, хүсэлтийг хүлээн авахаас татгалзсан нь үндэслэлгүй байна. Мөн хууль хэрэглээний хувьд эрх зүйн ач холбогдол бүхий хүсэлтийг хүлээн авахаас татгалзахдаа ИХШХШТХ-ийн 65.1.11-д заасан журмыг баримтлахаас гадна хүсэлтийг хүлээн авахаас татгалзах ИХШХШТХ-ийн 136.3, 136.4-т заасныг үндэслэх шаардлагатай.

Нэхэмжлэлийн шаардлага, үндэслэл тодорхойгүй (62.1.4)

БЗДИХАШШ-ийн 2019.06.10-ны өдрийн 9408 тоот захирамжаар “Нэхэмжлэгч шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ барилгын материалын үлдэгдэл төлбөрт 926,320₮, 976,320₮ гэж 50,000-ын зөрүүтэй бичсэн байгаа тул нэхэмжлэлийн шаардлагыг тодруулах нь зүйтэй. ИХШХШТХ-ийн 62.1.4-т зааснаар нэхэмжлэлийн үндэслэл, шаардлага тодорхой байх ёстой. Нэхэмжлэлийн шаардлага тодорхой бус, нэхэмжлэлийн бүрдүүлбэрт тавигдах шаардлагыг хангаагүй байх тул нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах нь зүйтэй” гэжээ.

*Дүгнэлт.* Нэхэмжлэгчийн шүүхэд гаргасан нэхэмжлэлийн агуулгаас үзвэл хэлбэрийн төдий алдаа буюу мөнгөн дүнгийн хувьд зөрүүтэй бичигдсэн бичиглэлийг үндэслэж, нэхэмжлэлийн шаардлага, түүний үндэслэл тодорхойгүй гэж татгалзаж байгаа нь “ялимгүй алдаа”-нд үндэслэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тодруулах боломжтой нөхцөлийг харгалзан үзээгүй байна. Энэ нь нэхэмжлэгч дахин нэхэмжлэл гаргаж цаг хугацаа алдахаас гадна УТХ-ийн төлбөр дахин төлөх зэргээр зардал нэмэгдэх үр дагавар бий болгож байна.

Нэхэмжлэлийн шаардлага, үндэслэл тодорхойгүй (ИХШХШТХ-ийн 62.1.4)

БГДИХАШШ-ийн 2019.03.12-ны өдрийн 3213 дугаартай захирамжийн үндэслэх хэсэгт “Баянгол дүүргийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсийн шүүхэд гаргасан хүсэлт нь ИХШХШТХ-ийн 62-р зүйлд заасан бүрдүүлбэр хангаагүй, нэхэмжлэлийн шаардлага, үндэслэл тодорхойгүй байх тул хүлээн авахаас татгалзах нь зүйтэй байна” гэжээ.

*Хүснэгт 2-ын үргэлжлэл*

---

БГДИХАШШ-ийн 2019.07.02-ны өдрийн 8621 дугаар захирамжийн үндэслэх хэсэгт “Нэхэмжлэгч нь дээрх хугацааны СӨХ-ийн дундын өмчийн засвар үйлчилгээний төлбөрийг нэгтгэн тодорхойлж хариуцагчаас гаргуулахаар шаардсан байгаа нь нэхэмжлэлийн шаардлага ойлгомжтой бөгөөд тодорхой байх хуулийн шаардлагыг хангаагүй. Оршин суугч нэг сард хэчнээн төгрөгийн хураамж төлөх үүрэгтэй, бүгд хэдэн сарын төлбөр төлөгдөөгүй, тэдгээр нь он тус бүрдээ хэдэн төгрөгийн төлбөр төлөх нь тодорхойгүй байна. ИХШХШТХ-ийн 62.1-д заасан нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангагдаагүй гэж үзэх нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах нь зүйтэй” гэжээ.

БГДИХАШШ-ийн 2019.10.03-ны өдрийн 12324 дугаартай захирамжийн үндэслэх хэсэгт “Хүсэлт гарагч У-гийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Д нь О-г эрэн сурвалжлуулах хүсэлт гаргажээ. Хариуцагчид холбогдуулан хүсэлт гаргагч зөрчигдсөн эрхээ сэргээн хамгаалуулахаар шүүхэд мэдүүлэх эрхээ хэрэгжүүлсэн эсэх нь тодорхойгүй байна. Иргэний эрх зүйн маргаанд хариуцагчаар оролцвол зохих этгээдийг эрэн сурвалжлах нь уг этгээдийг улс орон даяар эрэн сурвалжлах, нийтэд зарлах зэргээр Үндсэн хууль болон бусад хуулиар хамгаалагдсан хууль ёсны ашиг

---

сонирхлыг хөндөх үр дагавартай тул дээр дурдсан нөхцөл байдлыг зайлшгүй тодруулах нь зүйтэй. Иймд эрэн сурвалжлуулах гэж буй иргэний эрх зүйн харилцаанд оролцвол зохих этгээд мөн эсэхийг дахин тодруулах, мөн түүний байгаа газрыг тодруулах талаар өөрийн боломжтой ямар арга хэмжээ авсныг ирүүлээгүй тул хүлээн авахаас татгалзах нь зүйтэй” гэжээ.

БГДИХАШШ-ийн 2019.12.13-ны өдрийн 16069 дугаартай захирамжийн үндэслэх хэсэгт “Нэхэмжлэгч нь нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлдээ орон тоог үндэслэлгүй цомхотгосон, шинээр бий болсон ахлахын ажлын байранд шилжүүлэх боломж байсан гэж тайлбарласан байх ба нэхэмжлэлийн шаардлагаа зохих орон тооны ажилд эгүүлэн томилж өгнө үү гэжээ. ИХШХШТХ-ийн 62.1.4 дэх хэсэгт нэхэмжлэлийн үндэслэл, шаардлага, түүнийг нотолсон баримтыг тодорхой тусгасан байхыг шаарддаг. Нэхэмжлэгчийн шүүхэд гаргасан нэхэмжлэлээс үзвэл орон тоог цомхотгосон, ажлаас халсан, өөр ажлын байранд шилжүүлээгүйн алинд гомдолтой байгаа болон ямар ажлын байранд томилуулахаар нэхэмжлэлийн шаардлага гаргаж байгаа нь ойлгомжгүй, тодорхойгүй байх тул нэхэмжлэлийг ИХШХШТХ-ийн 62.1.4-т заасан нэхэмжлэлийн бүрдүүлбэрийг хангаагүй гэж үзэх үндэслэлтэй байна” гэжээ.



*Дүгнэлт:* Шүүхээс эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоолгох хүсэлтийг “зорилго тодорхойлоогүй” гэсэн үндэслэлээр хүлээн авахаас татгалзаж буй нь ИХШХШТХ-ийн 136.2-т заасан шаардлагад нийцэж байна. Гэвч шүүхээс зарим тохиолдолд нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж буй үндэслэлээ огт тайлбарлахгүй, зөвхөн хуулийн заалтууд бичээд нийцэхгүй байх тул гэж татгалзаж буй дутагдал ажиглагдсан. Нэхэмжлэлийг шүүхээс ямар үндэслэлээр хүлээн авах боломжгүй байгааг зарим шүүгчийн захирамжид тодорхой дурдсан ч заримд нь дурдаагүй нь нэхэмжлэгч ямар алдаа гаргаснаа мэдэх боломжгүй нөхцөл бүрдүүлсэн байна. Мөн нэхэмжлэлийн шаардлагаар хэдэн төгрөг, ямар үндэслэлээр нэхэмжилж байгаа нь ойлгомжтой байхад “нарийвчлан задалж оруулаагүйгээс ойлгомжгүй байна” гэх үндэслэлээр цөөнгүй нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзжээ. Нэхэмжлэлд зайлшгүй тусгах зүйлийг ИХШХШТХ-ийн 62 дугаар зүйлд заасан бөгөөд нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангагдсан эсэхийг нэхэмжлэлийг хүлээн авахдаа шалгаж байх нь чухал юм. Гэхдээ нэхэмжлэлийн бүрдүүлбэрт мөн хуулийн 62.1-д заасан нөхцөл хамаардаг учир нэхэмжлэлийн агуулга, улмаар шаардлага үндэслэлтэй эсэх талаар нэхэмжлэлийг хүлээн авахдаа мөн иргэний хэрэг үүсгэхдээ дүгнэлт хийх нь ИХШХШТХ-ийн 115-118 дугаар зүйлд нийцэхгүй гэдгийг анхаарвал зохино.<sup>29</sup>

Нэхэмжлэлийн  
шаардлага  
тодорхойгүй  
(ИХШХШТХ-ийн  
62.1.4)

ХУДИХАШШ-ийн 2019.01.02-ны өдрийн 354 дугаартай захирамжаар “СӨХ-ийн нэхэмжлэлийн шаардлага тодорхойгүй, байранд үзлэг шалгалт явуулж хариуцлага тооцох гэсэн нь ойлгомжгүй байна. Барилгад илэрсэн ямар зөрчлийг арилгах гэсэн нь тодорхойгүй байна. Мөн ИХШХШТХ-ийн 62.1.3-т заасны дагуу хариуцагч тодорхойгүй байна. “М” ХХК гэсэн байх боловч үндэслэлд “П” ХХК ашиглалтад оруулсан учраас доголдол хариуцах ёстой гэж тодорхойлсон байна” гэжээ.

<sup>29</sup> Монгол Улсын Дээд шүүхийн Зөвлөмж, Нэхэмжлэлийн үндэслэл, шаардлагыг тодорхойлоход анхаарах зарим асуудал, 2016.02.01, №1. <http://www.supremecourt.mn/act/view/184> 2021.04.15-ны өдөр мэдээлэл авав.

*Дүгнэлт:* Нэхэмжлэлийн шаардлага буюу шүүхээс юу хүсэж байгаа, түүний үндэслэл, бодитой үүссэн нөхцөл байдлыг нэхэмжлэлд тодорхой тусгах шаардлагатай. Шүүхээс нэхэмжлэгчийн шаардлага, үндэслэлд тулгуурлан талуудын хооронд үүссэн эрх зүйн харилцааг тодорхойлсноор ХХША-ны заасан журмыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ. Иймд нэхэмжлэгч юу хүсэж байгаа, ямар учраас түүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөж буйг тодорхойлох бодит нөхцөлийг нэхэмжлэлд дурдах зайлшгүй шаардлагатай. Иймд нэхэмжлэлийн шаардлага нь хоёрдмол утгатай, агуулгын хувьд ойлгомжгүй нөхцөлд нэхэмжлэл хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэх бөгөөд шүүхээс нэхэмжлэлийн шаардлага, үндэслэлийг тодруулах хугацаа тогтоосон ажиллагаа байхгүй байгаа нь нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах зохицуулалтыг хэрэглэж, шүүхэд дахин дахин хандах сөрөг үр дагавар бий болгож байна.

<p>Нэхэмжлэлийн шаардлага, үндэслэл тодорхойгүй (ИХШХШТХ-ийн 62.1.4)</p>	<p>СХДИХАШШ-ийн 2019.01.21-ний өдрийн 1156 дугаартай захирамжийн үндэслэх хэсэгт ““Б” ХХК-ийн шүүхэд гаргасан нэхэмжлэл нь ИХШХШТХ-д заасан нэхэмжлэлийн бүрдүүлбэрийн шаардлагыг хангаагүй байх тул нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл болж байна. Тодруулбал, ИХШХШТХ-ийн 62.1.4-т нэхэмжлэлийн үндэслэл шаардлага, түүнийг нотлох баримтыг нэхэмжлэлд тусгана гэж зааснаар хариуцагчаар оролцвол зохих этгээд Д-г эрэн сурвалжлуулах болсон үндэслэл, шаардлага тодорхойгүй. Д нь хариуцагчаар оролцвол зохих этгээд мөн эсэх нь эргэлзээтэй байна” гэжээ. СХДИХАШШ-ийн 2019.02.01-ний өдрийн 1643 дугаартай захирамжийн үндэслэх хэсэгт “Нэхэмжлэгч нь сэтгэл санааны болон 10 жил ажилласан хөдөлмөрийн</p>
--	--

хөлс болох 14,200,000 төгрөгийн хохирол, өмчлөлийн бусад эд хөрөнгийг хуулийн дагуу барагдуулж шийдвэрлэж өгнө үү гэж нэхэмжлэлийн шаардлагаа тодорхойлсон нь ойлгомжгүй байна. Сэтгэл санааны хохиролд хэдэн төгрөг, 10 жил ажилласан хөдөлмөрийн хөлсөнд хэдэн төгрөг тус тус нэхэмжилж байгаа, дундын өмчлөлийн ямар эд хөрөнгөөс өөрт ногдох хэсгийг гаргуулахаар нэхэмжлэлийн шаардлага гаргаж байгаа нь тодорхойгүй байна” гэжээ.

СХДИХАШШ-ийн 2019.02.01-ний өдрийн 1676 дугаартай захирамжийн үндэслэх хэсэгт “Нэхэмжлэл нь ИХШХШТХ-ийн 65.1.5-д “нэхэмжлэгчийг төлөөлөх бүрэн эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан”, 65.1.11-д “энэ хуулийн 62 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй байвал” гэж заасан шаардлагыг хангаагүй байх тул нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах нь зүйтэй. Тодруулбал, нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл болох ажил гүйцэтгэх гэрээ нь "С" ХХК болон "Г" ХХК-ийн хооронд байгуулагдсан, нэхэмжлэгч Т нь нэхэмжлэлд "Г" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрмийг хавсаргасан байна. ИХШХШТХ-ийн 26.2-т заасны дагуу Т нь нэхэмжлэл гаргах эрх бүхий этгээд болох нь тогтоогдохгүй байна. Учир нь иргэн эсхүл хуулийн этгээдийн хэн нь нэхэмжлэл гаргаж байгаа нь эргэлзээтэй тул нэхэмжлэлийн үндэслэл шаардлага тодорхойгүй, нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангагдаагүй байна” гэжээ.

*Дүгнэлт:* ИХШХШТХ-ийн 62 дугаар зүйлд нэхэмжлэлд заавал тусгах асуудлуудыг жагсаасан бөгөөд нэхэмжлэлд түүний үндэслэл, шаардлагыг тусгахаар заасан. Нэхэмжлэлийн үндэслэл, шаардлага нь хоёр өөр ойлголт юм. Нэхэмжлэлийн үндэслэл гэдэг нь нэхэмжлэгч шүүхэд хандах болсон бодит нөхцөл ба түүний шаардлага ямар учир шалтгаантай болохыг нэхэмжлэгчийн зүгээс тодорхойлсон байдал юм.

Шаардлага нь нэхэмжлэгч шүүхээс юу хүсэж байгааг илэрхийлдэг.<sup>30</sup> Нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлага болон үндэслэлээ л тусгах ёстой. Гэвч шүүхээс “тодорхойгүй” гэдэг үндэслэлээр хавтгайруулан татгалзах явдал бий болсон байна. Тухайлбал, иргэн нэхэмжлэлдээ хэнээс, юуг, яагаад буюу ямар шалтгаанаар гаргуулж байгаагаа л тайлбарлахад хангалттай байхад шүүхээс иргэний хэрэг үүсгэх шатанд “тодорхойгүй байна” гээд хүлээн авахгүй тохиолдлууд цөөнгүй гарсан байна. Тодорхойгүй асуудлуудыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тодруулах, мөн шүүх хуралдаан дээр шүүгч тодруулах замаар асуух боломж бий. Гэтэл шүүх нэхэмжлэгч иргэнээс “мэргэжлийн түвшний” агуулгатай, тодорхой нэхэмжлэл гаргаж тавихыг шаардаж байгаа нь энгийн иргэн шүүхэд хандах эрхээ хэрэгжүүлэхэд хүндрэлтэй болгож байна. Тухайлбал, өөрийгөө нэхэмжлэгч гэж тодорхойлоод нэхэмжлэл гаргаж өгсөн байхад баримтуудаар та нэхэмжлэгч мөн эсэх нь эргэлзээтэй байна гэж эсхүл юу шаардаж байгаагаа бичсээр байхад илүү тодорхой болго гэх мэтээр “хуульд байхгүй” шаардлагуудыг тавьж хүлээн авахаас татгалзсан тохиолдлууд гарсан байна. Энэ нь шүүхэд мэдүүлэх эрхийг хангах үзүүлэлтүүдийн нэг болох процессын ажиллагааг хүндрэл төвөггүй, ойлгомжтой, тодорхой болгож, маргааныг шийдвэрлэхэд төвлөрөх бус, зөрчигдсөн эрхээ хамгаалуулж, сэргээлгэх гэж буй иргэнд процессын “дааж давшгүй, ойлгомжгүй” шаардлагууд тавьж нэхэмжлэлийг нь хүлээж авахгүй буцаан, шүүхэд дахин дахин ирж очих зардлыг нэмэгдүүлж, хугацаа алдах сөрөг үр дагавруудыг бий болгож байна.

<sup>30</sup> Монгол Улсын Дээд шүүх, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар, 2014, 178 дахь тал.

ИХШХШТХ-ийн 62 дугаар зүйлийн 62.3 дахь хэсэгт заасан “Нэхэмжлэлд улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт эсхүл уг хураамжаас чөлөөлүүлэх тухай хүсэлт, хэрэв нэхэмжлэлийг төлөөлөгч гаргасан бол итгэмжлэлийг мөн хавсаргана” гэж заасны дагуу улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримтыг хавсаргаагүй гэсэн үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж буй нийтлэг тохиолдлууд, түүнд хийсэн хууль зүйн дүгнэлтийг Хүснэгт 3-т харуулав.

### **Хүснэгт 3. УТХ төлөөгүй эсхүл дутуу төлсөн гэх үндэслэлээр гаргасан захирамж**

---

Улсын тэмдэгтийн хураамж төлөөгүй эсхүл дутуу төлсөн (ИХШХШТХ-ийн 62.2)	БЗДИХАШШ-ийн 2019.01.28-ны өдрийн 1906 тоот захирамжаар “...ИХШХШТХ 63.1.1, УТХ-ийн хураамжийн тухай хуулийн 7.1.7-д зааснаар нэхэмжлэгч нь 35,012₮ дутуу төлсөн байна. Иймд УТХ төлөөгүй тул нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангаагүй үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан” гэжээ. БЗДИХАШШ-ийн 2019.01.25-ны өдрийн 1889 тоот захирамжаар “Нэхэмжлэгч 2018.11.19-ний өдөр Баянзүрх дүүргийн УТХ төлөх дансанд хураамж төлсөн баримт хавсаргасан. Тус мөнгийг улсын орлогоос буцаан аваагүй талаар тодорхойлолтыг хавсарган ирүүлсэн нь УТХ-ийг зохих ёсоор төлсөн гэж үзэхгүй. Тус УТХ төлсөн баримтыг ямар шалтгааны улмаас 2018 оны 10 дугаар сард буюу нэхэмжлэл гаргахаас 90 хоногийн өмнө төлсөн нь тус нэхэмжлэлд зориулан өмнө нь шүүхэд нэхэмжлэл гарган төлж байсан нь тодорхойгүй, энэ талаарх баримтгүй байна. Иймд ИХШХШТХ 57.1, 62.2-т зааснаар УТХ-ийг зохих ёсоор шинээр төлж, шүүхэд ирүүлэх шаардлагатай тул нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзав” гэжээ.
---	---

---

*Дүгнэлт:* ИХШХШТХ-ийн 62 дугаар зүйлийн 62.2 дахь хэсэгт улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт эсхүл УТХ-аас чөлөөлүүлэх тухай хүсэлтийг холбогдох баримтын хамт нэхэмжлэлд хавсаргахаар заасан. Нэхэмжлэгч нэхэмжлэлийн үнийг дүнг буруу тодорхойлсон юм уу зарим тохиолдолд хэрхэн яаж тодорхойлох мэдээлэлгүйн улмаас УТХ-ийг дутуу төлөх, төлөхгүй байх тохиолдлууд нь нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл болж байна. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд УТХ-ийг нөхөн төлүүлэх, нэхэмжлэлийн бүрдүүлбэрийг хангуулахаар нэхэмжлэгчид хугацаа олгох зохицуулалт байхгүй байна. Энэ нь УТХ-ийг дутуу төлсөн тохиолдолд дахин эхнээсээ шүүхэд нэхэмжлэл гаргах давхар ажиллагаа хийж гүйцэтгэх сөрөг үр дагавар үүсгэж байна.

Улсын  
тэмдэгтийн  
хураамж  
төлөөгүй,  
дутуу төлсөн  
(ИХШХШТХ  
62.2)

БГДИХАШШ-ийн 2019.03.18-ны өдрийн 3406 дугаартай захирамжийн үндэслэх хэсэгт “Нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангаагүй, хуульд заасан хэмжээгээр улсын тэмдэгтийн хураамж төлөөгүй байх тул 2019.02.19-ний өдрийн 19,900 төгрөгийг 2019.02.28-ны өдрийн захирамжаар буцаан олгохоор шийдвэрлэсэн байхад уг баримтаа хавсаргаж өгсөн нь буруу болжээ” гэжээ.

БГДИХАШШ-ийн 2019.04.09-ний өдрийн 4511 дугаартай шүүгчийн захирамжийн үндэслэх хэсэгт “Нэхэмжлэл нь ИХШХШТХ-ийн 62.2 дахь хэсэгт заасан нэхэмжлэлийн бүрдүүлбэрийг биелүүлээгүй байна. Нэхэмжлэгч нь тус хуулийн 63.1.3-т зааснаар нэхэмжлэлийн үнийг тодорхойлж улсын тэмдэгтийн хураамж төлөх үүрэгтэй. Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур гэсэн үндэслэлээр УТХ-аас чөлөөлүүлэх хүсэлт ирүүлсэн боловч холбогдох баримтыг ирүүлээгүй байна. Иймд УТХ төлөөгүй гэж үзэж, 65.1.11-д зааснаар нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзав” гэжээ.

Хүснэгт 3-ын үргэлжлэл

БГДИХАШШ-ийн 2019.11.01-ний өдрийн 13850 дугаартай захирамжийн үндэслэх хэсэгт “ИХШХШТХ-ийн 63.1.3 дахь хэсэгт бие даасан хэд хэдэн шаардлагыг нэг нэхэмжлэлд бичсэн бол бүх шаардлагын үнийн нийлбэрээр нэхэмжлэлийн үнийн дүнг тодорхойлохоор заасан байна. Гэтэл “А” ХХК нь нэхэмжлэлийн нэг шаардлагад ногдох улсын тэмдэгтийн хураамж төлж, нэхэмжлэлийн хоёр дахь шаардлага болох үүргийн гүйцэтгэлийг барьцаа хөрөнгөөр хангуулах нэхэмжлэлийн шаардлагад улсын тэмдэгтийн хураамж төлөөгүй байна. Нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангаагүй байх тул 65.1.11-д заасан үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах нь зүйтэй” гэжээ.

*Дүгнэлт:* УТХ огт төлөгдөөгүй эсхүл дутуу төлөгдсөн байх нь ИХШХШТХ-ийн 65, 163, 164, 173 дугаар зүйлд заасан үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах, давж заалдах болон хяналтын гомдлыг хүлээн авахгүй байх нөхцөл болохыг анхаарвал зохино.<sup>31</sup> Шүүхэд нэхэмжлэл гаргахдаа шүүхийн зардлыг урьдчилан төлсөн байх нь зайлшгүй тавигдах шаардлагуудын нэг юм. Гэхдээ төлбөрийн чадваргүйн улмаас УТХ-аас чөлөөлүүлэх боломжийг ИХШХШТХ-ийн 58.3-т зохицуулж, холбогдох баримтыг хавсаргаж ирүүлэхээр заасан. Нэхэмжлэгч УТХ-аас чөлөөлүүлэх хүсэлтээ гаргасан ч хангалттай баримтаар нотлоогүй тохиолдолд холбогдох баримтуудыг хавсаргаж ирүүлэх талаар зарим шүүгчийн захирамжид ерөнхий, тодорхойгүй тусгаж байна. Хэрэв шүүхээс нэхэмжлэгчийн хавсаргаж ирүүлсэн баримтыг хангалтгүй гэж үзэж байгаа бол хаанаас, ямар бичиг баримтуудыг гаргаж ирүүлэх ёстойг тодорхой дурдах нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чухал зорилгуудын нэг бөгөөд агуулгын хувьд ч ИХШХШТХ-ийн 65.2-т хамаарах юм.

<sup>31</sup> Монгол Улсын Дээд шүүхийн Зөвлөмж, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь улсын тэмдэгтийн хураамжийн асуудал, №4, 2012.12.24. <http://www.supremecourt.mn/act/view/61> 2021.04.15-ны өдөр мэдээлэл авав.

Үүнээс гадна ИХШХШТХ-ийн 65 дугаар зүйлд заасан бусад үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж буй тохиолдолд “төлбөрийн баримт”-ыг дахин ашиглах боломжгүй, “дахин шинээр төлөх” шаардлага нь иргэдэд цаг хугацаа алдах, зардал чирэгдэл болох нөхцөл бүрдүүлж байна.

Нэхэмжлэл гаргаж буй хугацаа, төлбөр төлсөн хугацаа зөрөх, хураамжийн талаар гарсан хүчин төгөлдөр эрхийн актын заалт биелэгдэхгүй байх зэрэг сөрөг үр дагавар гарах магадлалтай тул зүй нь нэхэмжлэгч хураамжийн төлбөрийг шинээр төлөх ёстой ба түрүүчийн хураамжийг буцаан авах эсэх нь түүний эрхийн асуудал юм. Гэвч хэргийн онцлог эсхүл нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах, дахин нэхэмжлэл гаргах хоёр үйл явдлын хооронд богино хугацаа өнгөрсөн байх, хураамжийн хэмжээ их байх зэрэг шалтгаанаар нэхэмжлэгчийн дээрх ажиллагааг шүүх зөвшөөрч байгаа тохиолдолд УТХ-ийг буцаасан шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолын заалтыг хэрхэх талаар шүүхийн шийдвэрт заах шаардлагатай.<sup>32</sup> Гэвч судалгааны явцад шүүгчийн захирамжид хугацаа тогтоож, тогтоосон хугацаанд нэхэмжлэлийн алдаагаа засаж нэхэмжлэлээ дахин гаргах бол хуучин баримтаа ашиглаж болох талаар дурдсан нэг ч захирамж гараагүй байна. Энэ нь хуульд тухайлан заасан зохицуулалт байхгүйтэй холбоотой байж болох юм.

Улсын  
тэмдэгтийн  
хураамж  
төлөөгүй,  
дутуу төлсөн  
(ИХШХШТХ  
62.2)

СХДИХАШШ-ийн 2019.05.08-ны өдрийн 5297 дугаартай захирамжийн үндэслэх хэсэгт “Хүсэлт гаргагч нь УТХтХ-ийн 7.1.2 дахь хэсэгт зааснаар УТХ төлөх боловч төлбөрийн чадваргүй гэх үндэслэлээр чөлөөлүүлэх тухай хүсэлт ирүүлсэн байна. Түүний хүсэлт нь баримтаар тогтоогдсонгүй.

<sup>32</sup> Монгол Улсын Дээд шүүхийн Зөвлөмж, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь улсын тэмдэгтийн хураамжийн асуудал, №4, 2012.12.24. <http://www.supremecourt.mn/act/view/61> 2021.04.15-ны өдөр мэдээлэл авав.



Иймд О нь төлбөрийн чадваргүй буюу амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготойг тодорхойлсон хорооны засаг даргын захирамж, түүний хавсралт, нийгмийн халамжийн байгууллагын тодорхойлолт зэргийг хавсаргаж шүүхэд ирүүлэх эсхүл хуульд зааснаар УТХ төлж баримтыг нэхэмжлэлдээ хавсарган ирүүлэх нь зүйтэй тул хүсэлтийг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэв” гэжээ.

*Дүгнэлт:* Дээрх захирамжид шүүгч УТХ-аас чөлөөлүүлэх нэхэмжлэгчийн хүсэлтийг хүлээн аваагүй шалтгаанаа маш тодорхой тайлбарлаж, түүнээс илүү ямар ямар материал бүрдүүлж өгснөөр хүсэлтийг хүлээн авах боломжтой талаар ойлгомжтой бичсэн байна. Яг энэ захирамж шиг тодорхой бөгөөд ойлгомжтой бичсэн захирамж олон биш байгаа нь шүүгчийн бичгийн болон мэргэжлийн ур чадвартай шууд холбоотой гэж дүгнэж болох юм. Тиймээс иргэдийн дунд шүүгчийн мэдлэг, ур чадварт эргэлзсэн, сайжруулах шаардлагатай гэсэн саналуудыг судалгаанд өгсөн байна. Тодруулбал, иргэдийн 40 орчим хувь нь шүүгч, ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд цаашид онцгой анхаарах шаардлагатай гэж үзжээ. Энэ нь судалгааны нэгдүгээр хэсэгт “Шүүхээр хэрэг маргаанаа шийдвэрлүүлэхэд ямар нэг хүндрэл гарсан уу?” гэж асуухад иргэдийн дийлэнх олонх нь “Шүүгчдийн мэдлэг, чадварт эргэлзсэн” гэж хариулсантай давхцаж байна. Шүүхийн шинэтгэлийн хүрээнд 2014 оноос хойш шүүгчдийн бүрэлдэхүүнийг олон шинэ шүүгчээр нэмэгдүүлсэн ч иргэд шүүгчдийн мэдлэг, ур чадвар хангалтгүй гэж үзэж байгаа хувь өндөр хэвээр байна. Эдгээр нь цаашид шүүхийн хүний нөөцийн шинэтгэлийг гүнзгийрүүлэх шаардлагатайг илэрхийлж байна.<sup>33</sup>

<sup>33</sup> ШЕЗ-ийн Судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн, “Шүүхэд итгэх иргэдийн итгэл” санал асуулгын судалгааны тайлан, 2017 оны 8-р сар, 17 дахь тал.

ИХШХШТХ-ийн 62.1.3-т заасан “Хариуцагчийн овог, эцгийн нэр, нэр, хаяг, хуулийн этгээд бол оноосон нэр, хаяг, оршин байгаа газар”-ын мэдээлэл нэхэмжлэлд заагаагүй үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж буй нийтлэг тохиолдлууд, тэдгээрт хийсэн хууль зүйн дүгнэлтийг Хүснэгт 4-т харуулав.

#### **Хүснэгт 4. Хариуцагчийн мэдээлэл нэхэмжлэлд дурдагдаагүй гэх үндэслэлээр гаргасан захирамж**

Хариуцагчийн мэдээлэл тодорхой бус (ИХШХШТХ-ийн 62.1.3)	<p>БЗДИХАШШ-ийн 2019.3.13-ны өдрийн 3981 тоот захирамжаар “Нэхэмжлэлд хариуцагчийн хаягийг бүрэн тодорхойлоогүй өөрөөр хэлбэл, гудамжны хэдэн тоотыг тодорхойлоогүй нь хариуцагчийн хаягийг тодорхойгүй болгож, нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангаагүй тул хүлээн авахаас татгалзав” гэжээ.</p> <p>Шүүгчийн 2019.11.22-ны өдрийн 19113 тоот захирамжаар “Нэхэмжлэл, түүнд хавсаргасан баримтаас үзэхэд нэхэмжлэгч нь хариуцагчийн овог, эцгийн нэрийг бичээгүй, нэхэмжлэлд хариуцагчийн иргэний үнэмлэх хавсаргагдаагүй тул шүүх хэнд холбогдуулан иргэний хэрэг үүсгэж ИХХША явуулахад тодорхойгүй нөхцөл үүсгэж байна. Иймд нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангаагүй үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзав” гэжээ.</p>
---	--

*Дүгнэлт:* Нэхэмжлэлд хариуцагчийн хаягийг зөв тодорхойлсноор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тухайн хариуцагчийг оролцуулах, холбогдох мэдэгдлийг хүргүүлэх, шүүхэд дуудан ирүүлэх чухал ач холбогдолтой. Хариуцагчийн овог, эцгийн нэрийг бичээгүй гэх үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж байгаа нь хуулиар нэхэмжлэлийг хүлээн авснаас хойш долоо хоногийн хугацаанд нэхэмжлэлтэй холбоотой “өөрчлөх, тодруулах боломжтой зүйлс”-ийг тодруулах ажиллагааг зохицуулаагүйтэй холбоотой.

Улсын тэмдэгтийн хураамжийг татварын буруу дансанд шилжүүлсэн үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан захирамжид хийсэн дүгнэлтийг Хүснэгт 5-д харуулав.

### **Хүснэгт 5. Буруу дансанд УТХ шилжүүлсэн гэх үндэслэлээр гаргасан захирамж**

---

Улсын тэмдэгтийн хураамжийг буруу дансанд шилжүүлсэн (ИХШХШТХ 62.2)	БЗДИХАШШ-ийн 2019.05.08-ны өдрийн 7427 дугаартай захирамжид “Татварын байгууллагаас УТХ төлсөн дансыг өөрчлөн зохион байгуулсантай холбогдож шүүхэд нэхэмжлэл гаргахад төлөх УТХ-ийг 10200300941 тоот дансанд тушаана. Гэвч нэхэмжлэлд хавсаргасан баримтаас үзэхэд ямар дансанд төлсөн нь тодорхойгүй байх тул УТХ төлсөн гэж үзэхгүй. Энэ нь нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл болно” гэжээ.
---	---

---

*Дүгнэлт:* БЗДИХАШШ-ийн захирамжуудтай танилцах явцад “УТХ-ийг хүлээн авдаг данс өөрчлөгдсөнтэй” холбоотойгоор буруу дансанд хураамжийг тушаасан гэсэн үндэслэлээр бага бус тооны нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан байв. Захиргааны байгууллагын зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбоотойгоор нэхэмжлэгч УТХ-ийг буруу дансанд тушаасныг “нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангаагүй” гэсэн үндэслэлээр хүлээн авахаас татгалзаж байгаа нь захиргааны байгууллага хоорондын уялдаа холбоогүйгээс үүдэн иргэн, хуулийн этгээдийн шүүхээр хамгаалуулах эрх үндэслэлгүйгээр хязгаарлагдсан байна.

---

Нэхэмжлэлийг хүлээн авах болон түүний бүрдүүлбэртэй холбоотой харьцуулсан судалгааны хүрээнд ХБНГУ, Япон Улс болон ОХУ-ын хуулийн зохицуулалтыг авч үзлээ.

Монгол Улсын ИХШХШТХ-ийн 62 дугаар зүйлд заасан “Нэхэмжлэлийн бүрдүүлбэр”-ийн зохицуулалтыг ОХУ-ын Арбитрын процессын кодекс<sup>34</sup>, мөн Иргэний процессын кодекс<sup>35</sup> холбогдох зохицуулалттай харьцуулж үзэхэд ОХУ-ын процессын хуулиудад нэхэмжлэл, түүнд хавсаргах баримтууд нь Хүснэгт 6-д үзүүлсэн байдлаар хийгддэг ажээ.

**Хүснэгт 6. ОХУ-ын процессын хуулиудад  
“Нэхэмжлэлийн бүрдүүлбэр”-ийн талаар зохицуулсан байдал**

<b>Арбитрын процессын кодекс</b>	<b>Иргэний процессын кодекс</b>
<p>125 дугаар зүйл. Нэхэмжлэлд зайлшгүй тусгах зүйлс:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Нэхэмжлэл гаргаж буй шүүхийн нэр;</li> <li>- Нэхэмжлэгчийн нэр, хаягийн мэдээлэл (иргэн байх тохиолдолд оршин суугаа газрын нэр, төрсөн огноо, ажлын байрны хаяг эсхүл хувиараа бизнес эрхлэгчийн улсын бүртгэлийн дугаар, утас, факс, цахим хаягийн мэдээлэл);</li> <li>- Хариуцагчийн мэдээлэлд Иргэний хувьд: овог (байгаа тохиолдолд), эцгийн нэр, нэр, оршин суугаа хаяг, мэдэж байгаа тохиолдолд төрсөн огноо, ажлын хаяг</li> </ul>	<p>131 дүгээр зүйл. Шүүхэд нэхэмжлэл бичгээр гаргана. Нэхэмжлэлд дараах зүйлсийг тусгана. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Нэхэмжлэл гаргаж буй шүүхийн нэр;</li> <li>- Нэхэмжлэгчийн нэр, оршин суугаа газрын хаяг, (Байгууллагын хувьд нэхэмжлэгчийн нэр, хаяг; нэхэмжлэлийн төлөөлөгч гаргаж байгаа тохиолдолд түүний нэр, хаяг);</li> <li>- Хариуцагчийн мэдээлэлд Иргэний хувьд: овог (байгаа тохиолдолд), эцгийн нэр, нэр, оршин суугаа хаяг, мэдэж байгаа тохиолдолд төрсөн огноо, ажлын хаяг болон иргэний</li> </ul>

<sup>34</sup> Арбитражный процессуальный кодекс Российской Федерации, 24.07.2002, N. 95-ФЗ. [http://www.consultant.ru/document/cons\\_doc\\_LAW\\_37800/](http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_37800/) (дата обращения: 13.03.2021)

<sup>35</sup> Гражданский процессуальный кодекс Российской Федерации, 14.11.2002, N. 138-ФЗ. [http://www.consultant.ru/document/cons\\_doc\\_LAW\\_39570/](http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_39570/) (дата обращения: 13.03.2021)

- 
- |  |   |
|--|---|
| <p>болон иргэний дараах тодорхойлох мэдээллүүдээс аль нэгийг заавал (НД-ийн хувийн дансны дугаар, татвар төлөгчийн дугаар, иргэний паспортын серийн дугаар, хувиараа бизнес эрхлэгчээр улсын бүртгэлд бүртгүүлсэн дугаар, жолооны үнэмлэхийн дугаар, тээврийн хэрэгслийн эзэмшигчийн дугаар); Байгууллагын хувьд: нэр, хаяг, мэдэж байгаа тохиолдолд татвар төлөгчийн болон улсын бүртгэлийн дугаар;</p> <ul style="list-style-type: none"><li>- Хариуцагчаас шаардаж буй шаардлага (нэхэмжлэлийн шаардлага), хууль болон бусад эрх зүйн актыг эшилсэн үндэслэл;</li><li>- Нөхцөл байдал – нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл болж буй үүссэн нөхцөл байдал, тухайн нөхцөл байдлыг нотлох баримтууд;</li><li>- Нэхэмжлэлийн үнэ (үнэлэх боломжтой тохиолдолд);</li><li>- Нэхэмжилж буй мөнгөн дүнгийн тооцоолол;</li><li>- Урьдчилан шийдвэрлэх ажиллагаанд явуулсан мэдээлэл;</li><li>- Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцсон бол тэр талаарх мэдээлэл;</li></ul> | <p>дараах тодорхойлох мэдээллүүдээс аль нэгийг мэдэж байгаа тохиолдолд (НД-ийн хувийн дансны дугаар, татвар төлөгчийн дугаар, иргэний паспортын серийн дугаар, хувиараа бизнес эрхлэгчээр улсын бүртгэлд бүртгүүлсэн дугаар, жолооны үнэмлэхийн дугаар, тээврийн хэрэгслийн эзэмшигчийн дугаар); Байгууллагын хувьд: нэр, хаяг, мэдэж байгаа тохиолдолд татвар төлөгчийн болон улсын бүртгэлийн дугаар;</p> <ul style="list-style-type: none"><li>- Нэхэмжлэлийн шаардлага, нэхэмжлэгчийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөж буй шалтгаан;</li><li>- Нэхэмжлэлийн шаардлагаа үндэслэж буй нөхцөл байдал, түүнийг нотлох баримтууд;</li><li>- Нэхэмжлэлийн үнэ (үнэлэх боломжтой тохиолдолд), мөн мөнгөн төлбөрийн шаардлагын тооцоолол;</li><li>- Хуульд заасан тохиолдолд хариуцагчид хандаж шүүхийн өмнөх шатанд ажиллагаа хийсэн талаарх мэдээлэл;</li><li>- Талууд эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцсон тохиолдолд</li></ul> |
|--|---|
-

- Нэхэмжлэл гаргахаас өмнө эд хөрөнгийн эрхийг шүүхээр хамгаалуулсан арга хэмжээний мэдээлэл;
- Хавсралтаар өгч буй баримтын жагсаалт.

- холбогдох мэдээлэл;
- Хавсралтаар өгч буй баримтын жагсаалт.

126 дугаар зүйл. Нэхэмжлэлд дараах баримтуудыг хавсаргана. Үүнд:

1. Хэргийн бусад оролцогчдод нэхэмжлэл, түүний хавсралтуудын хуулбарыг шуудангаар хүргүүлсэн баримт;
2. УТХ төлсөн баримт эсхүл УТХ-ийг хойшлуулах, хэсэгчлэн төлөх, чөлөөлүүлэх хүсэлт;
3. Нэхэмжлэлийн шаардлагаа үндэслэж буй үүссэн нөхцөл байдлыг гэрчлэх баримтууд;
4. Хуулийн этгээд эсхүл хувиараа бизнес эрхлэгчийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
5. Нэхэмжлэлд гарын үсэг зурах эрх олгосон итгэмжлэл эсхүл бүрэн эрхийг нотолсон бусад баримт бичиг;
6. Иргэний хэрэг үүсгэх хүртэл эд хөрөнгийн эрхийг хамгаалах тухай шүүгчийн захирамжийн хуулбар;

132 дугаар зүйл. Нэхэмжлэлд дараах баримтуудыг хавсаргана. Үүнд:

1. УТХ төлсөн баримт эсхүл УТХ-ийг хойшлуулах, хэсэгчлэн төлөх, чөлөөлүүлэх хүсэлт;
2. Итгэмжлэл эсхүл төлөөлөгчийн бүрэн эрхийг тодорхойлох бусад баримтууд;
3. Нэхэмжлэлийн шаардлагаа үндэслэж буй үүссэн нөхцөл байдлыг гэрчлэх баримтууд;
4. Холбооны хуульд заасан шүүхийн өмнөх шатанд хийгдсэн ажиллагааны баримтууд;
5. Нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл болсон нөхцөл байдлыг гэрчилсэн баримтууд;
6. Нэхэмжлэгч, түүний төлөөгчийн гарын үсэг зурсан маргаж буй төлбөрийн шаардлагын тооцоолол, түүний хуулбарууд (хариуцагчийн тоогоор);

*Хүснэгт 6-гийн үргэлжлэл*

- 
- |  |  |
|--|--|
| 7. Холбооны хуулийн дагуу хийгдсэн урьдчилан шийдвэрлэх ажиллагааны баримтууд;   | 7. Хэргийн бусад оролцогчдод нэхэмжлэл, түүний хавсралтуудын хуулбарыг шуудангаар хүргүүлсэн баримт; |
| 8. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцсонтой холбоотой баримтууд (байгаа тохиолдолд);   | 8. Талууд эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцсон бол холбогдох баримтууд.                           |
| 9. Гэрээ байгуулахыг даалгах шаардлагын хувьд гэрээний төсөл;  |  |
| 10. Хуулийн этгээд, хувиараа бизнес эрхлэгчийн улсын бүртгэлийн нэгдсэн сангийн лавлагаа (лавлагааг авснаас хойш 30 хоногийн дотор шүүхэд хандах). |  |
- 

ОХУ-ын Арбитрын процессын кодексын 128 дугаар зүйл, мөн тус улсын Иргэний процессын кодексын 136 дугаар зүйлд зааснаар нэхэмжлэлийн агуулга болон хэлбэрийн шаардлагыг хангаагүй эсхүл нэхэмжлэлд хавсаргахаар заасан баримтуудыг ирүүлээгүй тохиолдолд нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулах захирамж (нэхэмжлэлийг түдгэлзүүлэх) гаргах бөгөөд захирамжид тухайн захирамжийн эрх зүйн үндэслэлээс гадна нэхэмжлэлийн бүрдүүлбэрийг хангуулах нэмэлт хугацаа заадаг. Нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангаагүй гэх үндэслэлээр нэхэмжлэл хүлээн авахаас татгалзах хууль зүйн үндэслэлийг процессын хуулиудад заагаагүйгээс гадна аливаа этгээд өөрийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг шүүхээр хамгаалуулах эрхийн хүрээнд нэхэмжлэлийн бүрдүүлбэртэй холбоотой илэрсэн зөрчлийг засварлах, нэмэлт хугацаанд арилгах боломжтой юм. Захирамжид заасан хугацаанд зөрчлийг арилгаагүй тохиолдолд нэхэмжлэлийг буцаах буюу ахин гаргах эрхтэйгээр

нэхэмжлэгчид нэхэмжлэл, түүнд хавсаргасан баримтыг буцаадаг.

ХБНГУ-д нэхэмжлэл нь хуульд заасан шаардлагыг хангасан, шүүхийн зардлыг шүүхийн дансанд урьдчилан төлсөн тохиолдолд шүүхээс нэхэмжлэлийг нөгөө тал руу тэр даруй илгээдэг. Нэхэмжлэлийг нөгөө талд хүргүүлснээр иргэний хэрэг үүссэн гэж үзнэ. Хэрэв нэхэмжлэл нь алдаатай бол шүүхээс тухайн алдааг засах боломж олгох бөгөөд засаагүй тохиолдолд нэхэмжлэлийг шаардлага хангаагүй гэж үзэж хүлээн авахаас татгалздаг.<sup>36</sup> Ийнхүү алдаатай нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан шүүгчийн шийдвэрт гомдол гаргах эрхгүй (Иргэний процессын хуулийн 139.3 дахь заалт).

Тус улсын Иргэний процессын хуулийн 253.1, 253.2, 253.3-т заасны дагуу бичгээр гаргаж буй нэхэмжлэл нь маргаж буй талууд болон харьяалан шийдвэрлэх шүүхийг тодорхойлж, нэхэмжлэлийн үндэслэлүүд ба маргаж буй асуудлын талаар тодорхой мэдээлэл өгч, хүсэлт гаргаж байгаа бол тухайн хүсэлтийн үндэслэлийг тодорхой заасан байна. Мөн нэхэмжлэл гаргахаас өмнө маргааныг шийдвэрлүүлэхээр эвлэрүүлэн зуучлагч болон ижил төстэй зөрчилдөөнийг шийдвэрлэх бусад ажиллагаанд оролцсон эсэх, оролдлого хийсэн эсэх, мөн шүүхээр шийдвэрлүүлэхээс урьдчилан сэргийлэх бодит шалтгаан байгаа эсэх, маргаж буй асуудал нь тодорхой мөнгөн дүнтэй байхыг шаардахгүй боловч маргаж буй зүйлийн үнэ цэний талаарх мэдээлэл нь шүүхээр ямар асуудлыг шийдвэрлэх эсхүл шийдвэрлэхгүйг тодорхойлоход ач холбогдолтой. Тиймээс түүнийг тодорхойлох, нэг шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэхээс сэргийлэх ямар нэг шалгаан байгаа эсэх талаар дурдсан байх шаардлагатай. Нэхэмжлэлд тавигдаж буй дээр дурдсан шаардлагуудаас аль нэгийг нь нэхэмжлэгч орхигдуулсан эсхүл нэхэмжлэлээ

<sup>36</sup> European Justice, How to proceed – Germany, [https://e-justice.europa.eu/content\\_how\\_to\\_proceed-34-de-en.do?member=](https://e-justice.europa.eu/content_how_to_proceed-34-de-en.do?member=) (accessed 10 April 2021)



алдаатай гаргасан тохиолдолд шүүхээс хугацаа тогтоож түүнийг засах боломж олгож, хэрэв тухайн хугацаанд дурдсан алдааг нэхэмжлэгч засаагүй бол гомдол гаргах эрхгүйгээр хүлээн авахаас татгалзаж байгаа нь шударга бөгөөд үр дүнтэй зохицуулалт болсон.

Япон Улсын Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хоёрдугаар бүлэгт шүүх анхан шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан бөгөөд тус хуулийн 133 дугаар зүйлээр “нэхэмжлэл гаргах журам”-ыг зохицуулсан. Тус журамд шүүхэд гомдол гаргах замаар нэхэмжлэл гаргах, тухайн гомдолд талууд, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгчид, нэхэмжлэлийн шаардлага болон нэхэмжлэлийн үндэслэлийг тусгахаар заасан. Уг зохицуулалтыг илүү тодруулбал, нэхэмжлэлд талуудыг тодорхой заасан байхаас гадна нэхэмжлэлийн объект (шаардлага гэж ойлгож болох юм) болон үндэслэлийг заавал тусгасан байна. Нэхэмжлэлийн объект (шаардлага) нь нэхэмжлэлээ бүхэлд нь дүгнэж буй ойлголт бөгөөд нэхэмжлэгчийн шүүхээр хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхийг хүсэж буй зүйл, тухайлбал, тодорхой хэмжээний мөнгө төлөхийг шаардах эсхүл үл хөдлөх эд хөрөнгөө нүүлгэн шилжүүлэхийг шаардах гэх мэт үр дүнг ойлгоно.<sup>37</sup>

2. *“Шүүхийн харьяалал зөрчсөн” үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан захирамжид хийсэн дүн шинжилгээ*

Шүүхээс нэхэмжлэлийг шүүхийн харьяалал зөрчсөн гэх үндэслэлээр хүлээн авахаас татгалзсан захирамж гаргасан дараах тохиолдлуудад хуулийн зохицуулалтыг тайлбарласан шүүгчийн дүгнэлтэд хуульч судлаачийн байр сууринаас дүгнэлт хийсэн болно.

<sup>37</sup> Outline of civil procedure in Japan, 2020, Supreme Court of Japan. /[https://www.courts.go.jp/english/vc-files/courts-en/file/Outline\\_of\\_Civil\\_Procedure\\_in\\_JAPAN\\_2020.pdf](https://www.courts.go.jp/english/vc-files/courts-en/file/Outline_of_Civil_Procedure_in_JAPAN_2020.pdf)/ (Accessed date: 09 April 2021)

## Хүснэгт 7. Шүүхийн харьяалал зөрчсөн гэх үндэслэлээр гаргасан захирамж

1

Татгалзлын үндэслэл	Хууль зүйн дүгнэлт
Шүүхийн онцгой харьяалал (ИХШХШТХ-ийн 16.1)	БЗДИХАШШ-ийн 2019.01.07-ны өдрийн 544 тоот захирамжаар “Орон сууцны хууль ёсны өмчлөгчөөр тогтоолгох тухай”, мөн шүүгчийн 2019.02.26-ны өдрийн 3172 тоот захирамжаар “Хууль бус эзэмшлээс орон сууцыг чөлөөлүүлэх тухай” шаардлага бүхий нэхэмжлэлийг хариуцагчийн оршин суугаа газрын шүүхэд гаргасныг “шүүхийн онцгой харьяалал зөрчсөн” гэх үндэслэлээр хүлээн авахаас татгалзсан байна.
<i>Дүгнэлт:</i> ИХШХШТХ-ийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт зааснаар үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх, эзэмших, ашиглах эрхтэй холбоотой эсхүл үл хөдлөх эд хөрөнгийн битүүмжлэлийг нээлгэх тухай нэхэмжлэлийг тухайн эд хөрөнгө байрлаж байгаа газрын шүүхэд гаргахаар зохицуулсан тул нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан нь үндэслэлтэй. Нэхэмжлэгч нь тодорхой гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар гэрээний зүйл болох үл хөдлөх эд хөрөнгийг шилжүүлэх шаардлага гаргаагүй байх тул нутаг дэвсгэрийн нийтлэг харьяаллыг баримталж шийдвэрлэхгүй байна.	
Шүүхийн онцгой харьяалал (ИХШХШТХ-ийн 16.4)	Шүүгчийн 2019.01.11-ний өдрийн 1010 тоот захирамжаар “Хүүхдийн асрамж, тэтгэлэг тогтоолгох тухай”, мөн шүүгчийн 2019.04.02-ны өдрийн 5039 тоот захирамжаар “Хүүхдийн тэтгэлэг тогтоолгох тухай” шаардлага бүхий нэхэмжлэлийг шүүхийн онцгой харьяаллын дагуу нэхэмжлэгч өөрийн оршин суугаа газрын шүүхэд гаргаагүй гэсэн үндэслэлээр хүлээн авахаас татгалзсан.

Хүснэгт 7-гийн үргэлжлэл

*Дүгнэлт:* ИХШХШТХ-ийн 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсэгт зааснаар тэжээн тэтгэхтэй холбоотой нэхэмжлэлийг нэхэмжлэгчийн оршин суугаа газрын шүүхэд гаргах бөгөөд “тэжээн тэтгүүлэхтэй” холбоотой шаардлагыг дангаар гаргасан тохиолдолд энэхүү онцгой харьяалал үйлчилнэ. Харин “Хүүхдийн асрамж, тэтгэлэг тогтоолгох” тухай нэхэмжлэлийн шаардлагын хувьд зөвхөн хүүхдийн тэтгэлэг тогтоолгохоос гадна хүүхдийн асрамжтай холбоотой асуудлыг шийдвэрлүүлэхээр шүүхэд хандсан байх тул нэхэмжлэлийг нутаг дэвсгэрийн нийтлэг харьяаллын дагуу ИХШХШТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасныг үндэслэн хариуцагчийн оршин суугаа газрын шүүхэд гаргах эрхтэй бөгөөд шүүхийн харьяалал зөрчөөгүй байна.

Шүүхийн  
онцгой  
харьяалал  
(ИХШХШТХ-  
ийн 16.1)

ХУДИХАШШ-ийн 2019.01.07-ны өдрийн 544 дүгээр захирамжаар орон сууцны хууль ёсны өмчлөгчөөр тогтоолгох нэхэмжлэлийн шаардлага бүхий нэхэмжлэлд “Нэхэмжлэгч нь БЗД-т байрлах орон сууцны хууль ёсны өмчлөгчөөр тогтоолгох тухай нэхэмжлэл гаргасан. ИХШХШТХ 16.1-д зааснаар БЗД-т байрлах үл хөдлөх хөрөнгийн өмчлөгчөөр тогтоолгох тухай нэхэмжлэлийг тус шүүхэд гаргаснаар хуульд заасан шүүхийн харьяалал зөрчсөн байх тул ИХШХШТХ-ийн 65.1.2-т зааснаар татгалзах үндэслэлтэй байна. Мөн нэхэмжлэгч УТХ төлөхдөө данс андуурч ХУД-ийн бүртгэлийн хэлтсийн дансанд тушаасныг дурдах нь зүйтэй” гэсэн шүүгчийн захирамж гарчээ.

*Дүгнэлт:* Үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх, ашиглах, захиран зарцуулах эрхтэй холбоотой нэхэмжлэл нь шүүхийн онцгой харьяалалд хамаарах бөгөөд үл хөдлөх хөрөнгө нь гэрээний зүйл болж гэрээнээс үүдэлтэй шаардлага гаргаж байгаа тохиолдолд шүүхийн нутаг дэвсгэрийн нийтлэг харьяаллын дагуу шийдвэрлэхээр ИХШХШТХ-ийн 14, 16 дугаар зүйлээр зохицуулсан. Нэхэмжлэлийн шаардлагыг зөв тодорхойлох нь

нэхэмжлэлийн үнийг тооцон УТХ төлөхөөс гадна нэхэмжлэлийг шүүхийн харьяаллын дагуу шүүхэд гаргах урьдчилсан нөхцөл бүрддэг. Шүүхээс харьяалал зөрчиж хэргийг хянан шийдвэрлэх боломжгүй учраас энэхүү үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан нь ХХША-ны журамд нийцнэ.

Нутаг  
дэвсгэрийн  
нийтлэг  
харьяалал  
(ИХШХШТХ  
14.2)

БЗДИХАШШ-ийн 2019.04.04-ний өдрийн 5255 тоот захирамжаар компанид холбогдуулан гаргасан “Гэрээний үүргийн гүйцэтгэлд төлбөр гаргуулах тухай”, 2019.10.04-ний өдрийн 15598 тоот захирамжаар “Нийгмийн даатгалын шимтгэлийн өр, алдангийг гаргуулах тухай” шаардлагатай компанид холбогдуулан гаргасан нэхэмжлэлийг тус тус хариуцагч компанийн Гүйцэтгэх захирлын оршин суугаа газрын шүүхэд гаргасан нь ИХШХШТХ-ийн 14.2-т заасан хуулийн этгээд ажил хэргээ байнга явуулдаг эсхүл удирдах байгууллага нь байгаа газрын шүүхэд гаргах, шүүхийн харьяаллыг зөрчсөн гэж үзэж нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан.

*Дүгнэлт.* Иргэний хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт зааснаар өмчлөгч буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг хуулийн этгээд гэнэ. Хуулийн этгээд нь иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийн оролцогчийн эрхийг эдэлж, үүрэг хүлээх чадвартай бие даасан субъект болохын хувьд компанийн үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал байхаас үл хамааран иргэний оршин суудаг хаяг нь “хуулийн этгээдийн ажил хэргээ байнга явуулдаг” эсхүл “удирдах байгууллагын оршин байгаа” гэсэн хуульд заасан хаягийг тодорхойлоход хамаарахгүй учраас нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан нь хууль зүйн үндэслэлтэй байна.

*Хүснэгт 7-гийн үргэлжлэл*

---

Нутаг дэвсгэрийн харьяалал (ИХШХШТХ- ийн 14.1)	БГДИХАШШ-ийн 2019.08.05-ны өдрийн 9691 дугаартай захирамжийн үндэслэх хэсэгт “ИХШХШТХ-ийн 14.1 дэх хэсэгт... гэж заасан. ИХШХШТХ-ийн 65.1.2-т заасны дагуу шүүхийн харьяалал зөрчсөн нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзахаар хуульчилсан байна. Гэтэл нэхэмжлэгч нь шүүхэд хандан нэхэмжлэл гаргахдаа хариуцагчийн хаягийг Баянгол дүүргийн ... тоот, Сүхбаатар дүүргийн ... тоот гэж тодорхойлсон бөгөөд Баянгол дүүргийн хаягт хариуцагч нь амьдардаггүй болохыг нэхэмжлэлд дурдсан байх тул хариуцагчийн оршин суугаа газрын шүүхэд нэхэмжлэлийг гаргах боломжтой гэж үзэн нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэлтэй байна” гэжээ.
--	--

---

Нэхэмжлэгчийн сонгон авсан нутаг дэвсгэрийн харьяалал (ИХШХШТХ- ийн 15.4)	БГДИХАШШ-ийн 2019.02.20-ны өдрийн 2401 дугаартай захирамжийн үндэслэх хэсэгт “ИХШХШТХ-ийн 133.1.10-т заасан онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх хэрэгт хамаарч байгаа хүсэлт гаргагч нь 15.3-т заасны дагуу эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоолгох хүсэлтээ иргэн, хуулийн этгээд өөрийн оршин суугаа газрын эсхүл тухайн үйл явдал болсон газрын шүүхэд гаргана гэж зааснаар хуулийн этгээдийн бүртгэлтэй газрын шүүхэд хүсэлтээ гаргах нь зүйтэй. Иймд дээрх үндэслэлээр хүсэлтийг хүлээн авахаас татгалзах нь зүйтэй” гэжээ.
---	--

---

БГДИХАШШ-ийн 2019.11.05-ны өдрийн 14051 дугаартай захирамжийн үндэслэх хэсэгт “ИХШХШТХ-ийн 155.1, 155.2-г ...гэж заасан. ИХШХШТХ-ийн 65.1.2, 14.5-д эрэн сурвалжлах нэхэмжлэлийг нэхэмжлэгчийн оршин суугаа газрын шүүхэд гаргахаар заасан байна. Нэхэмжлэгч О нь Архангай аймаг... тоот хаягт оршин суух бүртгэлтэй байх тул нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч У-гийн гаргасан нэхэмжлэлийг шүүхийн харьяалал зөрчсөн үндэслэлээр хүлээн авахаас татгалзах нь зүйтэй гэж үзэв” гэж шийдвэрлэснийг нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч “Нэхэмжлэгч О нь Архангай аймагт бүртгэлтэй байх тул шүүхийн харьяалал зөрчсөн гэсэн үндэслэлээр хүлээн авахаас татгалзсан нь үндэслэлгүй байна. Нэхэмжлэгч О нь У надад итгэмжлэлээр өөрийгөө төлөөлөх бүх эрхийг олгосон бөгөөд тус итгэмжлэлээр О-г бүрэн төлөөлж байгаа гэдэг нь тодорхой. Нэхэмжлэгчийн бүхий л эрх, үүргийг хэрэгжүүлэх боломжтой, нэхэмжлэгч гэж ойлгох боломжтой тул өөрийн харьяа дүүргийн шүүхэд нэхэмжлэл гаргах боломжтой гэж үзэж байна” гэсэн агуулга бүхий гомдол гаргасныг, тухайн шатны шүүхийн 2019.11.19-ний өдрийн 444 дугаартай тогтоолоор “О нь 2019.10.18-ны өдөр У-д итгэмжлэл олгосон ба ИХШХШТХ-ийн 25, 26 дугаар зүйлд заасан эрх, үүргийг шилжүүлсэн. Үүний дагуу төлөөлөгч У нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хариуцагчаар оролцвол зохих этгээдийг эрэн сурвалжлуулах хүсэлтийг өөрийн оршин суугаа газрын шүүхэд гаргасныг ИХШХШТХ-ийн 155.2-г заасныг зөрчсөн гэж үзэхгүй.

*Хүснэгт 7-гийн үргэлжлэл*

---

Учир нь мөн хуулийн 26.2.2-т зааснаар нэхэмжлэгч гэж өөрийн болон бусдын нэрийн өмнөөс нэхэмжлэл гаргагч этгээдийг хэлдэг тул нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нэхэмжлэлийг өөрийн оршин суугаа газрын шүүхэд гаргасныг буруутгах боломжгүй байна. Дээрх нэхэмжлэл нь ИХШХШТХ-ийн 16-р зүйлд заасан шүүхийн онцгой харьяалалд хамаарахгүй” гэж тайлбарлан гомдлыг хангаж, захирамжийг хүчингүй болгож шийдвэрлэсэн.

---

*Дүгнэлт:* Шүүхийн ердийн харьяалал болох нэхэмжлэлийг хариуцагчийн оршин суугаа газрын шүүхэд гаргах, онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх хүсэлтийг тухайн үйл явдал болсон газрын эсхүл нэхэмжлэгчийн оршин суугаа газрын шүүхэд гаргах хуулийн зохицуулалтын хүрээнд дээрх захирамжууд гарсан нь хуульд нийцсэн байна. Харин хүсэлт гаргагчийн оршин суугаа газрын шүүхэд гаргахаар хуульд заасан шүүхийн харьяалал бүхий “хариуцагчийг эрэн сурвалжлуулах” хүсэлтийг нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь өөрийн оршин суугаа газрын шүүхэд гаргасныг шүүгч хүлээн авахаас татгалзсан. Нэхэмжлэгч нэхэмжлэлийг шүүхэд гаргахаас эхлээд өөрийн бүхий л эрх, үүргийг итгэмжлэлээр төлөөлөгчид шилжүүлсэн тохиолдолд сонгох болон нэхэмжлэгчийн оршин суугаа газрын шүүхэд нэхэмжлэл гаргах шүүхийн харьяаллыг хэрхэн ойлгох вэ гэдэг асуудал хөндөгдөж байна. Тухайлбал, дээрх тохиолдол шиг “Нэхэмжлэгч өөрөө Архангай аймагт амьдардаг, хариуцагч нь Улаанбаатар хотод оршин суудаг бөгөөд тэрээр Улаанбаатар хотод оршин суудаг хүнд бүх эрх, үүргээ хэрэгжүүлэх итгэмжлэл олгосон бол итгэмжлэгдсэн төлөөлөгч нь хариуцагчийг эрэн сурвалжлуулах хүсэлтээ заавал Архангай аймгийн шүүхэд гаргах ёстой юу?” гэдэг асуудлыг шүүхэд мэдүүлэх эрхийн үүднээс зөвөөр тайлбарлаж, шүүхийн практикт хэрэглэх нь зүйтэй.

---

Өөрийн эрх нь зөрчигдөөгүй этгээд бусдын зөрчигдсэн эрхийг сэргээлгэхээр нэхэмжлэл гаргаж болно. “Бусдын эрхийг хэрэгжүүлэх” гэдгийг хоёр утгаар ойлгож болно. Юуны өмнө үүнд бусдаар төлөөлүүлэн нэхэмжлэл гаргах, түүнийг төлөөлөн иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах, мөн өөрөө нэхэмжлэл гаргаж төлөөлөгчөө оролцуулах явдал хамаарна гэж Улсын Дээд шүүх тайлбарласан байдаг. Харин онолын хувьд энд бусдын эрхийг өөрийн нэрийн өмнөөс хэрэгжүүлэх явдал багтана.<sup>38</sup> Дээрх тохиолдолд тухайн шатны шүүхийн тогтоолоор нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчид бүх эрх, үүргийг хэрэгжүүлэх итгэмжлэл олгогдсон байх тул түүнийг ИХШХШТХ-ийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэгт зааснаар “нэхэмжлэгчийн нэгэн адил үзнэ” гэж тайлбарласныг хүлээн зөвшөөрөх үндэслэлтэй юм. Энэ нь шүүгчийн захирамжид гомдол гаргах эрхийг “нээлттэй” байлгасны шууд үр дагавар бөгөөд шүүхэд мэдүүлэх эрхийг хамгаалж буйгаараа ач холбогдолтой юм.

Монгол Улсын ИХШХШТХ-ийн 65 дугаар зүйлийн 65.1.2-т зааснаар “шүүхийн харьяалал” зөрчсөн тохиолдолд нэхэмжлэл хүлээн авахаас татгалзах зохицуулалтыг ОХУ-ын процессын хуулиудад “нэхэмжлэлийг буцаах” ойлголтын хүрээнд хэрхэн зохицуулсныг Хүснэгт 8-д харуулав.

<sup>38</sup> Б.Буянхшиг, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй, УБ., 2021, 80 дахь тал.



**Хүснэгт 8. ОХУ-ын процессын хуулиудад  
“Нэхэмжлэлийг буцаах” нөхцөлийг хуульчилсан байдал**

<b>ОХУ-ын Арбитрын процессын кодексын 129-р зүйл</b>	<b>ОХУ-ын Иргэний процессын кодексын 135-р зүйл</b>
<p>Шүүгч нэхэмжлэлийг хүлээн авах асуудлуудыг хянан хэлэлцэх үед дараах тохиолдолд нэхэмжлэлийг буцаана. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"><li>1. Шүүхийн харьяалал зөрчсөн (ердийн шүүхийн харьяалал байх тохиолдолд);</li><li>2. Нэхэмжлэлийн шаардлага нь мөнгөн төлбөр (хуулиар тогтоосон бага хэмжээний)-ийг шүүгчийн захирамжаар албадан гаргуулах журмаар шийдвэрлэх тохиолдолд;</li><li>3. Хэрэг үүсгэхээс өмнө нэхэмжлэгчээс нэхэмжлэлийг буцаах хүсэлт гаргасан;</li><li>4. Нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулах захирамжид заасан хугацаанд бүрдүүлбэрийг хангаагүй;</li><li>5. Хуулиар тогтоосон урьдчилан шийдвэрлүүлэх ажиллагаа болон шүүхээс өмнөх шатанд гүйцэтгэх ажиллагааг зөрчсөн;</li><li>6. Нэхэмжлэлд гарын үсэг зураагүй эсхүл нэхэмжлэлд гарын үсэг зурах эрх олгогдоогүй этгээд зурсан;</li><li>7. Улсын тэмдэгтийн хураамжийг хөнгөлөх, хойшлуулах хүсэлтийг хүлээн авахаас татгалзсан.</li></ol>	<p>Шүүгч дараах тохиолдолд нэхэмжлэлийг буцаана. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"><li>1. Хуулиар тогтоосон шүүхийн өмнөх шатны ажиллагааны журмыг баримтлаагүй эсхүл ажиллагаа хийсэнтэй холбоотой баримтыг ирүүлээгүй;</li><li>2. Нэхэмжлэлийн шаардлага нь мөнгөн төлбөр (хуулиар тогтоосон бага хэмжээний)-ийг шүүгчийн захирамжаар албадан гаргуулах журмаар шийдвэрлэх тохиолдолд;</li><li>3. Шүүхийн харьяалал зөрчсөн;</li><li>4. Эрх зүйн бүрэн чадамжгүй иргэн нэхэмжлэл гаргасан;</li><li>5. Нэхэмжлэлд гарын үсэг зураагүй эсхүл нэхэмжлэлд гарын үсэг зурах эрх олгогдоогүй этгээд зурсан;</li><li>6. Нэхэмжлэлд заасан үндэслэл, шаардлагын хүрээнд тухайн хариуцагчид холбогдох маргааныг тухайн шүүх, бусад шүүх эсхүл хөндлөнгийн арбитр шийдвэрлэж байгаа;</li></ol>

- 
7. Хэрэг үүсгэхээс өмнө нэхэмжлэгчээс нэхэмжлэлийг буцаах хүсэлт гаргасан;
  8. Нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулах захирамжид заасан хугацаанд бүрдүүлбэрийг хангаагүй.
- 

ОХУ-ын арбитрын болон ердийн шүүхээс иргэний маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд “нэхэмжлэлийг буцаах” болон “нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах” үндэслэл, түүний эрх зүйн үр дагаврын ялгаатай байдлыг хуулиар тодорхойлсон. Нэхэмжлэлийг буцаах ойлголт нь түүнийг хүлээн авахад саад болж буй нөхцөл байдлыг арилгасан тохиолдолд шүүхэд мэдүүлэх эрхтэй байх эрх зүйн үр дагавартай. Харин ердийн (арбитрын) шүүхээс нэхэмжлэлд заасан маргааныг шийдвэрлэх боломжгүй буюу илэрсэн зөрчлийг засварлах боломжгүй нөхцөлд нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалздаг.

ХБНГУ-ын Иргэний процессын тухай хуулийн 12 дугаар зүйлд зааснаар иргэний маргаан шийдвэрлэх ерөнхий харьяалал нь тусгайлан зааснаас бусад тохиолдолд хариуцагчийн оршин суудаг газрын ердийн шүүх байдаг. Тус улсын Шүүхийн байгууллын тухай хуулийн 13 дугаар зүйлд зааснаар ердийн шүүхүүд нь иргэний болон гэр бүлийн маргаан, эрүүгийн бус, захиргааны албан тушаалтнуудын эсрэг бус, захиргааны шүүхийн харьяаллын бус иргэний асуудлууд болон холбооны хуулийн заалтуудаар зөвшөөрөгдөж бий болгосон тусгай шүүхийн харьяаллын бус иргэний асуудлуудыг шийдвэрлэдэг. Маргааны төрөл болон хандаж буй шүүхээсээ хамаарч нэхэмжлэл гаргахаас эхлээд процессын бүхий л үе шатанд хэргийн оролцогч өөрөө орох эсхүл заавал

өмгөөлөгч буюу зөвлөх оролцуулах замаар иргэний маргаанд оролцоно. 5000 евро хүртэлх үнийн дүнтэй маргааныг орон нутгийн анхан шатны шүүх, түүнээс дээш үнийн дүнтэй маргааныг бүсийн анхны шатны шүүх шийддэг.<sup>39</sup> Иргэний маргаан үүсгэхийн тулд нэхэмжлэгч нь эрх бүхий шүүхэд гомдлоо бичгээр гаргах бөгөөд энэхүү гомдол нь нэхэмжлэл юм. Шүүхээс уг нэхэмжлэл нь Иргэний процессын хуульд заасан шаардлагуудад нийцэж буй эсэхийг шалган, бүртгэсний дараа нэхэмжлэлийг хариуцагчид хүргүүлдэг. Нэхэмжлэл хүлээн авах нөхцөлүүдийг заавал хангасан байх шаардлагатай. Тухайлбал, яагаад энэ шүүхэд нэхэмжлэл гаргах болсон талаар шүүхийн харьяаллыг тайлбарлах, дүүргийн болон хөдөлмөрийн шүүхээс бусад дээд шатны шүүхүүдэд заавал зөвшөөрөлтэй хуульчаар төлөөлүүлэх, бусад газарт эсхүл шүүхээр хэргийг шийдвэрлээгүй байх, хууль зүйн маргаан байх зэрэг багтана.

Дээрхээс дүгнэвэл маргааны төрлөөс хамаарч хууль зүйн мэдлэг шаардсан төвөгтэй маргаанд заавал хуульч, өмгөөлөгчийг зөвлөхөөр оролцуулах шаардлагыг хуулиар зохицуулсан нь нэхэмжлэл гаргах эрхийг хамгаалж буй нэг хэлбэр гэж үзэхээр байна. Учир нь нэхэмжлэгч өөрөө хууль зүйн мэдлэггүйгээс дээрх төрлийн төвөгтэй маргаануудад нэхэмжлэлээ тодорхой гаргахгүй, үндэслэлээ зөв тодорхойлж чадахгүй, хуульд нийцүүлэхгүй гаргаснаас эрхээ хамгаалуулах боломжгүй үр дагаварт хүрэхээс сэргийлж заавал хуульч, өмгөөлөгчөөр төлөөлүүлэх зохицуулалттай.

Япон Улсад нэхэмжлэгч нь хэргийн харьяаллын дагуу шүүхэд нэхэмжлэл гаргаснаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхэлдэг. Тохиолдлыг аль шүүхийн харьяаллынх болохыг шүүхийн акт, Иргэний процессын хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор шийдвэрлэнэ.

<sup>39</sup> European Justice, Ordinary courts – Germany. [https://e-justice.europa.eu/content\\_ordinary\\_courts-18-de-maximizeMS-en.do?member=1](https://e-justice.europa.eu/content_ordinary_courts-18-de-maximizeMS-en.do?member=1) (accessed 10 April 2021).

Иргэний маргааныг хянан шийдвэрлэх анхан шатны шүүх нь түргэвчилсэн/хялбаршуулсан шүүх (*summary court*) эсхүл дүүргийн шүүх (*district court*) байдаг. Япон Улсад 438 түргэвчилсэн/хялбаршуулсан шүүх, дүүргийн 50 шүүх байдаг. Түргэвчилсэн/хялбаршуулсан шүүх нь маргааны зүйлийн үнэ 1.4 сая иен, түүнээс бага хэмжээний мөнгөн дүн бүхий хэргийг хянан шийдвэрлэдэг бол дүүргийн шүүх нь 1.4 сая иенээс их үнийн дүн бүхий маргааныг харьяалан шийдвэрлэдэг.<sup>40</sup>

3. *“Нэхэмжлэгчийг төлөөлөх бүрэн эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан” үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан захирамжид хийсэн дүн шинжилгээ*

### **Хүснэгт 9. Төлөөлөх бүрэн эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан гэх үндэслэлээр гаргасан захирамж**

<b>Татгалзлын үндэслэл</b>	<b>Тохиолдол</b>
Хуулийн этгээдийг төлөөлөх (ИХШХШТХ-ийн 35, 36)	БЗДИХАШШ-ийн 2019.01.03-ны өдрийн 541 тоот захирамжаар “Нэхэмжлэлд Хадгаламж, зээлийн хоршооны даргаас итгэмжлэл олгосон этгээд гарын үсэг зурсан. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 28.1, 28.2, 34.8, 39.1, 39.7.1, 39.7.3-т тус тус зааснаар Хоршооны дарга нь хоршоог итгэмжлэлгүйгээр төлөөлөх, шүүхэд нэхэмжлэл гаргах итгэмжлэлд гарын үсэг зурах, итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох эрх бүхий этгээд биш байх тул итгэмжлэл нь ИХ-ийн 64.2, ИХШХШТХ-ийн 36.2-т зааснаар хуульд нийцээгүй” гэж үзэн нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан.

<sup>40</sup> Outline of civil procedure in Japan, 2020, Supreme Court of Japan. /[https://www.courts.go.jp/english/vc-files/courts-en/file/Outline\\_of\\_Civil\\_Procedure\\_in\\_JAPAN\\_2020.pdf](https://www.courts.go.jp/english/vc-files/courts-en/file/Outline_of_Civil_Procedure_in_JAPAN_2020.pdf)/ (Accessed date: 09 April 2021).

Дүгнэлт. ИХ-ийн 64 дүгээр зүйлийн 64.2.1-д зааснаар хуулийн этгээдийн итгэмжлэлд эрх баригч гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарсан байх бөгөөд Хадгаламж, зээлийн хоршооны дарга нь хоршоог төлөөлөн итгэмжлэл олгох эрхтэй эсэхийг Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулиас гадна нэхэмжлэлд хавсаргасан баримтад үндэслэн тодорхойлно. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэгт бүх гишүүдийн хурлын чөлөө цагт хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааг Тэргүүлэгчдийн зөвлөл удирдаж, бүх гишүүдийн хуралд тайлагнана гэж заасан. Мөн хуулийн 35.1.18-д зааснаар хяналтын зөвлөл, зээлийн хорооны гишүүн, гишүүнчлэл бүхий гүйцэтгэх захирал, ажилтанд зээл олгох зөвшөөрөл олгох, зээлийн гэрээний хэрэгжилтэд хяналт тавих бүрэн эрхийг Тэргүүлэгчдийн зөвлөлд олгосон. Тэргүүлэгчдийн зөвлөл шийдвэрийг олонхын саналаар гаргах бөгөөд тогтоол хэлбэртэй байхаар заасан тул Тэргүүлэгчдийн зөвлөлийн дарга юм уу Хоршооны дарга дангаараа шүүхэд төлөөлөх итгэмжлэл олгох эрх хуулиар нарийвчлан зохицуулаагүй тул тухайн асуудлаар шийдвэр гаргах бүрэн эрх олгосон Тэргүүлэгчдийн зөвлөлийн тогтоол эсхүл Хоршооны дарга нь хуулийн этгээдийг төлөөлөх баримт бичгийг шүүхэд нэхэмжлэлийн хамт ирүүлэх ёстой байжээ. Шүүхээс ИХШХШтХ-ийн 36 дугаар зүйлийн 36.2-т заасны дагуу итгэмжлэл нь ИХ-ийн 64 дүгээр зүйлийн 64.2 дахь хэсэгт зааснаар хуульд нийцээгүй гэж дүгнэж, хүлээн авахаас татгалзсан нь үндэслэлтэй байна.

Хуулийн этгээдийг төлөөлөх (ИХШХШтХ-ийн 35.2)	БЗДИХАШШ-ийн 2019.01.07-ны өдрийн 671 тоот захирамжаар “...татварын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээс гаргасан нэхэмжлэлд түр орлон гүйцэтгэлийн тушаалыг хавсаргаагүй үндэслэлээр”, шүүгчийн 2019.04.11-ний өдрийн 5751 тоот захирамжаар “...нэхэмжлэлд гарын үсэг зурсан захирал нь хуулийн этгээдийг төлөөлөх бүрэн эрхтэй эсэх талаар баримт авагдаагүй” гэсэн үндэслэлээр нэхэмжлэлийг тус тус хүлээн авахаас татгалзсан.
---	--

*Дүгнэлт.* ИХШХШТХ-ийн 35 дугаар зүйлийн 35.2 дахь хэсэгт зааснаар хуулийн этгээдийг төлөөлж байгаа этгээд өөрийн албан тушаалыг гэрчилсэн баримтыг шүүхэд ирүүлээгүйн улмаас нэхэмжлэлийг төлөөлөх эрх бүхий этгээд гаргасан эсэхийг тодорхойлох тул шүүгчийн захирамж үндэслэлтэй байна.

<p>Хуулийн этгээдийг итгэмжлэлээр төлөөлөх (ИХШХШТХ-ийн 35,36-р зүйл)</p>	<p>БЗДИХАШШ-ийн 2019.02.04-ний өдрийн 2393 тоот захирамжаар “...нэхэмжлэлийг төлөөлөгч гаргасан бөгөөд түүний эрх бүхий этгээдээс олгосон итгэмжлэлд зээлээр ... гар утас авах Худалдах, худалдан авах гэрээний үүрэгтэй холбоотой маргаанд нэхэмжлэгчийг төлөөлөх эрх олгосон. Гэвч ... хөдөлгөөнт интернэт үйлчилгээ болон түүний хөдөлгөөнт төхөөрөмжийг Худалдах, худалдан авах гэрээний үүрэгтэй холбоотой маргаанд төлөөлөх эрх олгогдоогүй байна” гэсэн үндэслэлээр татгалзсан.</p>
---	--

*Дүгнэлт:* ИХШХШТХ-ийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсэгт зааснаар төлөөлөгчийн бүрэн эрхийг төлөөлүүлэгчээс бичгээр олгосон итгэмжлэл, бусад баримт бичгээр тодорхойлно. Итгэмжлэл нь ИХ-ийн 64 дүгээр зүйлийн 64.2 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан байна. ХХША-нд төлөөлүүлэгчийн эрх ашгийг зөрчсөн ямар маргаанд төлөөлөх эрх олгож буйг итгэмжлэлд тодорхой заах нь чухал ач холбогдолтой. Мөн итгэмжлэлд “шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг олгосон боловч ямар маргаанд төлөөлөх эрхийг” тусгаагүй байх нь нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл болж байна.

<p>Хуулийн этгээдийг төлөөлөх (ИХШХШТХ-ийн 35, 36)</p>	<p>БҮДИХАШШ-ийн 2019.04.03-ны өдрийн 3200 дугаартай захирамжийн үндэслэх хэсэгт “Шүүх нэхэмжлэлийг хүлээн авахдаа тухайн маргаанаар иргэний хэргийг хянах ажиллагаа явуулах нөхцөл бүрдсэн эсэх, иргэний журмаар тухайн шүүхийн харьяаллаар шалгах маргаан мөн эсэхийг шалгах шаардлагатай бөгөөд ИХШХШТХ-ийн</p>
--	---

62 дугаар зүйлд заасан нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангасан эсэх, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл байгаа эсэхийг шалгах шаардлагатай. ...Нэхэмжлэгчийн шүүхэд ирүүлсэн нэхэмжлэлд зээл, зээлийн хүү, нэмэгдүүлсэн хүү нь нийт нэхэмжилж буй үнийн дүнгээс зөрүүтэй байна. Мөн нэхэмжлэлд хавсарган ирүүлсэн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ баримтад О-г даргаар бүртгэв гэсэн байх бөгөөд нэхэмжлэл гаргасан Б нь нэхэмжлэгчийг шүүхэд төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхтэй эсэх нь нэхэмжлэлд хавсаргасан баримтуудаар тогтоогдохгүй байна. Энэ нь ИХШХШтХ-ийн 65.1.5-д заасан үндэслэл болно...” гэжээ.

БГДИХАШШ-ийн 2019.09.02-ны өдрийн 10655 дугаартай захирамжийн үндэслэх хэсэгт “Нэхэмжлэгч “Ц” ХХК-ийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй АНУ-ын иргэн Э нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд компанийг төлөөлүүлэхээр Б, Т нарт итгэмжлэл олгосон байх бөгөөд уг итгэмжлэлийн дагуу төлөөлөгчид шүүхэд нэхэмжлэл гаргажээ. Нэхэмжлэгч компанийн захирал Э нь монголоор бичигдсэн итгэмжлэлийн утга агуулга, үр дагаврыг ойлгосон эсэх, нэхэмжлэгч түүний хүсэл зоригийг бүрэн илэрхийлсэн, мэдсэн эсэхийг иргэний хэрэг үүсгэхээс өмнөх шатанд шүүх тогтоох боломжгүй юм. ИХШХШтХ-ийн 7.2 дахь хэсэгт заасан итгэмжлэлээ өөрийн эх хэл буюу мэддэг хэлээр үйлдэн, монгол хэл рүү орчуулж, нотариатаар гэрчлүүлэн ирүүлэхийг мэдэгдэх нь зүйтэй. Итгэмжлэлийг монгол хэлээр үйлдэж, англи хэл рүү орчуулсныг Э бүрэн ойлгосон гэж үзэхгүй болно. Иймд Б, Т нарыг нэхэмжлэгч “Ц” ХХК-ийг төлөөлж нэхэмжлэл гаргах эрх бүхий этгээд гэж үзэхгүй байх тул нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзав” гэжээ.

Иргэнийг  
төлөөлөх  
(ИХШХШТХ-ийн  
32, 33)

БГДИХАШШ-ийн 2019.01.25-ны өдрийн  
1459 дугаартай захирамжийн үндэслэх  
хэсэгт “Нэхэмжлэгч нь орон сууцны дээд  
айлаас ус алдсаны улмаас учирсан хохирол  
шаардаж байх боловч орон сууцны өмчлөгч  
нь нэхэмжлэгч биш байна. Харин түүний хүү  
өмчлөгч байна. Тиймээс нэхэмжлэгч тухайн  
орон сууцанд учирсан хохирлыг бусдаас  
нэхэмжлэх эрхтэй болох нь нэхэмжлэлд  
цугларсан баримтаар тогтоогдохгүй байгаа  
тул нэхэмжлэгчийг төлөөлөх бүрэн эрхгүй  
этгээд нэхэмжлэл гаргасан гэж үзэж хүлээн  
авахаас татгалзав” гэжээ.

*Дүгнэлт:* Нэхэмжлэгчийг төлөөлөх эрхгүй этгээд шүүхэд нэхэмжлэл гаргасан гэх үндэслэлийг тайлбарлахад иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэн болон хуулийн этгээдийн төлөөллийн ялгаатай асуудлууд хөндөгддөг. Тухайлбал, иргэний хувьд нотариатаар гэрчлүүлсэн итгэмжлэл, хуулийн этгээдийн хувьд хуульд заасан итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээдээс олгосон итгэмжлэлийг тус тус нэхэмжлэлд хавсаргасан байх шаардлагатай. Итгэмжлэлд хэнээс хэнд холбогдох иргэний хэрэгт эсхүл хэнд холбогдуулан нэхэмжлэл гаргах, цаашлаад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ямар эрх, үүрэг хэрэгжүүлж оролцох талаар тодорхой дурдсан байхыг шаарддаг. Итгэмжлэгдсэн төлөөлөгч нь итгэмжлэлээ нэхэмжлэлд хавсаргаагүй тохиолдолд шүүхээс нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл бүрддэг. Итгэмжлэлийг гадаадын иргэн, хуулийн этгээдийн монгол хэл мэдэх эсэхийг нь тогтоох боломжгүй этгээд гаргасан, гарын үсэг зурсан тохиолдолд түүнийг заавал баталгаат орчуулгаар орчуулж, нотариатаар гэрчлүүлэх хуулийн шаардлагыг ИХШХШТХ-ийн 7.4-т заасан. Дээрх захирамжуудад хуульд заасан шаардлагыг хангаагүй, хуулийг буруу, эргэлзээтэй тайлбарласан тохиолдол гараагүй боловч шүүгч хэлбэрийн бөгөөд хурдан хугацаанд засах боломжтой бүрдүүлбэрийн “жигжиг” алдаа байсан ч татгалзаж байгаа нь хугацаа тогтоож бүрдүүлбэр хангуулах хуулийн зохицуулалт байхгүйтэй шууд холбоотой байна.



*Хүснэгт 9-ийн үргэлжлэл*

Иргэнийг  
төлөөлөх  
(ИХШХШТХ  
32-34)

ХУДИХАШШ-ийн 2019.07.04-ний өдрийн 8241 дугаартай захирамжаар “Э-гийн шүүхэд гаргасан нэхэмжлэлээс үзэхэд түүний нөхөр нь хариуцагчийн харуулын ажилд орж, ХУД-ийн нутаг дэвсгэрт байрлах ... хотхоны харуулаар 2019.04.02-ны өдрөөс эхлэн ажилласан ба түүний цалинг дутуу олгосныг нэхэмжилсэн байна. Нөхрийнхөө өмнөөс Э нэхэмжлэл гаргасан байх боловч түүнийг төлөөлөх бүрэн эрхээ баталсан баримтгүй, өөрөөр хэлбэл, ИХ-д заасан хэлбэрийн шаардлага хангасан итгэмжлэлгүй тул бүрэн эрхгүй этгээд гэж үзнэ” гэх үндэслэлээр хүлээн авахаас татгалзсан.

ХУДИХАШШ-ийн 2019.08.09-ний өдрийн 9138 дугаар захирамжаар “Нэхэмжлэгчийн хүү Б нь 18 нас хүрснээр иргэний эрх зүйн бүрэн чадамжтай болсон байх тул үрчлэлтийг хүчингүйд тооцуулахыг хүссэн нэхэмжлэлийг өөрөө гаргах боломжтой байх тул түүний эх М нь түүнийг төлөөлөн нэхэмжлэл гаргасан нь хуульд нийцэхгүй байна. Учир нь үрчлүүлэгч Б нь Гэр бүлийн тухай хуулийн 61.1 дэх хэсэгт зааснаар үрчлэлтийг хүчингүйд тооцуулах тухай хүсэл зоригоо шүүхэд өөрөө хэрэгжүүлэх үүрэгтэй болно” гэж хүлээн авахаас татгалзсан.

*Дүгнэлт:* ИХШХШТХ-ийн 32 дугаар зүйлийн 32.1, 32.2 дахь хэсэгт заасны дагуу иргэн өөрийн биеэр юм уу төлөөлөгчөөрөө дамжуулан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоно. Төлөөлөл нь хуульд зааснаар эсхүл сайн дураар буюу гэрээгээр төлөөлөх хэлбэртэй байна. Иргэний хуульд заасан журмаар төлөөлөх гэдэг нь хууль ёсны төлөөлөгч болох эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нарт хамаарал бүхий ойлголт бөгөөд нэхэмжлэгчийн эрх зүйн чадамжтай салшгүй холбоотой. Иргэний эрх зүйн бүрэн чадамжтай иргэний хувьд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлөгчөөрөө дамжуулан эсхүл гэрээний үндсэн дээр өмгөөлөгчөөр төлөөлүүлж оролцох талаар ИХШХШТХ-иар зохицуулсан. Эрх зүйн бүрэн чадамжтай иргэний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсэн тохиолдолд иргэний ХХША-нд биечлэн оролцох боломжгүй тохиолдолд итгэмжлэлээр эсхүл гэрээний үндсэн дээр бусдаар төлөөлүүлэн оролцож болно.

Гэрлэгчид нь иргэний эрх зүйн харилцааны бие даасан субъектүүд байх тул хэн нэгний хуулиар хамгаалагдсан ашиг сонирхол нь зөрчигдсөний улмаас шүүхэд мэдүүлэх эрхээ биечлэн хэрэгжүүлэх боломжгүй тохиолдолд итгэмжлэлийн үндсэн дээр эхнэр эсхүл нөхөр нь ХХША-нд төлөөлөн оролцох тул “итгэмжлэл” авагдаагүй гэсэн үндэслэлээр хүлээн авахаас татгалзсан нь үндэслэлтэй байна. Мөн Гэр бүлийн тухай хуулийн 61.1-д зааснаар “үрчлэлтийг хүчингүйд тооцох тухай” нэхэмжлэлийг хүүхдийг төрүүлсэн эцэг, эх, сонирхогч бусад этгээд, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах байгууллага эсхүл 14 нас хүрсэн хүүхэд өөрийн хууль ёсны ашиг сонирхлоо шүүхээр хамгаалуулахаар мэдүүлэх эрхтэй. Үрчлэгдсэн хүүхэд 18 насанд хүрсэн тохиолдолд хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар биечлэн шүүхэд хандах эрхтэй бөгөөд хэрэв өөрөө ХХША-нд биечлэн оролцох боломжгүй тохиолдолд ИХШХШТХ-ийн 32.4-т заасны дагуу бусдаар төлөөлүүлэх эрх нээлттэй байна.

Хуулийн  
этгээдийг  
төлөөлөх  
(ИХШХШТХ-ийн  
35, 36)

СХДИХАШШ-ийн 2019.02.19-ний өдрийн 2107 дугаартай захирамжийн үндэслэх хэсэгт “Нэхэмжлэгч “А” ХХК-ийн захирал, БНХАУ-ын иргэн Ч-гээс тус компанийг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах зэрэг эрхийг олгосон итгэмжлэлийг 2019 оны 2 дугаар сарын 10-ны өдөр Ц-д олгосон байх боловч тэрээр өөрийн мэдэх хэл буюу хятад хэлээр олгосон итгэмжлэлийг баталгаат орчуулгын газраар орчуулуулсан байх шаардлагатай. Гэтэл нэхэмжлэлд монгол хэлээр бичсэн итгэмжлэлийг хятад хэлээр орчуулсан байгаа нь хуулийн шаардлага хангасан гэж үзэх боломжгүй байна. Иймд нэхэмжлэгч “А” ХХК-ийн үүсгэн байгуулагч Ц нь тус компанийг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхтэй болох нь баримтаар тогтоогдохгүй байх тул ИХШХШТХ-ийн 65.1.5-д зааснаар нэхэмжлэгчийг төлөөлөх бүрэн эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан үндэслэлээр хүлээн авахаас татгалзах үндэслэл болж байна” гэжээ.

СХДИХАШШ-ийн 2019.07.08-ны өдрийн 7941 дугаартай захирамжийн үндэслэх хэсэгт “А ХХК нь шүүхэд гаргасан нэхэмжлэлд захирал Д-гээр гарын үсэг зуруулсан буюу нэхэмжлэлийг төлөөлөх бүрэн эрхгүй этгээдээс гарсан байх тул хүлээн авахаас татгалзах үндэслэл болж байна. Нэхэмжлэлд хавсаргасан улсын бүртгэлийн гэрчилгээгээр “А” ХХК-ийн гүйцэтгэх захирал М болох нь нотлогдох бөгөөд иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд “А” ХХК-ийг төлөөлөх эрхийг Тусгай активын захирал Н, Байгууллагын банкны газрын захирал Б болон орлон ажиллаж байгаа ажилтанд олгосон байна. Д-д шүүхэд нэхэмжлэл гаргах эрх олгогдоогүй, түүнийг Салбар тооцооны төвийн захирал болохыг нотолсон баримтыг нэхэмжлэлд хавсаргаагүй” гэжээ.

2019.12.06-ны өдрийн 13895 дугаартай захирамжийн үндэслэх хэсэгт ““С” байгууллагын шүүхэд гаргасан нэхэмжлэлийг даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б гаргасан байх ба тэрээр тус байгууллагыг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй эсэхийг нотолсон баримтыг нэхэмжлэлд хавсаргаагүй байна. Тодруулбал, Б нь тус байгууллагыг төлөөлөх бүрэн эрхтэй талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэр, тушаал нэхэмжлэлд хавсаргагдаагүй байна” гэжээ.

*Дүгнэлт:* Хуулийн этгээдийг төлөөлж нэхэмжлэл гаргаж буй этгээд нь хуульд зааснаар итгэмжлэлгүйгээр төлөөлж буй эсхүл тухайн этгээдээс албан ёсны тамга, гарын үсгээр баталгаажсан бичгээр гаргасан итгэмжлэлийг шүүхэд үзүүлэх буюу нэхэмжлэлд хавсаргах шаардлагатай. ИХШХШТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэгт заасны дагуу итгэмжлэл олгож буй этгээд нь гадаадын иргэн буюу монгол хэл мэддэггүй бол итгэмжлэлийг эхлээд тухайн хүний мэддэг хэлээр гаргаж, түүнийг монгол хэл рүү баталгаат орчуулгаар орчуулуулан шүүхэд гаргаж өгөх шаардлагатай. Итгэмжлэлээр олгогдсон эрхийн хүрээнд нэхэмжлэл гаргаж байгаа тохиолдолд тухайн итгэмжлэл нь хуульд заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд хугацаа тогтоон бүрдүүлбэр хангуулснаар цаг хугацаа хэмнэх, улсын тэмдэгтийн хураамж дахин төлөх, шүүхэд дахин ирэх зардлыг багасгах эерэг талтай боловч манай улсын ИХШХШТХ-д энэ талаарх зохицуулалт байхгүй. Тиймээс хууль хэрэглэж шийдвэр гаргаж буй шүүхийг буруутгах боломжгүй.

Энэ төрлийн асуудлыг гадаад улсад зохицуулсан байдлыг дурдвал ОХУ-ын Арбитрын процессын тухай хуулийн 129 дүгээр зүйл, мөн тус улсын Иргэний процессын тухай хуулийн 135 дугаар зүйлд тус тус зааснаар “...нэхэмжлэлд гарын үсэг зурах эрх олгогдоогүй этгээд гарын үсэг зурсан” тохиолдолд

шүүхээс нэхэмжлэлийг буцаахаар журамласан. Нэхэмжлэгчээс олгосон итгэмжлэлд нэхэмжлэл гаргах эрхийг тодорхой заасан байхыг шаардах бөгөөд нэхэмжлэлийг буцаах тухай захирамж нь нэхэмжлэгчийн шүүхэд дахин нэхэмжлэл гаргахад саад болохгүй байхаар зохицуулсан.

*4. Бусад үндэслэлээр (ИХШХШТХ-ийн 65 дугаар зүйлийн 65.1.1, 65.1.3, 65.1.4, 65.1.6-65.1.10) нэхэмжлэл хүлээн авахаас татгалзсан байдал*

Шүүхээс нийтлэг бус буюу бусад үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан дараах тохиолдлуудыг харьцуулж дүгнэлт хийлээ.

**Хүснэгт 10. ИХШХШТХ-д заасан  
бусад үндэслэлээр гаргасан захирамж**

---

Хэргийн харьяалал зөрчсөн (ИХШХШТХ 65.1.1)	БГДИХАШШ-ийн 2019.10.16-ны өдрийн 13036 дугаартай захирамжийн үндэслэх хэсэгт “ИХШХШТХ-ийн 65.1.1-д энэ хуулийн 11.2-т хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, зохигчид харилцан тохиролцсон тохиолдолд арбитр шийдвэрлэнэ буюу хэргийн харьяалал зөрчсөн бол нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана. Талуудын хооронд байгуулсан гэрээнд Монгол Улсын Олон улсын арбитраар эцэслэн шийдвэрлэнэ гэж заасан байна. Иймд 65.1.1-д заасны дагуу хэргийн харьяалал зөрчсөн гэсэн үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзав” гэжээ.
--	---

---

БГДИХАШШ-ийн 2019.12.05-ны өдрийн 1626 дугаартай захирамжийн үндэслэх хэсэгт “ИХШХШТХ-ийн 133.1, 135.1, 135.2.10-т ...гэж тус тус заажээ. Нэхэмжлэгч нэхэмжлэлийн үндэслэлдээ гэрлэх зорилгогүйгээр гэрлэлтээ бүртгүүлсэн гэх боловч нэхэмжлэлийг Н-д холбогдуулан гаргасан нь тодорхойгүй. Хариуцагч ямар учраас юу хариуцах нь ойлгомжгүй байна. Хэрэв гэрлэгчид хэн хэн нь гэрлэх зорилгогүй гэрлэлтээ бүртгүүлсэн бол онцгой ажиллагааны журмаар эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоолгохоор хамтран нэхэмжлэл гаргана. Иймд ИХШХШТХ-ийн 65.1.1-д заасан үндэслэлээр нэхэмжлэгч А-гийн нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах нь үндэслэлтэй” гэжээ.

Шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлүүлэх талаар хуульд заасан журмыг нэхэмжлэгч зөрчсөн ба энэ журмыг хэрэглэх боломжтой байвал (ИХШХШТХ 65.1.3)

БГДИХАШШ-ийн 2019.05.24-ний өдрийн 6780 дугаартай захирамжийн үндэслэх хэсэгт “ИХШХШТХ-ийн 65.1.3-т ...гэж заасан. Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 12.1-д заасны дагуу уг маргааныг шийдвэрлэсэн зохих шатны шийдвэр нэхэмжлэлд хавсаргагдаагүй буюу урьдчилан шийдвэрлэх ажиллагаа хийгдээгүй байх тул нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах нь үндэслэлтэй байна. Дээрх шаардлагыг шүүхээс өөр байгууллага, албан тушаалтанд урьдчилан гаргаж, тус шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй” гэжээ.

Хүснэгт 10-ын үргэлжлэл

---

“... Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан ...шүүгчийн захирамж байгаа” ИХШХШТХ- ийн 65.1.6	БГДИХАШШ-ийн 2019.02.26-ны өдрийн 2623 дугаартай захирамжийн үндэслэх хэсэгт “П нь цагаатгалын нөхөн олговор 500,000 төгрөгийг нэмж олгуулах агуулга бүхий хүсэлтийг дараах үндэслэлээр хүлээн авахаас татгалзаж байна. Орхон аймгийн сум дундын шүүхийн 1999.06.02-ны өдрийн 638-р шийдвэрээр П-д цагаатгалын нөхөн олговорт 500,000 төгрөг олгохоор шийдвэрлэжээ. ИХШХШТХ-ийн 65.1.6 дахь хэсэгт заасны дагуу уг асуудлыг шийдсэн хүчин төгөлдөр шийдвэртэй байх тул уг асуудлыг хүлээн авахаас татгалзах нь зүйтэй байна” гэжээ.
Хариуцагчийн хаяг тодорхойгүй (ИХШХШТХ 65.1.9)	БГДИХАШШ-ийн 2019.11.21-ний өдрийн 14968 дугаартай захирамжийн үндэслэх хэсэгт “Тус шүүхийн шүүгчийн 2019.10.31-ний өдрийн 13817 дугаартай захирамжаар нэхэмжлэгч Э-гийн нэхэмжлэлтэй “Т” ХХК-д холбогдуулан гаргасан 235 сая төгрөг гаргуулах тухай нэхэмжлэлийг 65.1.11-д заасан үндэслэлээр хүлээн авахаас татгалзжээ. Нэхэмжлэгчийн 2019.11.18-ны өдөр гаргасан нэхэмжлэл нь шүүгчийн дээрх захирамжид заасан зөрчлийг арилгаагүй байх тул ИХШХШТХ-ийн 65.1.6 дахь хэсэгт заасан үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзав” гэжээ.
Хариуцагчийн хаяг тодорхойгүй (ИХШХШТХ 65.1.9)	БГДИХАШШ-ийн 2019.02.04-ний өдрийн 1913 дугаартай захирамжийн үндэслэх хэсэгт “Нэхэмжлэгч Д нь хариуцагч Ж-д холбогдох хүүхдийн тэтгэлэг тогтоолгох тухай нэхэмжлэлдээ хариуцагчийн хаягийг ЧД ... тоот гэж тодорхойлсон байна. Нэхэмжлэлд дурдсан хаягт хариуцагч нь бүртгэлтэй боловч оршин суудаггүй болохыг ЧД-ийн 19-р хорооны Засаг дарга тодорхойлж байх тул ИХШХШТХ-ийн 65.1.9-д заасны дагуу нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзав” гэжээ.

---

Зохигч хүн нас барсан (ИХШХШТХ 65.1.10)	БГДИХАШШ-ийн 9987 дугаартай хэсэгт “Хариуцагч нь гэрчилгээгээр ИХШХШТХ-ийн 65.1.10-т нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах нь зүйтэй” гэжээ.	2019.08.14-ний өдрийн захирамжийн үндэслэх нь 2018.10.17-ны өдөр нас тогтоогдож байх тул заасан үндэслэлээр	
---	--	---	--

*Дүгнэлт:* Хэргийн харьяалал зөрчсөн буюу захиргааны шүүхийн эсхүл захиргааны байгууллагын харьяалан шийдвэрлэх маргаан, хуулиар тухайлсан ажиллагаа явуулсны дараа шүүхэд хандахаар заасан тохиолдол, түгээмэл тохиолдолд гэрлэлт цуцлах болон хөдөлмөрийн маргаан, өмнө нь тухайн асуудлыг шийдвэрлэсэн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр байгаа, эрүүгийн журмаар шийдвэрлэж байгаа гэх үндэслэлүүдээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан захирамжуудад илт эсхүл эргэлзээтэй байдлаар хуулийг хэрэглэсэн, тайлбарласан зүйл ажиглагдаагүй. Харин өмнө нь тухайн нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан шүүгчийн захирамж гарсан нь хүчин төгөлдөр буюу захирамжид заасан алдааг засаагүй байна гэх үндэслэлээр хүлээн авахаас татгалзах тохиолдолд яагаад алдааг засаагүй гэж үзэж байгааг тодорхой тайлбарлаагүй захирамжууд байсан. Практикт нэхэмжлэл хүлээн авахаас татгалзсан тохиолдолд нэхэмжлэлийг дахин гаргахад тухайн шүүгчид хуваарилагддаг бөгөөд өмнө гаргасан гэх захирамж нь өөр шүүгчийнх биш учраас алдааг яагаад засаагүй гэж үзэж буйгаа товч бус, ойлгомжтой, тодорхой тайлбарлах шаардлагатай. Баянгол дүүргийн шүүхийн хувьд бусад дүүргээс ялгагдаж байсан онцлог нь нийт нэхэмжлэлийн 50-иас илүү хувийг хүлээн авахаас татгалзаж буй үндэслэл нь ИХШХШТХ-ийн 65 дугаар зүйлийн 65.1.9-д заасан “хариуцагчийн хаяг тодорхойгүй” байдал юм. Энэ нь үндсэн хоёр төрөлд хуваагдаж байна. Нэгдүгээрт, хариуцагч нэхэмжлэлд бичсэн хаягт огт оршин сууж байгаагүй, суудаггүй; хоёрдугаарт тухайн хаягт бүртгэлтэй боловч амьдардаггүй. Шүүхээс хариуцагчийн хаягийг тодруулах ажиллагааг тухайн дүүргийн хорооны Засаг даргаас тодорхойлолт авах, шүүхийн бичиг хүргэгчээр шалгуулах замаар явуулахдаа тэдгээрийн тодорхойлолт, тэмдэглэлд үндэслэдэг.



Ийнхүү хариуцагчийн хаяг тодорхойгүй гэх үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан захирамжид үндэслэн нэхэмжлэгч дахин “иргэний эрх зүйн маргаанд хариуцагчаар оролцвол зохих этгээдийг эрэн сурвалжлуулах” ажиллагааг өөрийн оршин суугаа газрын шүүхэд хүсэлт гаргах замаар явуулж болно. Практикт нэхэмжлэгч дээрх үндэслэлээр хүлээн авахаас татгалзсан захирамжаа шүүхээс ирж аваад өөрийн оршин суугаа газрын шүүхэд гаргахад бас л хүлээн авахаас татгалзсан тохиолдол цөөнгүй байна. Нэхэмжлэлийг хариуцагчийн хаяг тодорхойгүй гэх үндэслэлээр хүлээн авахаас татгалзаж буй тохиолдолд энэ талаар нэхэмжлэгчид мэдэгдэж, хүсэлтийг үндэслэн УТХ-ийг нэмж төлүүлэх замаар иргэний эрх зүйн маргаанд хариуцагчаар оролцвол зохих этгээдийг эрэн сурвалжлуулах ажиллагааг үргэлжлүүлэн явуулах боломжийг ИХШХШТХ-д тусгах нь оновчтой юм. Хуулийн зохицуулалтын дагуу иргэний хэрэг үүсгэсний дараа хариуцагчийн хаяг тодорхойгүй бол хэргийг түдгэлзүүлж, эрэн сурвалжлах ажиллагаа явуулдаг. Яг үүнтэй ижлээр нэхэмжлэлийг хүлээн авах шатанд хариуцагч нэхэмжлэлд дурдсан хаягт оршин суудаггүй, хаана оршин суугаа нь тодорхойгүй тохиолдолд нэхэмжлэгчийн оролцоо, тусламжтайгаар хариуцагчыг эрэн сурвалжлах боломж бий болговол шүүхэд мэдүүлэх эрхийг хангахад чухал хувь нэмэр болох юм.

Хэргийн  
харьяалал  
зөрчсөн  
(ИХШХШТХ  
65.1.1)

СХДИХАШШ-ийн 2019.11.07-ны өдрийн 12514 дугаартай захирамжийн үндэслэх хэсэгт “Эрх зүйн чадамжгүй хүнд асран хамгаалагч тогтоох асуудлыг сум, дүүргийн Засаг дарга шийдвэрлэх бөгөөд Гэр бүлийн тухай хуулийн 66, 67 дугаар зүйлд заасныг үндэслэсэн, шүүхийн харьяалан шийдэх маргаан биш юм” гэжээ.

Шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлүүлэх талаар хуульд заасан журмыг нэхэмжлэгч зөрчсөн ба энэ журмыг хэрэглэх боломжтой байвал (ИХШХШТХ 65.1.3)

СХДИХАШШ-ийн 2019.02.26-ны өдрийн 2623 дугаартай захирамжийн үндэслэх хэсэгт “Гэр бүлийн тухай хуулийн 14.1-д зааснаар гэрлэлт цуцлах асуудлаар эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах боломжгүйгээс бусад тохиолдолд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явагдсаны дараа шүүх иргэний хэрэг үүсгэнэ гэж заажээ. ИХШХШТХ-ийн 65.1.3-т зааснаар буюу “шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх талаар хуульд заасан журмыг нэхэмжлэгч зөрчсөн” үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах нь зүйтэй гэж үзлээ. Нэхэмжлэлд хавсаргасан БЗДИХАШШ-ийн эвлэрүүлэн зуучлагчийн 2018.02.26-ны өдрийн 24 дугаартай “Эвлэрүүлэн зуучлал хэрэглэхээс татгалзах тухай тэмдэглэл” гэх баримтад “Уулзалтад оролцсон А нь “О-г гадаадаас ирсэн үед гэрлэлт цуцлуулах асуудлаа ярилцана, итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй энэ асуудлыг ярилцахгүй” гэсэн тайлбар гаргасан гэсэн үндэслэлээр эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулах боломжгүй байна” гэсэн нь тухайн маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулсан гэж үзэх боломжгүй байна” гэжээ.

Хариуцагчийн хаяг тодорхойгүй (ИХШХШТХ 65.1.9)

СХДИХАШШ-ийн 2019.07.08-ны өдрийн 7492 дугаартай захирамжийн үндэслэх хэсэгт “Нэхэмжлэлд дурдсан СХД-ийн 22-р хороонд “Н” ХХК-ийн захирал Б бүртгэлтэй боловч одоогоор оршин суудаггүй. СХД-ийн 19-р хороо, 21-р хороолол, 240 айлын орон сууц хаягт хариуцагч оршин байдаггүй нь СХД-ийн 19, 22-р хорооны Засаг даргын тодорхойлолтоор тодорхойлогдож байна. Иймд хариуцагчийн хаяг тодорхойгүй тул нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж байна” гэжээ.

*Дүгнэлт:* Судлагдсан захирамжийн талаас илүү хувь нь шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлүүлэх талаар хуульд заасан журмыг нэхэмжлэгч зөрчсөн ба энэ журмыг хэрэглэх боломжтой байсан гэх үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзжээ. Зарим шүүгчийн захирамжид хүлээн авахаас татгалзаж буй үндэслэлээ ойлгомжтой, тодорхой тайлбарласан бол зарим шүүгчийн захирамжид огт тайлбарлаагүй эсхүл ойлгомжгүй тайлбарласан байна. Тухайлбал, нэхэмжлэгчид хариуцагчийн хаяг яагаад тодорхойгүй гэж үзэж байгааг тайлбарлахдаа хариуцагчийн хаягийг хэрхэн тодруулах боломжтой талаар буюу алдаагаа яаж засах талаар огт тайлбарлаагүй. Эвлэрүүлэн зуучлалын ажиллагаа явагдсан гэж үзээгүй бол эвлэрүүлэн зуучлагчид дахин хандах, татгалзах ямар үндэслэл байдгийг тодорхой, ойлгомжтой тайлбарлаагүй.

Гэр бүлийн тухай хуулийн 14.1, 14.4-т заасны дагуу гэрлэгчдийн харилцан тохиролцсон буюу тэдний хэн нэгний эсхүл иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй гэж тооцогдсон эхнэр, нөхрийн асран хамгаалагчийн нэхэмжлэлтэй болон гэрлэгчдийн хэн нэгний байнгын хүчирхийлэл, дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд ноцтой хохирол учирч болзошгүй эсхүл учирсан нь тогтоогдсон тохиолдолд гэр бүл цуцлах тухай маргаантай хэргийг шүүх шийдвэрлэнэ. Харин гэрлэлт цуцлах бусад үндэслэлээр гаргасан нэхэмжлэлийг шүүх хүлээн авахаас татгалзана. Өөрөөр хэлбэл, шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх журмаар тухайн маргааныг эвлэрүүлэн зуучлагч шийдвэрлэх болно.<sup>41</sup>

ОХУ-ын Арбитрын процессын тухай хуулийн 127 дугаар зүйл, мөн тус улсын Иргэний процессын тухай хуулийн 134 дугаар зүйлд тус тус зааснаар “хэргийн харьяалал зөрчсөн”, “нэхэмжлэлд заасан талуудын хоорондын маргаан, нэхэмжлэлийн зүйл, нэхэмжлэлийн шаардлага, түүний үндэслэлийн талаар өмнө нь шийдвэрлэсэн (ердийн шүүх,

<sup>41</sup> Монгол Улсын Дээд шүүх, Гэр бүлийн маргаантай хэргийг хянан шийдвэрлэхэд анхаарах зарим асуудлуудын талаар (Тойм), 2013.12.23. <http://www.supremecourt.mn/act/view/58> 2021.04.15-ны өдөр мэдээлэл авав.

арбитрын шүүх) шийдвэр хүчин төгөлдөр байгаа эсхүл хялбаршуулсан журмаар хэргийг шийдвэрлэж хэрэгсэхгүй болгосон, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан захирамж байгаа”, “арбитрын шүүхээс хөндлөнгийн арбитрын (Третейский суд) шийдвэрийг хүчингүй болгосон эсхүл шийдвэр гүйцэтгэх хуудас олгохоос татгалзсанаас бусад нэхэмжлэлд заасан талууд хоорондын маргаан, нэхэмжлэлийн зүйл, нэхэмжлэлийн үндэслэлийн талаар шийдвэрлэсэн хөндлөнгийн арбитрын (Третейский суд) шийдвэр байгаа” гэсэн гурван үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалздаг. Нэхэмжлэлд заасан маргааныг Үндсэн хууль болон эрүүгийн журмаар шийдвэрлэхээр, өмнө нь тухайн маргааныг шийдвэрлэсэн хүчин төгөлдөр шийдвэр байгаа тохиолдолд ердийн (арбитрын) шүүхээр иргэний маргааныг шийдвэрлэх боломжгүй тул тухайн нэхэмжлэлийг дахин гаргах эрхгүй болохыг шүүгчийн захирамжид зайлшгүй дурддаг. ОХУ-ын Иргэний процессын кодекс болон Арбитрын процессын кодекс “хариуцагчийн хаяг тодорхойгүй” гэсэн үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах зохицуулалт байхгүй. Харин нэхэмжлэгч нь ердийн (арбитрын) шүүхэд нэхэмжлэл гаргахдаа нэхэмжлэл, түүнд хавсаргасан баримтын хуулбарыг хариуцагчийн хаягаар баталгаат шуудангаар илгээх бөгөөд илгээсэн баримтыг нэхэмжлэлд хавсаргасан байх шаардлага тавигддаг.

## **2.2. НЭХЭМЖЛЭЛ ХҮЛЭЭН АВАХАД СААД БОЛСОН ЗӨРЧЛИЙГ ХЭРХЭН ЗАСАХЫГ ЗААХ ШҮҮХИЙН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ**

Нэхэмжлэл хүлээн авахаас татгалзах тухай зарим захирамжид ИХШХШтХ-ийн 65 дугаар зүйлийн 65.2-т заасны дагуу нэхэмжлэлийг хүлээн авахад саад болж буй нөхцөл, түүнийг арилгах арга замыг огт тусгалгүй эрх зүйн алдаа гаргасан тохиолдол цөөнгүй байв. Ямар учраас нэхэмжлэлийг

хүлээн авч иргэний хэрэг үүсгэх боломжгүй байгаа, нэхэмжлэл гаргахдаа ямар алдаа дутагдал гаргасан, хэрхэн яаж засаж залруулах боломжтойг шүүгчийн захирамжид дурдах нь иргэн, хуулийн этгээдээс шүүхэд мэдүүлэх эрхээ хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой. “Нэхэмжлэлийг хэрхэн мэдүүлэх эсхүл шүүх түүнийг хүлээн авахад саад болж байгаа зөрчлийг хэрхэн засах”-ыг дурдсан захирамжийн хувьд:

- Захирамжийн үндэслэх хэсэгт: “...Шүүгчийн захирамжид заасан зөрчлөө арилгаж харьяалах шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй болно” эсхүл “...Энэхүү шүүгчийн захирамжаар буцаан олгогдож буй УТХ-ийг уг захирамжийн дагуу улсын орлогоос буцаан авч, шүүхэд дахин нэхэмжлэл гаргахдаа УТХ шинээр төлж нэхэмжлэлдээ хавсаргах ба нэхэмжлэлийн үндэслэл, шаардлагаа тодруулж, дахин шүүхэд мэдүүлэх эрхээ хэрэгжүүлэхэд энэ шүүгчийн захирамж саад болохгүйг дурдах нь зүйтэй” гэсэн байна.
- Захирамжийн захирамжлах хэсэгт: “Нэхэмжлэлийг хүлээн авахад саад болж буй зөрчлийг арилган шүүхэд дахин нэхэмжлэл гаргах эрхтэйг дурдсугай” гэж заасан байна.

ИХШХШТХ-ийн 65 дугаар зүйлийн 65.2 дахь хэсэгт заасан нөхцөлийг шүүгчийн захирамжид хэрхэн яаж тусгах талаар хууль хэрэглээний нэгдмэл байдал хангагдахгүй байгаа нь тухайн нөхцөлийг шүүгчийн захирамжид огт дурдахгүй үлдээх, захирамжийн үндэслэх хэсэгт эсхүл захирамжлах хэсэгт заахгүй байгаагаар илэрч байна. Нэхэмжлэлийг шүүхэд хэрхэн мэдүүлэх, шүүх түүнийг хүлээн авахад саад болж байгаа зөрчлийг хэрхэн засахыг зааж өгөх нь ХХША дахь шүүгчийн үйл ажиллагаанд хамаарна.

ОХУ-ын Арбитрын процессын кодексын 128.2, 129.2 дахь хэсэг, мөн тус улсын Иргэний процессын тухай хуулийн 135.2, 136.1 дахь хэсэгт заасны дагуу “нэхэмжлэлийг буцаах”, “нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулах” захирамжид иргэний хэрэг үүсгэхэд саад болж буй нөхцөл байдал, түүнийг хэрхэн арилгах арга замыг заахаар зохицуулсан бөгөөд нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулах захирамжийн хувьд нэмэлт хугацааг захирамжаар тогтоохоор хуульчилсан. Монгол Улсын ИХШХШТХ-ийн 62 дугаар зүйлийн 62.2 дахь хэсэгт нэхэмжлэлийг шүүхэд хэрхэн мэдүүлэх, иргэний хэрэг үүсгэхэд саад болж буй зөрчлийг хэрхэн арилгахыг заах талаар зохицуулсан боловч хуулиар журамласан зохицуулалтыг хэлбэр төдий хэрэглэсэн эсхүл хэрэглэхгүй байгаа шүүхийн практик үүссэн байх тул “хуулийн хэрэглээний нэгдмэл байдлыг хангах” зарчмын хүрээнд хуулийг нэг мөр хэрэгжүүлэх шаардлагатай байна.

### **2.3. НЭХЭМЖЛЭЛ ХҮЛЭЭН АВАХААС ТАТГАЛЗСАН ЗАХИРАМЖИД ГОМДОЛ ГАРГАСАН, ТҮҮНИЙГ ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ**

ИХШХШТХ-ийн 170 дугаар зүйлийн 170.1 дэх хэсэгт зааснаар нэхэмжлэгчийг төлөөлөх бүрэн эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан тохиолдолд тухайн шүүгчийн захирамжид нэхэмжлэгч, түүний төлөөлөгч болон өмгөөлөгч гомдол гаргах эрхтэй. Гэтэл БГДИХАШШ-ийн 2019.01.5-ны өдрийн 1459, 2019.02.04-ний өдрийн 1897, 2019.03.01-ний өдрийн 2766, 2019.03.04-ний өдрийн 2859, 2019.10.02-ны өдрийн 12339, 2021.11.01-ний өдрийн 12895 дугаартай захирамжийн захирамжлах хэсэгт тус хуулийн заалтыг үндэслэсэн боловч гомдол гаргах эрхгүй талаар дурдсан нь хуульд заагаагүй үндэслэлээр нэхэмжлэгч, түүний өмгөөлөгч болон төлөөлөгчийн

гомдол гаргах эрхийг хязгаарласан байна. Шүүхээс дээрх заалтад дурдсан гомдол гаргах эрхтэй үндэслэл дээр нэмж нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангаагүй нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан захирамжид гомдол гаргах эрхтэйгээр эсхүл эрхгүйгээр, ихэвчлэн улсын тэмдэгтийн хураамж төлөөгүй гэх үндэслэлээр хүлээн авахаас татгалзсан тохиолдолд гомдол гаргах эрхтэй байхаар тус тус ялгаатай хэрэглэсэн. Энэ нь нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангаагүй үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан тус шүүхийн нийт захирамжийн 10 гаруй хувийг эзэлж байна.

БГДИХАШШ-ийн нэхэмжлэл хүлээн авахаас татгалзсан захирамжид гаргасан гомдлыг хянан хэлэлцэж шийдвэрлэсэн нийт 17 захирамжийн 50 хувьтай танилцахад нийт захирамжийн 60 хувийг хүчингүй болгож, иргэний хэрэг үүсгүүлэх тогтоол гаргасан байна. Тухайлбал, тус шүүхийн шүүгчийн 2019.08.08-ны өдрийн 9795 дугаар захирамжийг хүчингүй болгож шийдвэрлэсэн 2019.08.22-ны өдрийн 306 дугаар тогтоолын үндэслэх хэсэгт “Тус шүүхийн 2019.02.12-ны өдрийн 449 дүгээр шийдвэрээр Б-гийн нэхэмжлэлд Э-д холбогдох иргэний хэргийг хянан хэлэлцээд гэрлэгчдийн гэрлэлтийг цуцалж, хүүхдүүдийн асрамжийг тогтоож, нэхэмжлэгчийн гэрээнд заасан шаардлагаасаа татгалзсаныг болон талууд эд хөрөнгийн маргаангүй талаар дурдаж шийдвэрлэсэн бөгөөд шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр байна. Дээрхээс үзвэл нэхэмжлэгч нь гэрлэгчдийн эд хөрөнгийн талаар харилцан тохиролцсон 2018.12.13-ны өдрийн гэрээнээс татгалзаагүй байх бөгөөд харин шаардлагаасаа татгалзсан байна. Өөрөөр хэлбэл, нэхэмжлэгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүх гэрээнээс буюу хуулийн дагуу үүсэх гэрээний харилцаанаас татгалзсан гэж үзсэн нь үндэслэлгүй болжээ. Иймд үндэслэл шаардлагыг тодруулахгүйгээр нэхэмжлэлд дурдсан үйл баримтын талаар хуулийн хүчин төгөлдөр шийдвэр байгаа

үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан нь үндэслэлгүй байна” гэжээ.

ИХШХШТХ-д нэхэмжлэл хүлээн авахаас татгалзах захирамжид гомдол гаргах эрхтэй байхаар заасан зохицуулалтын дагуу нэхэмжлэгч гомдол гаргаж, үндэслэлтэй гомдлыг хангах замаар шүүгчийн “үндэслэлгүй” захирамжийг хүчингүй болгож буй нь хуулийн зохицуулалт үр дүнтэй хэрэгжиж буйн илрэл юм. Гэвч ИХШХШТХ-д шүүхээс нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулах хугацаа тогтоолгүй шууд хүлээн авахаас татгалздаг, татгалзсан захирамжид гомдол гаргах эрхгүйгээр зохицуулсан. Тиймээс нэхэмжлэгч шүүхэд дахин нэхэмжлэл гаргах эсэх нь шүүгч захирамждаа хүлээн авахаас татгалзсан үндэслэл болон алдаагаа хэрхэн засахыг хэр сайн, ойлгомжтой тайлбарласантай шууд холбогдож байна. Шүүгчийн мэдлэг болон хуулийг үндэслэлтэй, зөв, ойлгомжтой тайлбарлах ур чадвар нь манай улсын иргэний процессын хууль тогтоомжийн дагуу нэхэмжлэгч шүүхэд мэдүүлэх эрхээ хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна.

Үүнтэй холбогдуулан нэхэмжлэл хүлээн авахаас татгалзах захирамжид гомдол гаргах эрхийн талаарх харьцуулсан судалгааны хүрээнд ХБНГУ, Япон Улс болон ОХУ-ын хуулийн зохицуулалтыг авч үзье.

ОХУ-ын Арбитрын процессын тухай хуулийн 127.5, 128.4 дэх хэсэг, ОХУ-ын Иргэний процессын тухай хуулийн 134.3, 135.3 дахь хэсэгт тус тус заасны дагуу шүүхээс “нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах” эсхүл “нэхэмжлэлийг буцаах” захирамж гаргасан тохиолдолд нэхэмжлэгч харьяаллын давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхийг хуульчилж, шүүхэд мэдүүлэх эрхийг баталгаажуулжээ.

ХБНГУ-ын иргэний нэхэмжлэл гаргах, түүнийг хүлээн авахаас татгалзахтай холбоотой Иргэний процессын хуулийн



зохицуулалтаар нэхэмжлэлийн төрөл буюу эрх зүйн аль харилцаанд хамаарах маргаанаас шалтгаалж нэхэмжлэгч өөрөө нэхэмжлэл гаргах эсхүл зөвхөн мэргэжлийн хуульчаар төлөөлүүлж гаргах боломжийг зохицуулсан. Нэхэмжлэгч өөрөө эсхүл төлөөлүүлэгчээр дамжуулан гаргаж байгаагаас үл хамаарч нэхэмжлэл хуульд заасан шаардлагыг хангаагүй бол засах хугацаа тогтоож, засаагүй тохиолдолд гомдол гаргах эрхгүйгээр шийдвэрлэдэг. Мөн шүүгч талуудын маргааныг шийдвэрлэхэд хөндлөнгийн байх боловч процессын шаардлагыг хангуулахад талуудыг удирдан чиглүүлж, зөвлөн туслах үүрэгтэй оролцож байгаа нь процессыг хялбар болгох, талуудад зөвхөн хэрэг, маргааны агуулга, үндэслэлдээ төвлөрөх үр дагавар бий болгосон.

Япон Улсын Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 137 дугаар зүйлд нэхэмжлэгчийн гаргасан гомдол буюу нэхэмжлэл нь тус хуулийн 133.2 дахь хэсэгт заасан гомдолд тусгах зүйлсийг тусгаагүй эсхүл төлбөл зохих тэмдэгтийн хураамжийг төлөөгүй зөрчилтэй байвал алдааг залруулах боломжит хугацааг тодорхойлж, тогтоосон уг хугацааны дотор алдаагаа залруулахыг нэхэмжлэгчид санал болгохоор заасан. Нэхэмжлэгч дээрх алдааг залруулаагүй бол даргалагч шүүгч нь гомдлыг хүлээн авахаас татгалзсан захирамж гаргах ба уг шүүгчийн захирамж гарсан даруй нэхэмжлэгч гомдол гаргах эрхтэй байхаар тус тус хуульчилжээ. Үүнээс гадна нэхэмжлэгч нь шүүгчийн саналын дагуу алдаагаа зассан нь хангалтгүй тохиолдолд даргалагч шүүгч нэхэмжлэгчид дахин нэг удаа алдаагаа залруулахыг даалгана. Даргалагч шүүгч нь шүүхийн бичиг хэргийн ажилтнаар дамжуулан шаардлагатай залруулга хийхийг нэхэмжлэгчээс шууд шаардаж болно. Нэхэмжлэгч нь нэхэмжлэл болон түүний төлбөрийн хэмжээг тодорхойлон тогтоох эрх, үүрэгтэй бөгөөд шүүх нэхэмжлэгчийн шаардсан хэмжээнээс илүү төлбөр гаргуулах шийдвэр гаргах учиргүй

гэж тайлбарласан байна.<sup>42</sup> Хуулийн дээрх зохицуулалт нь нэхэмжлэгчийн эрх ашгийг хамгаалсан уян хатан, тодорхой, хэнд ч ойлгомжтой, үр дүнтэй байх бөгөөд шүүхийн процесс удаашрах эсэх нь шүүхээс бус нэхэмжлэгчээс шууд хамаарах үр дагавар бий болгосон. Нэхэмжлэгч өөрөө шуурхай, хариуцлагатай байвал нэхэмжлэл гаргах процесст хүндрэл учрахгүй нь илэрхий байна.

---

<sup>42</sup> Outline of civil procedure in Japan, 2020, Supreme Court of Japan. /[https://www.courts.go.jp/english/vc-files/courts-en/file/Outline\\_of\\_Civil\\_Procedure\\_in\\_JAPAN\\_2020.pdf/](https://www.courts.go.jp/english/vc-files/courts-en/file/Outline_of_Civil_Procedure_in_JAPAN_2020.pdf/) (Accessed date: 09 April 2021).

## ДҮГНЭЛТ

Иргэн, хуулийн этгээдийн “шүүхэд мэдүүлэх эрх”-ийг хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хязгаарлаж буй эсэхийг иргэний шүүх дэх нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан шүүгчийн захирамжид дүн шинжилгээ хийх замаар судлан, шүүхийн практикт үүсэж буй асуудлын үндсэн шалтгаан, нөхцөлийг илрүүлж, гадаадын зарим улсын эрх зүйн зохицуулалттай харьцуулан судаллаа.

Судалгааны хүрээнд улсын хэмжээнд нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан 9,737 тохиолдлоос нийслэлийн төвийн дөрвөн дүүрэгт хамаарах 5,264 тохиолдлыг эх олонлог гэж үзэж, түүний 13 хувь болох 685 захирамжтай танилцан, 95 хувийн итгэх магадлалтай тооцооллын үндсэн дээр түүвэрт дүн шинжилгээ хийн, дараах дүгнэлтийг танилцуулж байна.

- Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан шүүхээр хамгаалуулах эрхийг иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэгжүүлэх суурь нөхцөл болгож Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн гуравдугаар зүйлд “Шүүхэд мэдүүлэх эрх” гэж зохицуулсан. Тиймээс Монгол Улсын хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзэж байгаа аливаа этгээд уг эрхээ хамгаалуулахаар тус хуульд заасан журмын дагуу шүүхэд нэхэмжлэл,

хүсэлт, гомдол гаргах замаар шүүхэд мэдүүлэх эрхээ хэрэгжүүлж байна.

- Иргэн, хуулийн этгээдээс шүүхэд гаргасан нэхэмжлэл, гомдол, хүсэлтийг хүлээн авахаас татгалзах шийдвэр гаргахдаа зөвхөн хуульд заасан нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэлийг баримтлах, хуулийн заалтыг үндсэн агуулгаас нь өөрөөр тайлбарлаж хэрэглэхгүй байх, онцгой ажиллагааны журмаар шийдвэрлүүлэх хүсэлт, гомдлоор авч хэлэлцэх хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны журмын дагуу хүлээн авахаас татгалзах тохиолдолд тухайлсан журмын зохицуулалтыг зөв хэрэглэж хэвших шаардлагатай байна. Учир нь нэхэмжлэлийг хүлээн авахаас үндэслэлгүйгээр татгалзсан шийдвэрийн улмаас хууль хэрэглээний ялгаатай байдал бий болох, зөрчигдсөн эрхээ шүүхийн журмаар хамгаалуулах боломжгүй, цаг хугацааны болоод эдийн засгийн хувьд давхар хохирол үүсгэж буй нь иргэн, хуулийн этгээдийн шүүхэд мэдүүлэх эрх зөрчигдөх үндэслэл болж байна.
- Нэхэмжлэл хүлээн авахад саад болсон зөрчлийг хэрхэн засахыг заах шүүхийн үүргийн тухайд ихэнх шүүгч нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж байгаа захирамждаа “Нэхэмжлэгч дээрх зөрчлийг арилган дахин шүүхэд нэхэмжлэл гаргах эрх нь нээлттэй” гэсэн тайлбар бичиж байгаа ч зарим шүүгч уг эрхийн талаар огт дурдахгүй, дурдсан зарим тохиолдолд ямар учраас зөрчил болж байгаа гэдгийг огт тайлбарлахгүй эсхүл зөрчлийн талаар тайлбарлахдаа жирийн иргэн уншаад ойлгохгүй байдлаар дурдсан явдал цөөнгүй байна. Эдгээрийн үр дагавраар нэхэмжлэгч шүүхэд дахин нэхэмжлэл гаргах эрхгүй гэж төөрөгдөх, захирамжид заасан тайлбарыг ойлгоогүйн улмаас өмнөх алдаагаа

дахин давтаж, түүнийг нь шүүгч хүлээн авахаас дахин татгалзсан тохиолдлууд судалгааны явцад харагдав.

- ИХШХШТХ-д заасны дагуу нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах нийт үндэслэлээс татгалзсан тохиолдолд нэхэмжлэгч тухайн шүүгчийн захирамжийг “хянуулахаар” гомдол гаргах боломжтой үндэслэлүүд байгаа боловч энэ процесс нь төдий л үр дүнтэй биш байна. Учир нь гомдол гаргах эрхгүй байхаар заасан үндэслэл болох “хариуцагчийн хаяг тодорхойгүй”, “нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангаагүй” буюу түүн дотор “нэхэмжлэлийн үндэслэл, шаардлага тодорхойгүй”, “улсын тэмдэгтийн хураамж дутуу төлсөн, төлөөгүй, илүү төлсөн, буруу дансанд тушаасан” зэрэг тохиолдолд ямар ч эргэлзээгүйгээр хүлээн авахаас татгалзан, нэхэмжлэгч дахин нэхэмжлэл гаргахын тулд УТХ-аа дахин шинээр төлж шүүхэд хандах шаардлагатай болдог. Энэ процесс нь ИХШХШТХ-ийг 2002 онд батлагдсанаас хойш огт өөрчлөгдөөгүй 19 жилийн турш үргэлжилсэн бөгөөд өөрчлөх зайлшгүй шаардлагатай болох нь судалгааны явцад тогтоогдсон.
- ИХШХШТХ-ийн 65 дугаар зүйлийн 65.2 дахь хэсэгт нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах захирамжид уг нэхэмжлэлийг хэрхэн мэдүүлэх эсхүл шүүх түүнийг хүлээн авахад саад болж байгаа зөрчлийг хэрхэн засахыг зааж өгнө гэх зохицуулалтыг шүүгчид нэг мөр хэрэглэхгүй байгаа нь ажиглагдав. Судалгааны хүрээнд танилцсан зарим захирамжид нэхэмжлэл дахин гаргах эрхийн талаар огт дурдаагүй, бусад захирамжийн үндэслэл хэсэгт эсхүл захирамжлах хэсэгт гэх зэргээр ялгаатай дурдсан байв. Нэхэмжлэл дахин гаргах эрхийг захирамжид дурдаагүйн үр дагавраар шүүхэд хандаж буй этгээд шүүхэд дахин хандалгүй, асуудлаа

шийдүүлэхгүй орхих, зөрчигдсөн эрхээ шүүхээр хамгаалуулж, сэргээлгэж чадахгүй үлдэх эрсдэлтэй байна.

- ИХШХШТХ-ийн 170 дугаар зүйлийн 170.1 дэх хэсэгт зааснаар шүүхийн харьяалал зөрчсөн гэх үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан тохиолдолд тухайн шүүгчийн захирамжид нэхэмжлэгч, түүний төлөөлөгч болон өмгөөлөгч гомдол гаргах эрхтэй. Судалгааны явцад танилцсан захирамжуудын захирамжлах хэсэгт тус хуулийн заалтыг үндэслэсэн боловч гомдол гаргах эрхгүй байхаар дурдсан тохиолдлууд гарсан бөгөөд эдгээр нь шүүгчид яг ижил хуулийн заалтыг буруу тайлбарлаж, хэрэглэснээс иргэдэд тэгш бус байдал үүсгэсэн байна.
- Нэхэмжлэгч УТХ-аас чөлөөлүүлэх хүсэлтээ гаргасан ч “хангалттай” баримтаар нотлоогүй тохиолдолд “холбогдох” баримтуудыг хавсаргаж ирүүлэх талаар зарим шүүгчийн захирамжид ерөнхий, тодорхой бус байдлаар тусгаж байна. Хэрэв шүүхээс нэхэмжлэгчийн хавсаргаж ирүүлсэн баримтыг хангалтгүй гэж үзэж байгаа бол хаанаас, ямар бичиг баримтуудыг гаргаж ирүүлэх ёстойг тодорхой дурдах нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чухал зорилгуудын нэг боловч ихэнх тохиолдолд зөрүүтэй байдлаар захирамжид дурдаж байна.
- Хэргийн онцлог эсхүл нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах, дахин нэхэмжлэл гаргах хоёр үйл явдлын хооронд богино хугацаа өнгөрсөн байх, хураамжийн хэмжээ их байх зэрэг шалтгаанаар нэхэмжлэгчийн дээрх ажиллагааг шүүх зөвшөөрч байгаа тохиолдолд УТХ-ийг буцаасан шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолын заалтыг хэрхэх тухай шүүхийн шийдвэрт

заах шаардлагатай талаар Улсын Дээд шүүхийн зөвлөмжид тусгасан байдаг. Гэсэн хэдий ч судалгааны явцад шүүгчийн захирамжид хугацаа тогтоон, тогтоосон хугацаанд нэхэмжлэлийн алдаагаа засаж нэхэмжлэлээ дахин гаргах бол хуучин баримтаа ашиглаж болох талаар дурдсан нэг ч захирамж гараагүй байна. Энэ нь хуульд тухайлан заасан зохицуулалт байхгүйтэй шууд холбоотой байж болох юм.

- Монгол Улсын иргэн, хуулийн этгээдээс Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй гадаад улсын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газар эсхүл гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, оршин суугаа гадаадын иргэнд холбогдуулан гаргаж буй нэхэмжлэлийн хувьд заавал тухайн хүний мэддэг хэл рүү нь баталгаат орчуулагчаар орчуулуулан өгөх үүрэг хүлээхгүй юм. ИХШХШТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.2, 7.4 дэх заалтууд нь зөвхөн гадаад хэлээр бичсэн баримт бичгүүдийн хүрээнд хэрэглэгдэхээр байна. Гэтэл монгол хэлээр гаргаж буй баримт бичгээ шүүхэд гаргахдаа орчуулж өгөөгүй гэх үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, тухайн захирамжид гомдол гаргах эрхгүй захирамж гаргасан тохиолдол байна. Энэ нь шүүгчийн мэдлэг, ур чадварын дутмаг байдлын үр дагавраар шүүхэд мэдүүлэх эрх зөрчигдөж байгаагийн жишээ болж байна.
- Шүүх нэхэмжлэгчээс мэргэжлийн түвшний агуулгатай, тодорхой нэхэмжлэл гаргаж тавихыг шаардаж, энгийн иргэн шүүхэд хандахад төвөгтэй байдал үүсгэж байна. Тухайлбал, өөрийгөө нэхэмжлэгч гэж тодорхойлоод нэхэмжлэл гаргаж өгсөн байхад баримтуудаар та нэхэмжлэгч мөн эсэх нь эргэлзээтэй байна гэж, эсхүл юу шаардаж байгаагаа бичсээр байхад илүү тодорхой

болго гэх мэтээр хуульд байхгүй шаардлагууд тавьж хүлээн авахаас татгалзсан тохиолдлууд гарсан байна. Энэ нь шүүхэд мэдүүлэх эрхийг хангах үзүүлэлтүүдийн нэг болох процессын ажиллагааг хүндрэл төвөггүй, ойлгомжтой, тодорхой болгож, маргааныг шийдвэрлэхэд төвлөрөх бус зөрчигдсөн эрхээ хамгаалуулан сэргээлгэх гэж буй иргэнд процессын ойлгомжгүй бөгөөд хэлбэрийн хэтийдсэн шаардлага тавьж нэхэмжлэлийг нь хүлээж авахгүй буцаан, шүүхэд дахин дахин ирж очих зардлыг нэмэгдүүлж, хугацаа алдах сөрөг үр дагаврууд бий болгож байна.

- ИХШХШТХ-д шүүхээс нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулах хугацаа тогтоолгүй хүлээн авахаас шууд татгалзаж, татгалзсан захирамжид гомдол гаргах эрхгүйгээр зохицуулсан. Тиймээс нэхэмжлэгч нэхэмжлэлээ шүүхэд дахин гаргах эсэх нь шүүгч захирамждаа хүлээн авахаас татгалзсан үндэслэл болон алдаагаа хэрхэн засахыг хэр сайн ойлгомжтой тайлбарласантай шууд холбогдож байна. Шүүгчийн мэдлэг болон хуулийг үндэслэлтэй, зөв, ойлгомжтой тайлбарлах ур чадвар нь манай улсын иргэний процессын хууль тогтоомжийн дагуу нэхэмжлэгч шүүхэд мэдүүлэх эрхээ хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байх тул тэдний мэдлэг, ур чадварыг сайжруулж, ижил түвшинд байлгах зайлшгүй шаардлагатай байна.



## САНАЛ

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль нь 2002 онд батлагдсан бөгөөд Улсын дээд шүүхээс нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзахад анхаарах талаар холбогдох зөвлөмж гарган хэрэгжүүлж байгаа хэдий ч иргэний хэрэг үүсгэх шатанд аливаа этгээдийн шүүхэд мэдүүлэх эрх зөрчигдсөөр байна. Судалгаанаас үзэхэд ИХШХШтХ нь иргэний хэрэг үүсгэх, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах харилцааг бүрэн зохицуулж чадахгүй байгаа тул тус хуулийн “Нэхэмжлэл гаргах, түүнийг хүлээн авах” бүлэгт дараах агуулга бүхий зохицуулалтыг нэмэлт, өөрчлөлтөөр оруулах санал гаргаж байна. Үүнд:

- ИХШХШтХ-ийн 62 дугаар зүйлд заасан “Нэхэмжлэлийн бүрдүүлбэр”-ийн зохицуулалтыг “Нэхэмжлэлийн агуулгад тавигдах шаардлага” болон “Нэхэмжлэлд хавсаргах баримтууд” гэсэн хоёр хэсэгт хуваах замаар хэн бүхэнд ойлгомжтой байдлаар нэхэмжлэлийн бүрдүүлбэрийг хуульд тодорхойлж, шүүхээс шаардах баримтуудын хамрах хүрээг тогтоох;
- Нэхэмжлэгч нь нэхэмжлэлийг шүүхэд гаргахаас эхлэн өөрийн бүхий л эрх, үүргийг итгэмжлэлээр төлөөлөгчид шилжүүлсэн тохиолдолд итгэмжлэгдсэн төлөөлөгчийг ИХШХШтХ-ийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэгт заасны дагуу “нэхэмжлэгч” гэж үзэж, нэхэмжлэгчийн

итгэмжлэгдсэн төлөөлөгч өөрийн хаягаар шүүхэд хандах эрхтэй байх зохицуулалтыг зайлшгүй тусгах;

- Нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангаагүй гэж хүлээн авахаас шууд татгалзах бус, нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулахаар хугацаа тогтоох зохицуулалтыг нэмэлтээр оруулах нь зүйтэй. Нэхэмжлэлд хэлбэрийн, богино хугацаанд засах боломжтой бүрдүүлбэрийн жижиг алдаа байсан ч татгалзаж байгаа нь хугацаа тогтоож бүрдүүлбэр хангуулах хуулийн зохицуулалт байхгүйтэй шууд холбоотой. Тиймээс шүүх нэхэмжлэлийг хүлээн авч хянахдаа бүрдүүлбэр хангах хугацаа тогтоодог байх хуулийн зохицуулалтыг ИХШХШтХ-д оруулах нь шүүхэд мэдүүлэх эрхийг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэхээр байна. Тиймээс нэмэлтээр тогтоосон хугацаанд нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангаагүй тохиолдолд нэхэмжлэлийг буцаах зохицуулалтыг хуульчлах;
- Нэхэмжлэлд дурдсан хариуцагчийн хаяг тодорхойгүй буюу тухайн хаягт бүртгэлгүй, бүртгэлтэй боловч оршин суудаггүй тохиолдолд энэ талаар нэхэмжлэгчид мэдэгдэж, түүний хүсэлтийг үндэслэн УТХ-ийг нэмж төлүүлэх замаар иргэний эрх зүйн маргаанд хариуцагчаар оролцвол зохих этгээдийг эрэн сурвалжлуулах ажиллагааг үргэлжлүүлэн явуулах боломжийг ИХШХШтХ-д тусгах нь оновчтой юм. Одоогийн хуулийн зохицуулалтаар иргэний хэрэг үүсгэсний дараа хариуцагчийн хаяг тодорхойгүй бол хэргийг түдгэлзүүлж эрэн сурвалжлах ажиллагаа явуулдагтай адил нэхэмжлэлийг хүлээн авах процесст нэхэмжлэлд дурдсан хаягт хариуцагч оршин суудаггүй, хаана оршин суугаа нь тодорхойгүй бол нэхэмжлэгчийн тусламжтайгаар иргэний эрх зүйн маргаанд хариуцагчаар оролцвол зохих

этгээдийг эрэн сурвалжлах боломж бий болговол шүүхэд мэдүүлэх эрхийг хангахад чухал хувь нэмэр болох юм.

- ИХШХШТХ-ийн 65 дугаар зүйлд заасан нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэлүүдийн эрх, үр дагаврын ялгааг гаргах замаар иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны “нэхэмжлэлийг буцаах”, “нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах” үндэслэлийг ялгаатай тодорхойлох;
- Шүүгч нар ИХШХШТХ-ийн 65 дугаар зүйлийн 65.2 дахь хэсэгт нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах захирамжид уг нэхэмжлэлийг хэрхэн мэдүүлэх эсхүл шүүх түүнийг хүлээн авахад саад болж байгаа зөрчлийг хэрхэн засахыг тодорхой, ойлгомжтой зааж өгч буй шүүгчийн ажиллагаа нь шүүгчийн хараат бус байх зарчимд нийцнэ гэх агуулгаар зохицуулалтыг өөрчлөн найруулах нь зүйтэй. Дахин нэхэмжлэл гаргах эрхийг захирамжид дурдаагүй эсхүл ойлгомжтой тайлбарлаагүйн үр дагавраар шүүхэд хандаж буй этгээд шүүхэд дахин хандалгүй, асуудлаа шийдүүлэхгүй орхих, зөрчигдсөн эрхээ шүүхээр хамгаалуулан сэргээлгэж чадахгүй үлдэх эрсдэлтэй байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн “Шүүхийн зардал, улсын тэмдэгтийн хураамж” бүлэгт дараах агуулгыг тусгасан нэмэлт оруулах:

- ТХ-ийг буцаасан шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд ямар тохиолдолд УТХ төлсөн баримтыг дахин ашиглах талаар заах.

## АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Монгол Улсын Үндсэн хууль, УБ., 1992.
2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, УБ., 2002.
3. Иргэний хууль, УБ., 2002.
4. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль, УБ., 2011.
5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, УБ., 2017.
6. Гэр бүлийн тухай хууль, УБ., 1999.
7. Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлүүлэх тухай хууль, УБ., 2018.
8. Хөдөлмөрийн тухай хууль, УБ., 1999.
9. Ц.Амарсайхан, Ж.Амарсанаа, Л.Атарцэцэг болон бусад, Процессын эрх зүй: онол, туршлага, УБ., 2014.
10. Б.Буянхишиг, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй, УБ., 2021.
11. Монгол Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхим, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар, УБ., 2014.
12. Ханнс-Зайделийн сангийн дэргэдэх Эрх зүйн боловсролын академи, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, УБ., 2009.
13. Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүн таслах ажиллагааны тайлан, 2019.
14. Шүүхийн ерөнхий зөвлөлийн Судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн, “Шүүхэд итгэх иргэдийн итгэл” санал асуулгын судалгааны тайлан, 2017 оны 8-р сар.

15. Монгол Улсын Дээд шүүх, 2018 онд улсын хэмжээнд хянан шийдвэрлэсэн иргэний хэрэг, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тойм.  
<http://www.supremecourt.mn/act/view/260>
16. Монгол Улсын Дээд шүүхийн Зөвлөмж, Нэхэмжлэлийн үндэслэл, шаардлагыг тодорхойлоход анхаарах зарим асуудал, 2016.02.01, №1.  
<http://www.supremecourt.mn/act/view/>
17. Монгол Улсын Дээд шүүхийн Зөвлөмж, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь улсын тэмдэгтийн хураамжийн асуудал, №4, 2012.12.24. <http://www.supremecourt.mn/act/view/61>
18. Монгол Улсын Дээд шүүх, Гэр бүлийн маргаантай хэргийг хянан шийдвэрлэхэд анхаарах зарим асуудлуудын талаар (Тойм), 2013.12.23. <http://www.supremecourt.mn/act/view/58>
19. For comprehensive surveys cf. Dütz, Rechtsstaatlicher Gerichtsschutz im Privatrecht, 1970; Lorenz, Der grundrechtliche Anspruch auf effektiven Rechtsschutz, AöR 105 (1980), 623; Papier, §176: Justizgewähranspruch, in: Isensee/Kirchhof (Hrsg.), Handbuch des Staatsrechts, Bd. VIII, 3. Aufl. 2010, дам эшилсэн.
20. Rosenberg/Schwab/Gottwald, Zivilprozessrecht, 17. Aufl. 2010, §3 Rn. 1 with further references, дам эшилсэн.
21. BVerfGE 88, 118 (124); Maunz/Dürig/Grzeszick, Grundgesetz-Kommentar, 69. Ergänzungslieferung 2013, Art. 20 Rn. 134, BVerfGE 88, 118 (124), дам эшилсэн.
22. Murray/Stürner, German Civil Justice (2004) 166-177 with further references, дам эшилсэн
23. Gaier, Der moderne liberale Zivilprozess, NJW 2013, 2871 f, дам эшилсэн.
24. BVerfGE 69, 381 (385 f.); 91, 176 (181); 101, 397 (404), For controversies about the extent of this constitutional fair trial guarantee cf. Rosenberg/Schwab/Gottwald (note 4), §1 Rn. 30, дам эшилсэн.

25. European Justice, Ordinary courts – Germany, [https://e-justice.europa.eu/content\\_ordinary\\_courts-18-de-maximizeMS-en.do?member=1](https://e-justice.europa.eu/content_ordinary_courts-18-de-maximizeMS-en.do?member=1)
26. Конституция Российской Федерации (принята всенародным голосованием 12.12.1993). URL:<https://legalacts.ru/doc/Konstitucija-RF/razdel-i/glava-2/statja-46/>
27. Арбитражный процессуальный кодекс Российской Федерации от 24.07.2002 N 95-ФЗ. URL:[http://www.consultant.ru/document/cons\\_doc\\_LAW\\_37800](http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_37800)
28. Гражданский процессуальный кодекс Российской Федерации, 14.11.2002 N 138-ФЗ. [http://www.consultant.ru/document/cons\\_doc\\_LAW\\_39570](http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_39570)
29. С.М.Шахрай, А.А.Клишас, Конституционное право Российской Федерации, М., 2011.
30. National Report: Japan, the Right to Access to Justice and Public Responsibilities by Tkuya Hatta, International Association of Procedural Law Seoul Conference, 2014.
31. Outline of civil procedure in Japan, 2020, Supreme Court of Japan. [https://www.courts.go.jp/english/vc-files/courts\\_en/file/Outline\\_of\\_Civil\\_Procedure\\_in\\_JAPAN\\_2020.pdf/](https://www.courts.go.jp/english/vc-files/courts_en/file/Outline_of_Civil_Procedure_in_JAPAN_2020.pdf/)



# 2

## ЦАЛИН ХӨЛСНИЙ МАРГААНЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ШИНЖИЛГЭЭ

### СУДЛААЧИЙН ТАНИЛЦУУЛГА



#### БАДРАЛЫН АНХЗАЯА

Их засаг их сургуулийг 2009 онд төгсөж, 2013 онд МУИС-ийн Хууль зүйн сургуульд эрх зүйн магистрын зэрэг хамгаалсан хуульч, өмгөөлөгч. МҮЭХ-ны хуулийн зөвлөхөөр ажлын гараагаа эхэлж иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн зөвлөгөө өгөх, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх зэргээр ажилтны эрх ашгийг хамгаалах чиглэлд ажилласан туршлагатай. Одоогоор мэргэжлийн дагуу хуулийн этгээдэд ажиллахын сацуу хувь хүнийхээ хувьд нийгмийн хариуцлагын хүрээнд зорилтот бүлгийн иргэдэд эрх зүйн мэдлэг олгох төсөл, хөтөлбөрт сургагч багш, судлаачаар ажиллаж байна.



#### ЦОГТСАЙХАНЫ УЯНГА

Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэд хэрэгжиж буй “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах” төслийн хөдөлмөр эрхлэлт, хүртээмж хариуцсан мэргэжилтэн.

ХБНГУ-д улс төрийн шинжлэх ухааны магистрын зэргийг 2009 онд, Австралийн Засгийн Газрын тэтгэлгээр Австралид хөдөлмөрийн эрх зүйн магистрын зэргийг 2017 онд тус тус хамгаалсан. 2009 оноос хойш Үйлдвэрчний эвлэлийн чадавхыг бэхжүүлэх, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх, боловсролын чанарын ялгааг багасгах, ядууралд өртсөн хүүхдүүдийн эрх ашгийг хамгаалах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг сайжруулах гэх мэт асуудал хөндсөн төсөл, хөтөлбөрт ажиллаж байна.

Судлаачид:

Б.Анхзаяа  
Эрх зүйн магистр

Ц.Уянга  
Хөдөлмөрийн эрх  
зүйн магистр



## **АГУУЛГА**

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ .....	113
НЭГ. УДИРТГАЛ .....	114
ХОЁР. ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ .....	118
2.1. Цалин хөлс олгохгүйгээр хөдөлмөр эрхлүүлсэнтэй холбоотой маргаан .....	119
2.2. Ажлаас үндэслэлгүй халснаас үүссэн олговрын маргаан .....	139
2.3. Цалин хөлс бууруулах сахилгын шийтгэл оногдуулсантай холбоотой маргаан .....	143
2.4. Шүүх цалин хөлстэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэхдээ хэргийг урьдчилан хянан шийдвэрлүүлсэн байх шаардлагыг хэрэглэж байгаа байдал .....	155
ГУРАВ. НЭГДСЭН ДҮГНЭЛТ .....	163
ДӨРӨВ. НОМ ЗҮЙ .....	167

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ХтХ	Хөдөлмөрийн тухай хууль
ИХШХШтХ	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
ХМТК	Хөдөлмөрийн маргаан таслах комисс
ЗтХ	Зөрчлийн тухай хууль
ЗШШтХ	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ЭЗтХ	Эвлэрүүлэн зуучлах тухай хууль

## **НЭГ. УДИРТГАЛ**

Хөдөлмөрийн эрх зүйн харилцаа нь иргэн бүр оролцох боломжтой, амьдралын чанараа дээшлүүлэх орлогын эх сурвалжаа баталгаажуулж байдаг чухал ач холбогдолтой суурь харилцаа юм. Манай улсад хөдөлмөрийн харилцаа болон түүнтэй холбоотой бусад салбарын харилцаа (тухайлбал, нийгмийн хамгааллын салбар) төдий л судлагдахгүй байгаагийн улмаас иргэдийн хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилт, хөдөлмөрийн аюулгүй байдал хангагдах харилцаанд ахиц, дэвшил гарах нь удаан байна.

Сүүлийн таван жилийн статистик мэдээллээс харахад хөдөлмөрийн маргаанд цалин хөлстэй холбоотой маргааны эзлэх хувь хэмжээ багасахгүй байна (График 1-ийг харна уу). Түүнчлэн хөдөлмөрийн маргааны ангилал, Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан цалин хөлс авах эрхтэй холбоотой маргааны хувь, хэмжээ мөн шүүх цалин хөлстэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэхдээ хуулийг нэг мөр хэрэглэж байгаа эсэх, Хөдөлмөрийн тухай хуульд заасан маргааныг урьдчилан хянан шийдвэрлэх механизмын хэрэгжилт ямар түвшинд байгаа зэрэгт дүн шинжилгээ хийх хэрэгцээ шаардлага нэмэгдэж байгаа нь энэхүү судалгааг хийж гүйцэтгэх урьдчилсан нөхцөл болов.



Эх сурвалж: Шүүхийн ерөнхий зөвлөлийн судалгааны тайлан  
<http://www.judoinstitute.mn>

Хөдөлмөрийн ганцаарчилсан маргааныг Хөдөлмөрийн тухай хууль (ХтХ)-ийн 128 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлэхээр зохицуулсан байдаг. Хэрэв харьяаллын бус маргаанаар шүүхэд хандвал Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (ИХШХШТХ)-ийн 65 дугаар зүйлийн 65.1.3-т зааснаар шүүгч нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан захирамж гаргадаг. Цалин хөлстэй холбоотой маргаан нь хуулиар шүүхийн харьяаллын маргааны төрөлд ордоггүй (ХтХ-ийн 128 дугаар зүйл). Харин Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (ИХШХШТХ)-ийн 65 дугаар зүйлийн 65.1.3-ын дагуу урьдчилан хянан шийдвэрлүүлэх механизм буюу Хөдөлмөрийн маргаан таслах комисс (ХМТК) эсхүл Зөрчлийн тухай хууль (ЗтХ)-ийн 10.16 дугаар зүйлийн 9.2 дахь хэсэг, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль (ЗШШТХ)-ийн 6.10 дугаар зүйлийн дагуу мэргэжлийн хяналтад хандахаар тусгажээ. Бодит байдалд ХМТК байхгүй тохиолдолд иргэд цалин хөлстэй холбоотой асуудлаар мэргэжлийн хяналтын байгууллагад ханддаг бөгөөд

тэд ихэнх тохиолдолд шууд шүүхэд нэхэмжлэл гаргахыг зөвлөдөг<sup>1</sup> тул цалин хөлстэй холбоотой маргаан шүүхэд очдог байна. Судалгааны хүрээнд хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан буюу цалин хөлстэй холбоотой маргаан шүүхийн өмнөх шатанд хэрхэн шийдвэрлэгдэж байгааг болон энэхүү үйл явц нь ямар асуудлуудтай тулгарч байгаа талаар авч үзсэн болно.

Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ХтХ 1999 онд батлагдсан бөгөөд уг хуулийн шинэчилсэн найруулга 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдөр батлагдан 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс үйлчлэхээр болсон. Энэхүү судалгаагаар авч үзсэн маргааны зүйл нь ХтХ-ийн шинэчилсэн найруулгад тусгалаа олсон. Харин энэхүү судалгаа нь шинээр батлагдсан хуулийн хэрэгжилт, хэрэглээнд хувь нэмэр болно гэж найдаж байна.

Бид судалгаандаа цалин хөлстэй холбоотой маргааныг сонгон авч тухайн маргааныг шийдвэрлэхдээ шүүх хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хэрхэн хангаж байгаад дүн шинжилгээ хийсэн бөгөөд судлагдахуунаа дараах байдлаар ангилан авч үзсэн юм. Үүнд:

1. Цалин хөлс олгохгүй эсхүл хугацаанд нь олгоогүй ажил хөдөлмөр эрхлүүлсэнтэй холбогдон үүссэн хэрэг маргааны шийдвэрлэлт;
2. Ажлаас үндэслэлгүй халснаас үүссэн нөхөн олговрын маргаан;
3. Цалин хөлс бууруулах сахилгын шийтгэл оногдуулсан хэрэг маргааны шийдвэрлэлт;
4. Цалин хөлстэй холбогдсон маргааныг хянан шийдвэрлэхдээ ХтХ-д заасан хэргийг урьдчилан хянан шийдвэрлүүлэх хуулийн шаардлагыг шүүх хэрхэн хэрэглэж байгаа байдал зэрэг болно.

<sup>1</sup> Монголын Үйлдвэрчний Эвлэлийн дэргэдэх Хуульч өмгөөлөгчдийн багийн гишүүн М.Саранцацралтай хийсэн уулзалтын тэмдэглэл.

Шүүхийн шийдвэрээс түүвэрлэлт хийхдээ хуульч Л.Галбаатарын гаргасан Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх товч зөвлөмж<sup>2</sup> болон “Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх аргачлал”<sup>3</sup>-ыг баримтлан (i) анхан, давах, хяналтын шатны шүүхээр шийдвэрлэсэн хэрэг; (ii) хамгийн их тохиолдож буй маргааны төрөл; (iii) хувийн хэвшил дэх хөдөлмөрийн маргаан; (iv) сүүлийн хоёр жилийн дотор шийдвэрлэсэн байх зэрэг шалгуураар хэрэг маргааныг түүвэрлэн сонголоо.



---

<sup>2</sup> Л.Галбаатар, Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх арга зүй, УБ., 2020.

<sup>3</sup> Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн, Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх аргачлал, УБ., 2015.

## **ХОЁР. ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийхдээ арга зүйн хувьд Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх аргачлал болон бусад эх сурвалжийг<sup>4</sup> жишиг болгон ашигласан ба шүүхийн шийдвэрийг шинжлэхдээ формаль болон материаллаг шаардлагын хүрээнд хянаж үзэв.

Формаль шаардлагад дараах хоёр шалгуурыг авч үзлээ. Үүнд:

1. Шүүх хэргийг хуульд заасан харьяаллын дагуу шийдвэрлэсэн эсэх;
2. Хөөн хэлэлцэх хугацаандаа гомдол гаргасан маргааныг хүлээн авч шийдвэрлэсэн эсэх.

Маргаан аль шатандаа эцэслэн шийдэгдсэнээс хамааран материаллаг шаардлагыг хангасан эсэхийг дараах гурван бүлэг зүйл заалтын хүрээнд үнэлж шалгав. Үүнд:

1. Анхан шатны шүүх шийдвэр гаргахдаа хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий гарсан эсэх<sup>5</sup> нотлох баримтыг ИХШХШтХ-ийн 40 дүгээр зүйлд заасны дагуу үнэлсэн эсэх;

<sup>4</sup> Ц.Давхарбаяр (Ph.D), Үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөлд холбогдох шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ, "Шүүх эрх мэдэл" сэтгүүл, 2020, Дугаар 2.

<sup>5</sup> ИХШХШтХ-ийн 116 дугаар зүйлийн 116.2, 2002.

2. Давж заалдах шатны шүүх шийдвэр гаргахдаа ИХШХШТХ-ийн 168 дугаар зүйлд заасан хэм хэмжээг баримталсан эсэх;
3. Хяналтын шатны шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн, холбогдох хууль тогтоомжийг буруу тайлбарлаж хэрэглэсэн эсэх (ИХШХШТХ-ийн 172.2.1)<sup>6</sup>.

## 2.1. ЦАЛИН ХӨЛС ОЛГОХГҮЙГЭЭР ХӨДӨЛМӨР ЭРХЛҮҮЛСЭНТЭЙ ХОЛБООТОЙ МАРГААН

Цалин хөлс олгоггүй хөдөлмөр эрхлүүлсэн эсхүл цалин хөлсийг хугацаанд нь олгоогүй тухай маргааныг 2015 оноос хойш шүүхээр хянан шийдвэрлэж буй байдалд дүн шинжилгээ хийхэд нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож буй үндэслэл нь ихэнх тохиолдолд ажилтан өөрийгөө тухайн байгууллагад ажиллаж байсан буюу хөдөлмөрийн харилцаанд орсноо баталгаажуулж чадахгүйд оршиж байна.

Тэгвэл шүүхээс гомдлыг хэрэгсэхгүй болгоход баримталж буй үндэслэл болох хөдөлмөрийн харилцаа үүссэн эсхүл үүсээгүй гэх асуудлын тухайд хууль тогтоомжийн хүрээнд болон судлаач, хуульч, шүүгчдийн хувьд өөр өөр байр суурьтай болох нь харагдаж байна. Тухайлбал, ХтХ-д хөдөлмөрийн харилцаа гэж юуг хэлэх, тус харилцаа хэзээ үүсэх талаар нарийвчилсан зохицуулалт тусгаагүй боловч хуулийн зорилтод “Энэ хуулийн зорилт нь хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр хөдөлмөрийн харилцаанд оролцогч ажилтан, ажил олгогчийн нийтлэг эрх, үүрэг, хамтын гэрээ, хэлэлцээр, хөдөлмөрийн ганцаарчилсан ба хамтын маргаан, хөдөлмөрийн нөхцөл, удирдлага, хяналт болон хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг тодорхойлж

<sup>6</sup> ИХШХШТХ-ийн 172 дугаар зүйлийн 172.2.3 дахь заалт, 2021 оны 1 дүгээр сарын 15-ны өдрөөс “Шүүх хуулийг Улсын Дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн” гэж өөрчлөгдсөн.



талуудын харилцан эрх тэгш байдлыг хангахад оршино” гэж зааснаас үзэхэд хөдөлмөрийн албан ёсны харилцаа хөдөлмөрийн гэрээ байгуулсан цаг үеэс үүсдэг байна гэж үзэж болохоор байна. Мөн хөдөлмөрийн эрх зүйн салбарын дагнасан судлаачдын нэг, доктор Б.Уранцэцэг үүнийг тодорхойлохдоо дээрхээс арай өргөн агуулгаар буюу “Хөдөлмөрийн хууль тогтоомжоор зохицуулагдаж буй хөдөлмөрийн харилцааг л хөдөлмөрийн эрх зүйн харилцаа гэж үзнэ” хэмээжээ.<sup>7</sup>

Эндээс дүгнэвэл хөдөлмөрийн эрх зүйн харилцаа нь хөдөлмөрийн гэрээ байгуулагдсан үеэс эхлэн ХтХ-ийн 4 дүгээр зүйлд тусгагдсан субъектүүдийн хооронд үүсдэг харилцаа байна. Энэхүү хөдөлмөрийн эрх зүйн харилцаанд үндэслэн ажил олгогч, ажилтны хооронд үүссэн цалин хөлс олгоогүй гэх маргааныг шүүхийн зүгээс хэрхэн хянан шийдвэрлэж байгаад дүн шинжилгээ хийлээ.

### **Тохиолдол №1: Дөрвөн сарын хугацаанд ажилласан цалин хөлс гаргуулах маргаан<sup>8</sup>**

**Хэргийн үйл баримт:** Нэхэмжлэгч нь 2015 оны 4 дүгээр сараас 8 дугаар сар хүртэл ажилласан хугацааныхаа цалин хөлс болон хариуцагчийг эрэн сурвалжлуулахад гаргасан зардал нийт 2,072,000 төгрөгийг хариуцагчаас гаргуулах шаардлага бүхий нэхэмжлэлийг шүүхэд гаргасан. Нэхэмжлэгч нэхэмжлэлдээ “Г.Г би “ЮМ Э Т Э” Англи хэлний зуны вакум сургалтын төвд захирал Б.Т-тэй 2015 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр менежер албан тушаалд нэг сарын 650,000 төгрөгийн цалинтайгаар харилцан тохиролцон ажилд орсон. Тус сургалтын төвд 2014 оны зун хөдөлмөрийн гэрээ байгуулан 500,000

<sup>7</sup> Б.Уранцэцэг, “Эрх зүй ба эдийн засаг” (Илтгэл, шийдвэрийн эмхэтгэл), “Хөдөлмөрийн хуулийн тухай шинэчлэл ба шүүхийн практик” илтгэл, УБ., 2018, 53 дахь тал.

<sup>8</sup> Ажилласан хугацааны цалин хөлсөнд 2072000 төгрөг гаргуулах тухай, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх, 2016 оны 03 дугаар сарын 19-ны өдөр, Дугаар 2419, шүүх нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. Эх сурвалж: Шүүхийн шийдвэрийн цахим сан [www.shuukh.mn](http://www.shuukh.mn)

төгрөгийн цалинтай ажиллаж байсан тул 2015 оны 4 дүгээр сард хөдөлмөрийн гэрээ байгуулах хүсэлт удаа дараа тавьсан боловч байгуулаад хэрэггүй, итгэлцлийн үндсэн дээр ажилла гэх зэргээр хэлдэг байсан. Зуны дөрвөн сарын турш ойролцоогоор 70-80 хүүхдийн эцэг, эхтэй сургалтын төвийг төлөөлөн гэрээ байгуулж, сургалтын төлбөр тооцоо нь надаар дамжин хийгдэж, бас зарим тохиолдолд хүүхдүүдийн мөнгө Б.Т-гийн данс руу бас миний данс руу ордог байсан, би түүнийг захиралд өгдөг байсан. Түүнчлэн сургалтын төвийн оффисын бүх албан бичиг боловсруулах, явуулах болон байгууллагатай гэрээ хийн зуслангийн хоол хүнс цуглуулах, эд хогшил хүлээлгэн өгөх, хүүхдүүдийн сертификат, медаль хийлгэх, хэвлэх, хүүхдүүдийг автобус, унаагаар би хүргэж өгч авдаг... гэх мэт бүх ажлыг хийдэг байсан тул дөрвөн сарын цалин болох 2,000,000 төгрөгийг хариуцагчийг эрэн сурвалжлуулсан зардал болох 70,200 төгрөг нийт 2,072,000 төгрөг гаргуулна” хэмээн дурдсан байна.

Хариуцагчийн зүгээс “Түүний нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөхгүй. Миний бие 2010 оноос эхлэн “ЮМ Э Т Э” ХХК-ийн “УМ” боловсролын төвийг ажиллуулж ирсэн ба зуны гурван сарын хугацаанд англи хэлний вакум сургалт зохион байгуулж явуулдаг бөгөөд 2014 оны зунаас эхлэн Г.Г манай оффист туслан гүйцэтгэгчээр ажиллаж байсан. 2015 оны 5 дугаар сарын 16-ны Бямба гарагт зуслангийн эхний ээлж явах төлөвлөгөө гарган ажилласан боловч улаан бурхан өвчин дэлгэрч бүх зуслан нэг сарын хугацаатай үйл ажиллагаагаа хойшлуулах тухай Нийслэлийн захирамжийн дагуу манай үйл ажиллагаа хойшилсон тул Г.Г-г нэг сар ажиллуулаагүй. 2015 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс ажил эхэлсэн ба Г.Г-гийн сарын цалингийн хэмжээг 650,000 төгрөгөөр бус сарын 500,000 төгрөгөөр тохирч ажиллуулахаар болсон. Учир нь зуны улирлын гурван сар ажиллах тул үндсэн ажилтан хэрэггүй, хөлсөөр ажиллах хүн хэрэгтэй гэсний дагуу ажиллахаар болж 2015 оны 6 дугаар сарын 20-ны өдөр эхний ээлжийн

хүүхдүүдийг бүртгэн, үйл ажиллагаа эхлэхэд Г.Г-гийн дансаар мөн миний дансаар бэлнээр гэх мэтээр тооцоо орж ирсэн боловч 420,000 төгрөгийн дутагдал гарсан. Мөн өдрийн сургалтад хамрагдсан таван хүүхдийн сургалтын төлбөрийн үлдэгдэл болох 469,500 төгрөг дансаар авна гэж гэрээ хийсэн боловч 10 хоног амраад ирэх хүртэл Г.Г нь сургалтын төлбөрийг нэхэмжилж аваагүй тул компани алдагдалд орсон. Г.Г нь 2015 оны 6 дугаар сарын цалингаа өөрийн дүүг нутаг буцна гэсэн шалтгаанаар сургалтын орлогоос урьдчилж дур мэдэн 600,000 төгрөг авсан боловч цалин авсан баримт үйлдээгүй, өгөөгүй. Зөвхөн Г.Г-гийн ажлын хариуцлагын алдаанаас болсон хохирол байсан тул ажилласан сар гаруй хугацааны цалинг өгөх шалтгаан байхгүй гэж үзсэн” гэв.

**Шүүхийн шийдвэр ба анхан шатны шүүхийн шийдвэрийн үндэслэл:** Анхан шатны шүүх нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн бөгөөд “Зохигчдын шүүхэд болон шүүх хуралдаанд гаргасан тайлбар, хэрэгт авагдсан нотлох баримтуудаас үзэхэд нэхэмжлэгч Г.Г нь “ЮМ Э Т Э” ХХК-д менежерийн ажил албан тушаал эрхэлж байсан гэх үйл баримт тогтоогдож байна. ИХШХШТХ-ийн 25 дугаар зүйлийн 25.2.2, 38 дугаар зүйлийн 38.1-д зааснаар нэхэмжлэгч нь нэхэмжлэлийн шаардлага, түүний үндэс болж байгаа байдлын талаарх нотлох баримтаа өөрөө гаргаж өгөх, цуглуулах үүрэгтэй гэж заасан. Талуудын тайлбар, хэрэгт авагдсан бичгийн нотлох баримтуудаар иргэн Г.Г, Б.Т нарын хооронд хөдөлмөрийн гэрээ байгуулагдсан гэх үйл баримт тогтоогдохгүй байх тул нэхэмжлэгч Г.Г нь хариуцагч Б.Т-гээс ажилласан хугацааны цалин хөлсийг шаардах эрхгүй. Өөрөөр хэлбэл, нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг хариуцах этгээд нь иргэн Б.Т биш байх тул нэхэмжлэгч Г.Г-гийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэв” гэжээ.

**Дүн шинжилгээ:** ХтХ-ийн 125 дугаар зүйлийн 125.1 дэх хэсэгт ажил олгогч, ажилтны хооронд гарсан хөдөлмөрийн ганцаарчилсан маргааныг ХМТК, шүүх тус тусын харьяаллын дагуу шийдвэрлэнэ гэж заагаад шүүхээр шууд харьяалан шийдвэрлэх маргааны төрлийг ХтХ-ийн 128 дугаар зүйлд тусгажээ. Өөрөөр хэлбэл, шүүхээр шийдвэрлэхээр зааснаас бусад маргаан нь ХМТК-оор шийдвэрлэхээр хуульчилжээ (ХтХ-ийн 126.1). Харин цалин хөлстэй холбогдон үүсэх маргаан нь шүүхийн харьяаллын маргаан мөн эсэхийг ХтХ-ийн 128 дугаар зүйлээс үзэхэд шүүхэд харьяалагдах маргаан биш байх тул ХМТК урьдчилан хянан шийдвэрлэх эрх зүйн зохицуулалтаар шийдэгдэнэ. Гэвч тохиолдол №1-ийг шинжлэхэд шүүх нэхэмжлэгчийг ХМТК-т хандаж маргааныг урьдчилан хянан шийдвэрлүүлсэн эсэхэд дүгнэлт хийгээгүй буюу нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах (ИХШХШТХ 65.1.3) нөхцөл байдалд дүгнэлт хийлгүйгээр шийдвэр гаргасан байна. Мөн ХтХ-ийн 129 дүгээр зүйлийн 129.1 дэх хэсэгт Хөдөлмөрийн гэрээний талууд энэ хуулийн 129.2 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд эрхээ зөрчигдсөнийг мэдсэн буюу мэдэх ёстой байсан өдрөөс хойш гурван сарын дотор хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх байгууллагад гомдлоо гаргах эрхтэй болохыг тусгасан. Гэтэл нэхэмжлэгч хөөн хэлэлцэх хугацаандаа шүүхэд нэхэмжлэл гаргаагүй буюу хэрэгт авагдсан мэдээллийн дагуу 30 хоногоор хэтэрсэн байх магадлалтай байсан боловч анхан шатны шүүх үүнийг шалгалгүйгээр шийдвэр гаргажээ.

Ийнхүү шүүх нь шийдвэртээ хэргийн харьяаллын талаар дурдаагүй, мөн хөөн хэлэлцэх хугацаа хэтрүүлсэн эсэхэд дүгнэлт хийгээгүй байх тул формаль шаардлагын хоёр шалгуурын аль алийг нь хангаагүй байна гэсэн дүгнэлтэд хүрч байна.

Материаллаг шаардлагын тухайд дүн шинжилгээ хийж буй шүүхийн шийдвэр нь зөвхөн анхан шатны шүүхээр шийдэгдсэн тул ИХШХШТХ-ийн 40 дүгээр зүйлд заасныг хангасан эсэхийг шалгаж үзлээ.

Нэхэмжлэгч тайлбарлахдаа хариуцагчийн даалгасны дагуу бүх ажил үүргийг нэг бүрчлэн хийж гүйцэтгэж байсан тухайгаа хэлээд хөдөлмөрийн гэрээ байгуулах гэж олон удаа хүсэлт, шаардлага тавьсан боловч хүлээж авахгүйгээр итгэлцлийн үндсэн дээр ажлаа хий гэсэн тайлбар өгч байсан тухай дурдсан байна. Харин хариуцагчийн зүгээс нэхэмжлэгчээр олон төрлийн ажил үүрэг гүйцэтгүүлж байснаа хүлээн зөвшөөрсөн агуулгатай тайлбар өгч улмаар яагаад цалинг өгөөгүйгээ тайлбарласан байдаг. Талуудын тайлбарт үндэслэн хууль хэрэглээний хувьд дүгнэхэд ХтХ-ийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсэгт Хөдөлмөрийн гэрээг бичгээр байгуулаагүй тохиолдолд ажилтнаас ажил, үүрэг гүйцэтгэхийг шаардаж болохгүй гэж заасныг хариуцагч зөрчин, гэрээ байгуулалгүйгээр тухайн бизнесийг явуулахад хүний оролцоо шаардлагатай бүх ажил үүргийг уг ажилтнаар гүйцэтгүүлсэн болох нь харагдаж байна. Мөн хариуцагчийн тайлбарт ажилтны цалин хөлсийг хэд хэдэн удаа цувуулж өгч байсан, цалингийнхаа оронд эд зүйл өгч байсан зэргээ дурдсан байдаг. Гэвч шүүх ХтХ-ийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэгт “Ажилтны цалин хөлсийг сард хоёр ба түүнээс дээш удаа, тогтоосон өдөр олгоно”, 61.1 дэх хэсэгт “Ажилтны үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл олговрыг мөнгөн хэлбэрээр олгоно” гэсэн заалтуудыг зөрчсөн болохоо хариуцагч өөрөө тайлбараараа илэрхийлсэн байхад эл байдалд дүн шинжилгээ огт хийхгүйгээр шийдвэр гаргажээ.

Өөрөөр хэлбэл, нэхэмжлэгч, хариуцагч хэн хэнийх нь тайлбараар уг ажилтнаар ажил үүрэг гүйцэтгүүлсэн болох нь, ингэхдээ хуульд заасан наад захын хэм хэмжээг биелүүлж ажиллуулаагүй болох нь харагдаж байна. Иймд “Шүүхийн шийдвэр нь хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байна” гэсэн шалгуурыг хангаагүй байна гэж дүгнэхэд хүргэж байна. Мөн шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгт “Талуудын хооронд хөдөлмөрийн гэрээ байгуулагдсан гэх үйл баримт нотлогдохгүй байна” гэсэн дүгнэлт хийсэн байна. Хөдөлмөрийн тухай

хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт “Ажил олгогч буюу түүний эрх олгосон албан тушаалтан иргэнтэй хөдөлмөрийн гэрээг бичгээр байгуулж, гэрээний нэг хувийг ажилтанд өгөх үүрэгтэй” гэж заасан байдаг. Гэтэл ажил олгогч гэрээ байгуулах үүргээ биелүүлээгүй болох нь нэхэмжлэгчийн тайлбараас нотлогдож байх бөгөөд хуульд гэрээ байгуулах үүргийг нэгэнт ажил олгогчид хүлээлгэсэн байхад ажилтныг энэ талаараа нотлоогүй учраас хариуцагчийг уг хэргийг хариуцах этгээд биш байна гэж үзэж байгаа нь үндэслэлгүй байна гэж үзэхэд хүргэлээ. Түүнээс гадна ХтХ-ийн зарим зүйл, заалтыг тайлбарласан Улсын Дээд шүүхийн 33 дугаар тогтоолд “Ажилтан болон ажил олгогч амаар тохиролцсоны дагуу ажилтан ажил үүргээ гүйцэтгэж эхэлсэн ба хөдөлмөрийн гэрээг бичгээр нөхөн байгуулахаар харилцан тохиролцсон нөхцөлд хөдөлмөрийн эрхийн харилцааг амаар тохиролцсон үеэс эхэлсэн гэж тооцож болно”<sup>9</sup> гэж тайлбарласныг үндэслэл болгон нэхэмжлэгч, хариуцагч нарын хооронд хөдөлмөрийн харилцаа амаар харилцан тохиролцсон үеэс үүссэн гэж үзэж болохоор байжээ. Ийнхүү хууль зүйн эдгээр үндэслэлээр талуудын хооронд хөдөлмөрийн эрх зүйн харилцаа үүссэн байтал гэрээ байгуулах үүргээ биелүүлээгүй ажил олгогчийн үйлдлийг зөвтгөн нэхэмжлэлийн шаардлагыг хангахгүй орхигдуулж байгаа нь шийдвэр хууль ёсны байх шаардлагыг хангахгүй байна гэж дүгнэлээ.

Шүүх шийдвэр гаргахдаа нотлох баримтыг хуулийн дагуу үнэлсэн эсэхийг (ИХШХШТХ-ийн 40-р зүйл) дараах байдлаар дүгнэлээ. Шүүх хэргийг хэрэгсэхгүй болгосон дараагийн үндэслэл нь ИХШХШТХ-ийн 25 дугаар зүйлийн 25.2.2, 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэгт зааснаар нэхэмжлэгч нь нэхэмжлэлийн шаардлага, түүний үндэслэлийн талаарх нотлох баримтаа өөрөө гаргаж өгөх, цуглуулах үүрэгтэй байдаг.

<sup>9</sup> Хөдөлмөрийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай Улсын Дээд шүүхийн тогтоол, Дугаар 33, 2006.07.03.

Гэтэл шүүхийн зүгээс “Талуудын тайлбар, хэрэгт авагдсан бичгийн нотлох баримтуудаар иргэн Г.Г, Б.Т нарын хооронд хөдөлмөрийн гэрээ байгуулагдсан гэх үйл баримт тогтоогдохгүй байх тул нэхэмжлэгч Г.Г нь хариуцагч Б.Т-гээс ажилласан хугацааны цалин хөлсийг шаардах эрхгүй байна” гэж үзжээ. Шүүхийн шийдвэрийн энэ байдлаас харахад нотлох баримтыг гаргаж өгөх, цуглуулах үүргийг зөвхөн нэхэмжлэгчийн үүрэг мэтээр үзэж хэт нэг талын эрх ашгийг хамгаалан хэргийг шийдвэрлэсэн байна. ИХШХШТХ-ийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэгт “Зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч нь өөрийн шаардлага ба татгалзлын үндэс болж байгаа байдлын талаарх нотлох баримтаа өөрөө гаргаж өгөх, цуглуулах үүрэгтэй” гэж, мөн хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт “Хэргийн зохигч гэдэгт нэхэмжлэгч, хариуцагч, хуульд заасны дагуу тэдгээртэй эрх зүйн хувьд ижил эрх, үүрэгтэйгээр хэрэгт оролцож байгаа этгээд хамаарна” хэмээн хариуцагчийг мөн хамруулахаар заасан. Шүүх хуулийн энэхүү заалтыг зөвхөн нэхэмжлэгчийн үүрэг мэтээр хөндөн тавьсан нь шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсгээс харагдаж байна. Өөрөөр хэлбэл, хариуцагч дээрх хуулийн дагуу нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөхгүй байгаагийн үндэслэл болсон нотлох баримтуудыг гаргаж өгсөн эсэхэд шүүх мөн дүгнэлт хийлгүй орхигдуулжээ. Тухайлбал, хариуцагч тайлбартаа цалин шилжүүлж байсан гэж дурдсан тул нэхэмжлэгчид цалинг нь олгосон талаарх дансны хуулгаа ирүүлсэн эсэх, цалингийн оронд гар утас өгсөн болох нь нотлогдож байгаа эсэх зэрэг нь тодорхойгүй байхад шүүх зөвхөн нэхэмжлэгч нотлох баримтаа гаргаж ирүүлээгүй байна хэмээн дүгнэж хэргийг шийдсэн нь учир дутагдалтай.

**Дүгнэлт:** Ийнхүү ажилтны цалин хөлсөө авч чадахгүй байгаа маргааныг шүүхээр шийдвэрлэж буй эл байдалд дээрх шалгуурын дагуу дүн шинжилгээ хийж үзэх төдийд



тухайн шийдвэрийг үндэслэлтэй гарсан гэж үзэх боломжгүйг харж болохоор байна. Ажилтны цалин хөлс гэдэг бол тухайн хөдөлмөр эрхлэгч иргэний болоод цаашлаад түүний гэр бүлийн нийгмийн баталгаа байтал түүнийгээ авахын тулд ажилтан ажил олгогчийг эрэн сурвалжлах хүртэл хэмжээнд очиж байж хөндөгдсөн эрх ашгаа хамгаалуулахад хүрдэг нь нэхэмжлэгчийн эрх ашгийг илт хууль бусаар хохироож буй нөхцөл байдал юм. Хэдийгээр төрийн тогтоосон хуулийг шүүгч хэрэглэсэн гэж үзэж болох ч тэдгээр хэм хэмжээ нь усны гадаргуу дээрх хөөс төдий л зүйл гэж эрх зүйн социологичид үздэг<sup>10</sup>. Нөгөө талаас шүүх зөвхөн хуулийг ягштал хэрэглэх үүрэгтэй. Хууль хэрэглээг гуйвалтгүйгээр хэрэглэх, хэрэгжүүлэх газар нь зөвхөн шүүх юм гэж үзэх эрх зүйн судлаачид ч байдаг бөгөөд Монгол Улсын шүүгчийн тангараг нь “Шүүгч би ...хэрэг, маргааныг хэнээс ч хараат бус, зөвхөн Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд нийцүүлэн шийдвэрлэж, ...тангараглая...”<sup>11</sup> хэмээдэг. Өөрөөр хэлбэл, шүүхийн хууль хэрэглээ болон шийдвэр гаргаж буй нөхцөл байдлын талаар өөр өөр байр суурь байдаг тул шийдвэр гаргахдаа шүүгч өөрийн дотоод итгэл үнэмшлийн дагуу хууль хэрэглээ болоод хэрэгт авагдсан нотлох баримт хоорондын уялдааг сайтар хангаж дүгнэлт хийдэг байх нь нийгмийн харилцаа тэгш үргэлжлэхэд шүүгчийн оруулах том хувь нэмэр болох юм.

Цалин хөлстэй холбоотой маргаанд дүн шинжилгээ хийхэд хөдөлмөрийн гэрээ байгуулсан болон гэрээ байгуулахгүй ажилласан нөхцөл байдал нь шүүхийн шийдвэр өөр гарах нэг үндэслэл болж байна. Гэвч гэрээ байгуулагдаагүй шалтгааны улмаас буюу ажил олгогчийн хууль бус ажиллагааны үр дагавраас шалтгаалан ажилтны гаргасан нэхэмжлэлийг хангахгүй орхих нь нийгэмд үзүүлэх нөлөө, ач холбогдлын хувьд сөрөг байх хандлагатай. Ажил олгогч, бизнес эрхлэгчийн

<sup>10</sup> Н.Лүндэндорж, Jurisprudence, УБ., 2011, 54 дэх тал.

<sup>11</sup> Шүүгчийн эрх зүйн байдлын тухай Монгол Улсын хууль, 2012.



тухайд аль болох бага зардлаар их ашиг олох сонирхол давамгайлдаг. Энэ нь хэдийгээр бизнес эрхлэгчдийн зорилго хэдий ч тухайн үйл ажиллагаа, ашгийнх нь төлөө хөдөлмөрөө зориулж буй хүний эрх ашгийг хохироох нь буруу юм. Харин ажил олгогчийн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй байгааг шүүх үл харгалзан шийдвэрээ гаргах нь дараа дараагийн олон хүний эрх ашгийг хохироох нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна. Иймд хөдөлмөрийн маргаан зохицуулах механизмаа бэхжүүлэх, шинээр бий болгох буюу боловсронгуй болгоход чиглэсэн шинэчлэлийг эхлүүлж, хэрэгжүүлэхэд сайтар анхаарах хэрэгтэй.<sup>12</sup> Харин судлаачийн зүгээс дүгнэж үзэхэд цалин хөлстэй холбогдон үүсдэг маргаан наад зах нь тооцоолол зөв эсэхэд нэхэмжлэгч, хариуцагчид маргадаг тул тухайн маргаанаа байгууллагынхаа ХМТК-оор урьдчилан шийдвэрлүүлж, харин шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа тохиолдолд шүүхэд ханддаг байх одоогийн тогтолцоо нь зөв гэж үзэж байна. Гэсэн хэдий ч судалгааны явцад ХМТК-ын үйл ажиллагаа хэвийн явагдаж, хуулийн заалт амьдралд бодитоор хэрэгжиж байгаа эсэхийг манай судалгааны дөрөв дэх хэсэгт хөндсөн бөгөөд тодорхой шийдлийг тусгасан болно.

## **Тохиолдол №2: Нэмэгдэл, нэмэгдэл хөлс гаргуулах тухай нэхэмжлэл<sup>13</sup>**

Дүн шинжилгээ хийхээр сонгон авсан дараагийн кэйс нь ажилтны цалин хөлсний бүрэлдэхүүн болох нэмэгдэл, нэмэгдэл хөлстэй холбогдон үүссэн маргааныг шүүх хэрхэн авч үзэж

<sup>12</sup> ОУХБ-ын ОУ-ын сургалтын төв, Хөдөлмөрийн маргааны удирдлагын тогтолцоо, УБ., 2020.

<sup>13</sup> Мэргэшсэн зэргийн олгогдоогүй нэмэгдэл, ур чадварын нэмэгдэл, илүү цагийн хөлс, үр дүнгийн урамшуулал, удаан жилийн нэмэгдэл зэрэгт нийт 105,597,902.43 төгрөг гаргуулах тухай иргэний хэргийг Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх 2019 оны 5 дугаар сарын 14-ний өдөр, Дугаар 183/ШШ2019/01170 нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж, үлдсэн хэсгийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. Эх сурвалж: [https://shuukh.mn/single\\_case/13035?daterange=2019-08-05%20-%202021-06-17&id=2&court\\_cat=1&bb=1](https://shuukh.mn/single_case/13035?daterange=2019-08-05%20-%202021-06-17&id=2&court_cat=1&bb=1)

шийдвэрлэсэн тухай асуудал юм. 2015 оноос хойш шүүхээр шийдвэрлэсэн цалин хөлстэй холбоотой маргаануудад дүн шинжилгээ хийж үзэхэд дээрх тохиолдол №1-д тусгагдсан үндсэн цалин хөлсийг хугацаанд нь олгоогүйгээс гадна ажилтны цалин хөлсний бүрэлдэхүүн болох нэмэгдэл, нэмэгдэл хөлсийг олгоогүй тухай маргаан багагүй хувийг эзэлж байсан юм.

**Хэргийн үйл баримт:** Нэхэмжлэгч тал болох Үйлдвэрчний эвлэлийн хорооны итгэмжлэгдсэн төлөөлөгч нь хариуцагч байгууллагаас 14 ажилтны найман сарын хугацааны мэргэшсэн зэргийн нэмэгдэл, нэг жилийн хугацааны ур чадварын нэмэгдэл үндсэн цалингийн 15 хувиар бодож олгох, 2015 оны 10-12 дугаар сарын үр дүнгийн урамшуулал, удаан жилийн нэмэгдэл, илүү цагийн хөлс зэрэг нийт 105,597,902 төгрөг гаргуулах шаардлага бүхий нэхэмжлэл гаргасан байна. Нэхэмжлэгч энэхүү нэхэмжлэлийг гаргасан гол үндэслэлээ дараах байдлаар томъёолжээ: “2013 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн Хамтын гэрээ (Зорчигч тээврийн нэгдэл үйлдвэрчний эвлэл болон тухайн байгууллагын захиргааны хооронд байгуулсан)-ний 4.4.2 дахь заалтад ажилчдын ур чадварын нэмэгдлийг сар бүр олгоно, энэ нь үндсэн цалингийн 10 хувиас хэтрэхгүй гэж заасан ба жолооч нар түлш бага зарцуулсан бол ур чадвартай ажилласан гэж үзэхээр тусгажээ. Мөн байгууллагад аваар, осолгүй ажиллах, шатахуун хэмнэх, машины эвдрэлээс урьдчилан сэргийлсэн зэргийг ур чадвартай ажилласанд тооцдог байна. Том оврын автобусны жолооч нарын ажил нь хөдөлмөрийн хүнд нөхцөлд хамаардаг тул Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 77 дугаар тушаалыг үндэслэн 15 хувийн нэмэгдэл шаардсан байна. Удаан жилийн нэмэгдэл цалин хөлсний журамд зааснаар ажилтан 12 сар ажиллаад 1 дүгээр сард нь дараа жилийнх нь удаан жилийн нэмэгдлийг тооцдог. Ажилтан таван жил ажилласан бол зургаа дахь жилээсээ удаан жилийн нэмэгдэл авдаг байна. Мөн ажилтан таван жил ажилласан бол 50,000, 10 жил ажилласан бол 100,000, 18 жил

ажилласан бол 180,000 төгрөгийг түүнд жилд нэг удаа олгох бөгөөд үүнийг зорчигч тээврийн нэгдлийн 2013 оноос хойших цалин хөлсний журмаар зохицуулжээ. Үр дүнгийн цалинг бүтэн жил ажилласан хүнд дундаж цалингаар бодож олгодог байна. Үүнийг ажилтны нийгмийн даатгалын дэвтэрт бичигдсэн сүүлийн гурван сарын цалингийн дунджаар тооцдог. Үүнийг Хамтын гэрээний 4.7 дахь заалтыг үндэслэн хариуцагчаас нэхэмжилсэн байна. Илүү цагийн хөлсийг цалин хөлсний журамд заасан байдаг. Жолооч, кондукторын сард ажиллавал зохих цагаас илүү ажилласан цагийн мөнгийг нэг цагт ногдох тарифт хөлсийг хоёр дахин нэмэгдүүлж олгоно гэж заасан. 2015 оны 1 дүгээр сараас 2016 оны 4 дүгээр сар хүртэлх хугацааны илүү цагийн хөлс зэргийг цалин хөлсний журмын 6.3 дахь хэсэгт заасны дагуу тооцоолж олгохгүй байгаа тул нэр бүхий ажилчид нэхэмжлэл гаргаж байна”<sup>14</sup> гэжээ.

Хариуцагч нэхэмжлэлд хариу тайлбар өгөхдөө “Нэхэмжлэгчдийн төлөөлөгчийн итгэмжлэл хуулийн дагуу хийгдсэн эсэх нь тодорхойгүй, нэхэмжлэгчийн гаргаж буй үнийн дүн, шаардлага нь хэрэгт авагдсан нотлох баримтаас тодорхой харагдахгүй байна. Нэхэмжлэгчийн ярьж байгаа тушаалууд хэрэгт байхгүй, гаргаж байгаа нэхэмжлэлийн шаардлагад тооцоолол нь мэргэжлийн шаардлага хангах эсэх нь тодорхойгүй. Манай байгууллагаас мэргэшсэн нягтлан бодогчид өөрсдөө мэргэжлийн систем ашиглаад эдгээр тооцооллыг гаргаж ирдэг. Цалингийн картыг үндэслэн энэ хүмүүсийн ажилласан цагийн 2013 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн зорчигч тээврийн компани болон Үйлдвэрчний эвлэлийн хороотой байгуулсан Хамтын гэрээнд үндэслэн эдгээр цалин хөлс, урамшуулал, бүх зүйлийг олгосон байдаг. Байгууллагын зүгээс Хөдөлмөрийн тухай хуулийн 53.1, 18.1.1, 53.1 дэх хэсэгт заасныг баримтлан бүх ажилчдад өгөх ёстой цалин, нэмэгдэл тус бүрийг олгосон

<sup>14</sup> <http://new.shuukh.mn/irgenanhan/94348/view>

учраас нэхэмжлэлийн шаардлагын илүү цагийн хөлснөөс бусад нэмэгдэл, нэмэгдэл хөлсийг өгөх үндэслэлгүй” гэж маргажээ.

**Шүүхийн шийдвэр:** Анхан шатны шүүхийн шийдвэрийн үндэслэлд нэхэмжлэгчийн гаргасан таван төрлийн шаардлагыг шүүх дараах байдлаар дүгнэжээ. Үүнд:

- *Ажилласан жилийн нэмэгдэл* гаргуулах шаардлагыг шүүх шийдвэрлэхдээ 2015 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн цалин хөлсний тухай журмын 5.3.1-д “Ажилласан жилийн нэмэгдэл нь ажилтны тухайн байгууллагад удаан хугацаанд тогтвор суурьшилтай ажилласныг урамшуулан олгож буй нэмэгдэл цалин” гэж, 5.3.3-т “Ажилласан хугацааг тухайн байгууллагад үндсэн ажилтнаар томилогдон тушаал гарсан үеэс эхлэн тооцно. Ажилласан жилийн нэмэгдлийг таваас дээш жил ажилласан ажилчдад ажилласан жил тус бүрийг 10,000 төгрөгөөр тооцож тайлант жилийн эцэст жилд нэг удаа байгууллагын захирлын тушаалаар олгоно” гэж тус тус заасан байх бөгөөд нэхэмжлэгчид дээрх журмын дагуу ажлаа хэнд, хэрхэн тайлагнасан, ажилласан жилийн нэмэгдлийг тооцуулж, энэ талаар байгууллагын удирдлагаар баталгаажуулсан болох нь хэрэгт авагдсан бичгийн нотлох баримтаар нотлогдон тогтоогдохгүй байх тул хангах үндэслэлгүй байна.
- *Үр дүнгийн урамшуулал:* 2015 оны 10 дугаар сараас 12 дугаар сарын дундаж цалингаас үр дүнгийн цалин нэхэмжилсэн шаардлагын хувьд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 220 дугаар тогтоолоор баталсан “Нийслэл, дүүргийн орон нутгийн төсвийн байгууллага, өмчит үйлдвэрийн газрын ажиллагсдад үр дүнгийн шагнал

урамшуулал олгох журам”-ын дагуу байгууллагын удирдлагаар баталгаажуулсан үр дүнгийн урамшуулал олгох талаарх баримтыг шүүхэд ирүүлээгүй, хэрэгт авагдсан бичгийн нотлох баримт болон талуудын тайлбараар уг шаардлага тогтоогдохгүй байна.

- *Илүү цагийн хөлс*: 2015 оны 1 дүгээр сараас 2016 оны 4 дүгээр сар хүртэлх хугацааны илүү цагийн хөлсийг нэхэмжлэгч тус бүрээр тооцоолборыг гаргаж хариуцагч 1,052,750 төгрөг өгөхөөр хүлээн зөвшөөрсөн байна.
- *Мэргэшсэн зэргийн нэмэгдэл*: 2013 оны 8 дугаар сараас 2016 оны 4 дүгээр сар хүртэлх хугацааны мэргэшсэн зэргийн нэмэгдэл авахаар шаардсан байх бөгөөд Хөдөлмөрийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3.4-т зааснаар үндсэн цалингийн сүлжээ, жишиг болон нэмэгдэл хөлс, нэмэгдлийн хэмжээ, шагнал урамшуулал, түүнийг олгох нөхцөл, журмыг ажил олгогч нь хууль тогтоомж, хамтын гэрээ, хэлэлцээрт нийцүүлэн баталж мөрдүүлэхээр, мөн хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсэгт ажилтанд ажлын байрны тодорхойлолтыг үндэслэн мэргэшлийн зэргийн, хөдөлмөрийн нөхцөлийн болон бусад нэмэгдлийг хамтын гэрээгээр тогтоон олгоно гэж заажээ. А-1 ОНӨҮГазар болон Үйлдвэрчний эвлэлийн хороо нь 2013 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн “2013-2014 онд хэрэгжүүлэх авто тээврийн салбарын хамт (тариф)-ын хэлэлцээр” байгуулахад оролцоогүй, хэлэлцээрт гарын үсэг зураагүй, Үйлдвэрчний эвлэлийн холбоо нь энэ талаар маргаан үүсгэж шийдвэрлүүлээгүй байх тул дээрх хэлэлцээрийн дагуу хариуцагчаас мэргэшсэн зэргийн нэмэгдэл цалинг нэхэмжлэгчид болон Үйлдвэрчний эвлэлийн хороо шаардах эрхгүй, хариуцагч уг нэмэгдлийг олгох үүрэг хүлээгээгүй, Хамтын гэрээний 4.2-т зааснаар байгууллагын дотор мөрдөгдөж буй дүрэм журмуудыг баримталж уг нэмэгдэл цалинг олгохоор зохицуулсан байх тул мэргэшсэн зэргийн

нэмэгдэл цалин гаргуулах шаардлагыг хэрэгсэхгүй болгох үндэслэлтэй гэж үзсэн.

- Ур чадварын нэмэгдэл: “2013 оны 4 дүгээр сараас 2016 оны 4 дүгээр сар хүртэлх хугацааны үндсэн цалингийн 15 хувиар тооцож ур чадварын нэмэгдэл авах шаардлагын тухайд 2015 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн А/64 дугаар тушаалаар баталсан “Зорчигч тээврийн нэгдэл” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын цалин хөлсний тухай журмын 5 дугаар зүйлийн 5.5.1-д “Ур чадвараас хамаарах зэргийн нэмэгдлийг зөвхөн засвар үйлчилгээний станцын болон ерөнхий механикийн, тоног төхөөрөмжийн, цахилгааны, гэрэлтүүлгийн засварчдад олгоно” гэж, 5.5.2-т “Засварчдын зэргийг мэргэжлийн байгууллагын олгосон зэргийн үнэмлэх мөн байгууллагын “Зэрэг тогтоох комисс”-ын шийдвэрийг үндэслэн тогтооно” гэж заасан байхад нэхэмжлэгчид цалин хөлсний журамд тусгаагүй, уг журмаар зохицуулаагүй ур чадварын нэмэгдэл цалин нэхэмжилсэн нь мөн үндэслэлгүй байх бөгөөд Хамтын гэрээний 4.2-т зааснаар байгууллагын дотор мөрдөгдөж буй дүрэм журмуудыг баримталж уг нэмэгдэл цалинг олгохоор зохицуулсан учраас цалин хөлс олгох журамд зааж тусган зохицуулагдаагүй нэмэгдэл цалинг нэхэмжлэгчид шаардах эрхгүй тул уг шаардлагыг хангах үндэслэлгүй байна” гэж нэхэмжлэлийн шаардлага тус бүрд хэрэгсэхгүй байгаа үндэслэлийг дурдсаны дээр ХтХ-ийн 129 дүгээр зүйлд заасан хөөн хэлэлцэх хугацааг хэтрүүлсэн байна гэж дүгнэсэн байна.

Давж заалдах шатны шүүхийн магадлалын үндэслэлд “Анхан шатны шүүх хэрэгт цугларсан нотлох баримтыг ИХШХШТХ-ийн 40 дүгээр зүйлийн 40.1, 40.2 дахь хэсэгт заасны дагуу үнэлэн, хэргийн үйл баримтыг дүгнэн, хэрэглэвэл зохих хуулийг зөв тайлбарлан хэрэглэж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны

журам зөрчөөгүй байх тул шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх хуулийн шаардлагад нийцжээ. Хэрэгт авагдсан баримтаас үзвэл “А” ОНӨҮГ-ын төлөөлөл, ажилтнуудын төлөөллийн хооронд 2013 оны 2 дугаар сарын 5-ны өдөр Хамтын гэрээ байгуулан, уг гэрээнд 2014 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан хүчин төгөлдөр гэрээ байна. Анхан шатны шүүхээс авто тээврийн байгууллагын Үйлдвэрчний эвлэлийн салбар байгууллагуудын Хамтын гэрээнд хэлэлцээрээр тохирсон заалтуудыг тусгахаар тохиролцсон боловч “Зорчигч тээврийн нэгдэл” ОНӨААТҮГ нь гэрээний оролцогч биш гэж маргасан тул Хамтын гэрээнд тусгуулж тохиролцох талаар тус байгууллагын Үйлдвэрчний эвлэлийн хороо маргаан үүсгэж шийдвэрлүүлээгүй, хөдөлмөрийн дотоод журмыг хэлэлцээрт нийцүүлэн батлаагүй тул дээрх хэлэлцээрийн тохиролцооны талаар нэхэмжлэгчид шаардах эрхгүй” гэж дүгнэсэн нь үндэслэлтэй. Шүүх хэргийг шийдвэрлэхдээ хэрэгт авагдсан нотлох баримтаар тогтоогдсон үйл баримтын хүрээнд дүгнэлт хийж, нэхэмжлэлийн шаардлагын заримыг хангаж шийдвэрлэсэн нь үндэслэл бүхий гэж дүгнэжээ.

Улсын Дээд шүүхийн тогтоолд “Анхан шатны шийдвэрийг давж заалдах шатны шүүх хэвээр үлдээсэн бол хяналтын шатны шүүх шийдвэр, магадлалд агуулгын бус өөрчлөлт оруулж шийдвэрлэсэн байна. Улсын Дээд шүүх нэхэмжлэгчийн гаргасан гомдлыг хянан хэлэлцээд нэхэмжлэлийн таван шаардлагаас гурвыг буюу ур чадварын, үр дүнгийн, удаан жилийн нэмэгдэл тус тус нэхэмжилсэн хэсгийг ХтХ-ийн 129 дүгээр зүйлийн 129.1 дэх хэсэгт заасан хуулийн хөөн хэлэлцэх хугацааг хэтрүүлсэн байна” гэж дүгнэн тогтоол гаргаж нэхэмжлэгчийн гаргасан гомдлыг хангахгүй орхижээ.<sup>15</sup>

**Дүн шинжилгээ:** Шүүх шийдвэртээ хэргийн харьяалал зөрчсөн эсэхийг шалгаж хэрэгт авагдсан

<sup>15</sup> <http://new.shuukh.mn/irgenanhan/94348/view>



нотлох баримтад үндэслэн “Зорчигч тээврийн нэгдэл” ОНӨААТҮГ нь ХМТК байгуулаагүй болох нь тус байгууллагын Үйлдвэрчний эвлэлийн хорооны 2016 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 30 дугаартай албан бичгээр тогтоогдож байх тул ИХШХШТХ-ийн 65 дугаар зүйлийн 65.1.3-т заасан урьдчилсан нөхцөлийг зөрчөөгүй байх тул уг иргэний хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэхээр байна гэсэн дүгнэлт хийж формаль шаардлагын эхний шалгуурыг хангасан байна.

Хөөн хэлэлцэх хугацааны хувьд анхан шатны шүүх нэхэмжлэлийн таван шаардлагаас дөрвийг нь хангаагүй үндэслэлээ нэхэмжлэгч тал (ХтХ, 129.1) эрхээ зөрчигдсөнийг мэдсэн буюу мэдэх ёстой байсан өдрөөс хойш гурван сарын дотор гомдол гаргах эрхтэй байсан бөгөөд уг хугацааг хэтрүүлсэн гэж дүгнэн нэхэмжлэлийн шаардлагыг хангаагүй байна. Өөрөөр хэлбэл, нэхэмжлэгчид Хамтын гэрээгээр тохирсон нэмэгдэл цалин, хөлс, урамшуулал олгохгүй байгаа, энэ талаар ажилтны эрх ашиг зөрчигдөж байгааг мэдсэнээс хойш буюу 2013 оны 8 дугаар сараас хойш шаардсан мэргэшсэн зэргийн нэмэгдэл, 2013 оны 4 дүгээр сараас хойш шаардсан ур чадварын нэмэгдэл, 2015 оны 1 дүгээр сараас хойш шаардсан илүү цагийн хөлс, 2015 оны 10 дугаар сараас хойш шаардсан үр дүнгийн урамшуулалт цалин, удаан жилийн нэмэгдэл зэрэг шаардлагын талаар мэдсэн өдрөөс хойш гурван сарын дотор шүүхэд хандах эрхтэй байсан. Гэсэн ч энэ хугацаанд гомдол гаргаагүй байна гэж хэргийн хөөн хэлэлцэх хугацаа хэтрүүлсэн байдалд дүгнэлт хийсэн нь хугацаатай хамааралтай формаль шаардлагыг хангасан байна.

Анхан шатны шүүх хэргийг шийдвэрлэхдээ формаль шаардлагад дурдсаны дагуу хэргийн харьяалал болон хугацааг шалгасны эцэст хэрэгт авагдсан нотлох баримтуудад хууль зүйн дараах дүгнэлт хийсэн байна. Тухайлбал, маргагч талуудын мэтгэлцээний явцад нэхэмжлэгч нь нэмэгдэл,



нэмэгдэл хөлсийг авто замын салбарын Хамтын хэлэлцээр, байгууллагын Хамтын гэрээ зэргийг хууль зүйн үндэслэл болгон шаардлагын үндэслэлээ гаргаж байгаа талаар тайлбарласан. Шүүх энэ асуудалд дүгнэлт хийхдээ “2013 оны 2 дугаар сарын 5-ны өдөр Хамтын гэрээ байгуулагдаж, уг гэрээнд 2014 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Уг гэрээ нь ХтХ-ийн 8, 12-18 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан, хууль тогтоомжид нийцсэн, хуульд заасан хугацаанд Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газарт бүртгүүлсэн хүчин төгөлдөр гэрээ байна, Хамтын гэрээг цуцлах үндэслэл болохгүй бөгөөд харин Хамтын гэрээг өөрчлөх, нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэн байгуулах асуудлыг ажил олгогч буюу ажилчны төлөөлөгчид хэлэлцээ хийж шийдвэрлэхээр, ажилчны төлөөлөл болох үйлдвэрчний эвлэл шаардах эрхтэй байна” гэсэн дүгнэлт хийсэн нь ХтХ-д нийцсэн байна гэж үзэж байна. Мөн шүүх мэтгэлцээний эрх зүйн эх сурвалж болж байсан хамтын хэлэлцээрийн талаар “Хамтын хэлэлцээрийн тухайд хариуцагч талын зүгээс нэхэмжлэгчийн шаардлагын эрх зүйн эх сурвалж болж буй авто тээврийн салбарын хэлэлцээрт оролцоогүй гэж маргасан бол нэхэмжлэгч тал Монголын тээвэр холбоо, газрын тосны ажилтны Үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны гишүүн болох нь, хариуцагч тал авто тээврийн салбарын Үйлдвэрчний эвлэлийн холбоонд багтдаг гэх тайлбар хэргийн үйл баримтаар нотлогдон тогтоогдохгүй байна...” гэж тус тус дүгнээд шийдвэр гаргасан байх тул тус шүүхийн шийдвэр үндэслэлтэй бөгөөд хууль ёсны байх шаардлагыг бүрэн хангажээ.

Түүнчлэн шүүх шийдвэр гаргахдаа хэрэгт ямар нотлох баримтууд авагдсан болох, тухайн нотлох баримтуудыг хэрхэн үнэлж, дүгнэж байгаа талаараа дэлгэрэнгүй, логик дараалалтайгаар судалгаа хийж улмаар хууль хэрэглээтэй хослуулан дурдсан байсан нь үндэслэл бүхий шийдвэр болжээ. Жишээлбэл, шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгт

“Нэхэмжлэгч ХтХ-ийн 129 дүгээр зүйлийн 129.1 дэх хэсэгт заасны дагуу эрхээ зөрчигдсөнийг мэдсэн буюу мэдэх ёстой байсан хугацаанаас хойш гурван сарын дотор хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх байгууллагад гомдол гаргах хэрэгтэй гэж заасны дагуу гомдлоо хугацаанд нь гаргаж шийдвэрлүүлээгүй байна” гэж дүгнэсэн байна. Харин нэхэмжлэгчийн зүгээс үүнд няцаалт өгч тайлбарлахдаа “Гомдол гаргах хугацаа хэтрүүлээгүй, үүнийг нотлох баримт нь хэрэгт авагдсан, бид холбогдох байгууллагуудад удаа дараа энэ асуудлаар өргөдөл, гомдол гаргаж байсан тул хугацаа тасалдсан болох нь тогтоогдоно” гэж маргасан байх ба уг асуудалд шүүх нэг бүрчлэн дүн шинжилгээ хийж, нотлох баримтуудыг шинжлэн судалсан байх бөгөөд “Үйлдвэрчний эвлэлийн хорооноос эрх бүхий байгууллагуудад гаргасан гомдол нь агуулгын хувьд нэмэгдэл, нэмэгдэл хөлс гаргуулах шаардлагаас өөр асуудлаар гаргасан байх тул хөөн хэлэлцэх хугацаа тасалдсан гэж үзэх үндэслэлгүй байна” хэмээн нотлох баримтын үнэлгээ судалгааг хийсэн байна.

Нэхэмжлэгч анхан шатны шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй, Нийслэлийн давж заалдах шатны шүүх болон Улсын Дээд шүүхэд гомдол гаргасан. Тэрээр гомдолдоо “Шат шатны шүүхийн шийдвэр үндэслэлгүй гарсан” гээд “ХтХ-ийг буруу тайлбарлаж хэрэглэсэн, хэрэгт авагдсан нотлох баримтыг буруу үнэлсэн” хэмээжээ. Нэхэмжлэгчийн гаргасан гомдлыг давж заалдах шатны шүүх болон Улсын Дээд шүүх хянаж үзээд анхан шатны шүүхийг хууль хэрэглээний хувьд алдаагүй, ИХШХШТХ-д заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зөрчөөгүй байна гэж шийдвэрлэснийг үндэслэлтэй гэж үзэж байна.

**Дүгнэлт:** Тохиолдол №2-т дурдсан шийдвэр нь цалин хөлсний маргаан дотроо нэлээд өргөн хүрээтэй буюу шүүгчээс хөдөлмөрийн эрх зүйн өргөн мэдлэг, мэдээлэл шаардсан

маргааны төрөл гэж онцолж болохоор байлаа. Учир нь тухайн маргаанд нэхэмжлэгчээр байгууллагын Үйлдвэрчний эвлэлийн холбоо ажилтнуудыг төлөөлөн ганцаарчилсан маргаан үүсгэж нэхэмжлэл гаргасан, нийт таван төрлийн шаардлагаар харьцангуй өндөр дүн бүхий мөнгө нэхэмжилсэн, хамтын гэрээ, хэлэлцээрээр зохицуулагдсан эрх зүйн эх сурвалжтай, нэг хэргээр нийт 14 хүний асуудлыг нэг дор хэлэлцсэн шүүхийн шийдвэр байлаа.

Судлаачдын хувьд уг хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг хөдөлмөрийн маргаан, түүний дотор цалин хөлс гаргуулахтай холбоотой маргааны хувьд жишиг болохуйц хэмжээнд шийдвэрлэсэн маргаан гэж дүгнэж байна. Энэ нь дараах үндэслэлтэй. Үүнд:

1. Үйлдвэрчний эвлэлийн хорооны даргын гаргасан итгэмжлэл хуульд нийцсэн эсэх, үйлдвэрчний эвлэл ийнхүү ажилтнуудыг төлөөлөн нэхэмжлэл гаргах хууль зүйн үндэслэлтэй эсэхэд дүгнэлт хийж шийдвэрт тусгасан;
2. Шүүх урьдчилан хянан шийдвэрлэх хуулийн шаардлагыг нэхэмжлэгч нь хангасан эсэхэд дүгнэлт хийж, уг хэргийг шүүх харьяалан шийдвэрлэхийг тогтоосон;
3. Хууль хэрэглээ болон нотлох баримтыг үнэлэхдээ харьцуулсан дүгнэлтийг нэн ойлгомжтой бичиж, хэргийг хэрэгсэхгүй болгосон эрх зүйн үндэслэлийг хангалттай үндэслэлээр тайлбарласан;
4. Олон хүний нэхэмжлэлтэй, олон шаардлага бүхий маргааны шийдвэрлэлтийн байдлыг системтэй, цэгцтэй бичсэн. Иймд тухайн шийдвэрийг хөдөлмөрийн харилцаатай холбоотой сургалтын үйл ажиллагаанд жишиг болгон, бусад хуульч хөдөлмөрийн эрх зүйн практикт илүү мэргэшихэд ашиглаж болох юм.

## 2.2. АЖЛААС ҮНДЭСЛЭЛГҮЙ ХАЛСНААС ҮҮССЭН ОЛГОВРЫН МАРГААН

Энэ хэсэгт хөдөлмөрийн маргааны дийлэнх хувийг эзэлж буй ХтХ-ийн 69 дүгээр зүйлийн 69.1-д зааснаар ажилгүй байсан хугацааны олговроо гаргуулах нэхэмжлэл бүхий тохиолдолд дүн шинжилгээ хийлээ. Уг маргаан нь өндөр хувь эзэлж байгаа талаар доктор, профессор Б.Уранцэцэг “Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчлэл: Шүүхийн практик” сэдэвт илтгэлдээ “Шүүхээр шийдвэрлэж байгаа хөдөлмөрийн маргааны 89.5-91.3 хувь нь ажлаас буруу халсан буюу өөр ажилд буруу шилжүүлсэн тухай маргаан эзэлдэг, үүнийг даган цалин хөлсийг нөхөн гаргуулах шаардлага ч шийдэгддэг”<sup>16</sup> гэжээ.

### **Тохиолдол №3: Ажилгүй байсан хугацааны олговор гаргуулах маргаан<sup>17</sup>**

**Хэргийн үйл баримт:** Нэхэмжлэгч 2015 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн 2015/08 тоот тушаалаар ажлаас үндэслэлгүй халагдаж, Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 101/ШШ2016/04934 тоот шийдвэр, Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн 1454 дугаартай магадлал, Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны 2016 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 001/ХТ2016/01253 тоот тогтоолоор түүнийг ажилд эгүүлэн тогтоосон. Шүүхийн шийдвэрийг ажил олгогч 2017 оны 3 дугаар

<sup>16</sup> Б.Уранцэцэг, Эрх зүй ба эдийн засаг (Илтгэл, шийдвэрийн эмхэтгэл), “Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчлэл ба шүүхийн практик” илтгэл, УБ., 2018, 54 дэх тал.

<sup>17</sup> Ажилгүй байсан хугацааны цалин хөлстэй тэнцэх олговорт 20,532,000 төгрөг гаргуулах, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд нөхөн бичилт хийлгэх шаардлага, Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 3 дугаар сарын 6-ны өдрийн 799 дугаартай нэхэмжлэлийн шаардлагыг хангахгүй орхиж шийдвэрлэсэн. Эх сурвалж: [https://shuukh.mn/single\\_case/74264?daterange=2018-03-06%20-%202021-06-17&id=1&court\\_cat=1&bb=1](https://shuukh.mn/single_case/74264?daterange=2018-03-06%20-%202021-06-17&id=1&court_cat=1&bb=1)

сарын 2-ны өдөр биелүүлж ажилд авах тушаал гаргасныг 2017 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр мэдсэн тул ажилгүй байсан хугацааныхаа цалинг авахаар нэхэмжлэл гаргасан.

Хариуцагч нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөхгүй гэж маргасан. Тэрээр үндэслэлээ тайлбарлахдаа “Д.Н-ийн ажлаас үндэслэлгүй халагдсантай холбоотой маргаан өмнө нь шүүхээр шийдэгдэж байсан бөгөөд Баянзүрх дүүргийн анхан шатны шүүхийн 2016 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 101/ШШ2016/04934 тоот шийдвэр, Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн 1454 тоот магадлал, Улсын Дээд шүүхийн 2016 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 001/ХТ2016/01253 тоот тогтоолоор “Т” ХХК-ийн барилгын инженерийн ажилд эгүүлэн тогтоолгож, ажилгүй байсан хугацааны 10,443,000 төгрөг гаргуулах, нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгал нөхөн төлүүлэх шийдвэр гарсан. Үүний дараа компанийн нягтлан Н.Л ... дугаараас Д.Н-ийн ... дугаар руу залган ажилд нь оруулахаар дуудахад “ажилд буцаж орохгүй, мөнгийг минь л өгчих” гэсэн. Д.Н нь 2017 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албанд хандаж шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэхээр өргөдөл гаргахдаа зөвхөн шүүхийн шийдвэрийн дагуу мөнгөө авахаар хандсан байдаг. Мөн 2017 оны 9 үгээр сарын 18-ны өдөр Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албанд хандаж шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг хаалгах өргөдөл гаргасан ба үүндээ “Шүүхийн шийдвэрийн дагуу үлдэгдэл мөнгө, эрүүл мэндийн даатгал, нийгмийн даатгалын шимтгэлийг хуульд заасны дагуу суутган дэвтэрт бичилт хийлгэж баталгаажуулсан тохиолдолд өөр нэхэмжлэх зүйлгүй тул гүйцэтгэх баримт бичгийг хаах” гэсэн агуулга бүхий өргөдөл гаргаснаас үзэхэд нэхэмжлэгч зөвхөн ажилгүй байсан хугацааны цалин хөлсөө л авах сонирхолтой, ажилдаа эргэж орох хүсэл анхнаасаа байхгүй байсан нь харагдаж байна. Гэтэл одоо дахин

348 хоногийн 20,532,000 төгрөгийг “Т” ХХК-аас гаргуулах нэхэмжлэл гаргаж байгаа нь хууль зүйн үндэслэлгүй гэж бид үзэж байна. Бид өмнөх шүүхийн шийдвэрийг бүрэн биелүүлсэн, шүүхийн шийдвэрт заасны дагуу ажилдаа буцаж орохоос нэхэмжлэгч өөрөө татгалзсан байхад ажилгүй байсан хугацааны цалин хөлсийг дахин өгөх боломжгүй. Иймд нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож өгнө үү” гэжээ.

**Шүүхийн шийдвэр:** Шүүхийн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэхдээ дараах хоёр үндэслэлийг авч үзсэн байна. Үүнд:

- Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2018 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 4/4125 дугаартай албан бичигт “...Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаагаар шүүхийн шийдвэрт дурдсан төлбөрийн мөнгийг гаргуулан төлбөр авагчид шилжүүлэн, нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын дэвтэрт бичилт хийгдэж, Д.Н-ийн 2017 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр гаргасан хүсэлтийн дагуу гүйцэтгэх баримт бичгийг дуусгавар болгосон. Төлбөр авагч Д.Н нь ажилд эгүүлэн тогтоолгох тухай хүсэлт гаргаагүй, мөн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад ажилд орохгүй талаар шийдвэр гүйцэтгэгчид амаар тайлбар гаргасан тул ажилд эгүүлэн тогтоолгох ажиллагаа хийгдээгүй болно” гэжээ.
- Түүнчлэн “Нэхэмжлэгч 2017 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс ажилгүй байсан хугацааны цалин хөлстэй тэнцэх олговрыг нэхэмжлэх эрхтэй байх боловч 2017 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр шүүхэд нэхэмжлэл гаргасан нь ХтХ-ийн 129 дүгээр зүйлд заасан гомдол гаргах хугацааг хэтрүүлсэн байх тул ажилгүй байсан хугацааны цалин хөлстэй тэнцэх олговорт 20,532,000 төгрөгийг гаргуулах нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгох үндэслэлтэй” гэж дүгнэсэн байна.

**Дүн шинжилгээ:** Тохиолдол №3-т авагдсан маргаан нь хэргийн харьяаллын тухайд ХтХ-ийн 128 дугаар зүйлд заасан шүүхээр хянан шийдвэрлэгдэх маргааны тавдугаарт бичигдсэн маргаан байх тул шүүх тухайн хэргийг шууд хянан шийдвэрлэсэн нь хууль зүйн үндэслэлтэй формаль шаардлагын эхний шалгуурыг хангасан байна. Нэхэмжлэл гаргах хугацааны тухайд шүүх хугацаа хэтрүүлсэн эсэхэд дүгнэлт хийж нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байх тул мөн формаль шаардлагын хоёр дахь шалгуурыг хангажээ.

ХтХ-ийн 69 дүгээр зүйлд “Энэ хуулийн 36.1.2-т заасны дагуу ажилтныг ажил, албан тушаалд нь эгүүлэн тогтоосон бол түүнд ажилгүй байсан хугацаанд нь урьд авч байсан дундаж цалин хөлстэй тэнцэх олговор, хэрэв бага цалинтай ажил хийж байсан бол зөрүүтэй тэнцэх олговрыг олгоно” гэж заасан бөгөөд хуулийн энэхүү заалтыг шүүхийн шийдвэр гарч ажлаас үндэслэлгүй халагдсан болох нь тогтоогдсон тохиолдолд ажилгүй байсан хугацааны олговроо гаргуулах замаар хохирлоо барагдуулдаг. Материаллаг шаардлагын дагуу дүн шинжилгээ хийж үзэхэд “Шүүхийн шийдвэр нь хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байна” гэсэн шалгуурыг хангасан байна гэж үзэж болохоор байна. Учир нь шүүх шийдвэр гаргахдаа хэрэгт авагдсан нотлох баримтуудыг тал бүрээс нь бүрэн шалгаж, ХтХ-ийн 129.1-д заасан хөөн хэлэлцэх хугацааг зөв тоолж хууль хэрэглэсэн байна.

**Дүгнэлт:** ХтХ-ийн 69 дүгээр зүйлийн үндсэн зорилго нь аливаа хэлбэрээр ажлаас үндэслэлгүй халагдан цалин хөлс авч амьдралын хэрэгцээгээ хэвийн хангах үйл ажиллагаанд нь саад учирч, сэтгэл санаагаар хохирсон ажилтны зөрчигдсөн эрх ашгийг хамгаалах, ажилгүй байсан хугацаанд дундаж цалин хөлстэй нь тэнцэх хэмжээний олговор олгох замаар хангахад чиглэдэг. Нөгөөтээгүүр хуулийн энэ заалтаар хохирсон

ажилтанд боломж олгосноос гадна тодорхой хугацааны дотор зохих шаардлагаа гаргаж хөндөгдсөн эрх ашгаа хамгаалахыг үүрэг болгон, хөөн хэлэлцэх хугацаа тогтоосон нь ажил олгогчийн хэвийн үйл ажиллагааг хангах агуулгыг мөн хуульчилсан хэрэг юм.

### 2.3. ЦАЛИН ХӨЛС БУУРУУЛАХ САХИЛГЫН ШИЙТГЭЛ ОНОГДУУЛСАНТАЙ ХОЛБООТОЙ МАРГААН

Хөдөлмөрийн маргаан гарах нэг шалтгаан нь сахилгын шийтгэлтэй холбоотой асуудлууд байдаг. Жуулийн үндэслэлийн хувьд ХтХ-ийн 131 дүгээр зүйлд зааснаар хөдөлмөрийн гэрээ, дотоод журам, холбогдох бусад дүрэм журмыг зөрчсөн ажилтанд дараах төрлийн сахилгын шийтгэл ногдуулна. Үүнд:

- Сануулах;
- Үндсэн цалинг гурван сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах;
- Ажлаас халах.

Хөдөлмөрийн сахилгын шийтгэл нь ажилтны үндсэн цалингаас 20 хүртэлх хувиар хасахаас гадна хөдөлмөрийн харилцааг ажил олгогчийн санаачилгаар цуцлах цөөн үндэслэлүүдийн (131.3, 40.1.4) нэг болдог учир хөдөлмөрийн сахилгын шийтгэл хүлээлгэхээс үүдсэн маргааныг нарийвчлан судлах нь ач холбогдолтой.



**Тохиолдол №4: Сахилгын шийтгэлтэй байх хугацаандаа давтан зөрчил гаргаж ажлаас халагдсан маргаан<sup>18</sup>**

**Хэргийн үйл баримт:** “МСМ” ХХК-д ажилтай Б.С нь 2016 оны 6 дугаар сараас 8 дугаар сарын хооронд ажлаасаа нийт 1000 минут хоцорсон учир цалинг нь 10 хувь бууруулсан сахилгын шийтгэл хүлээжээ. Түүнчлэн шийтгэлтэй байх хугацаандаа удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй гэх үндэслэлээр давтан зөрчил гаргасан гэж үзэн ажлаас нь халжээ. Б.С хяналтын шатны шүүхэд гаргасан гомдолдоо “Сахилгын шийтгэлийн алиныг ч хүлээн зөвшөөрөхгүй буюу ажлаасаа хоцроогүй. Харин өөр салбар дээр өөрт оногдсон ажил үүргээ хэрэгжүүлээд явж байсан ба өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь хийгээд явсан” гэж мэдүүлжээ. Б.С сахилгын шийтгэлийг хүлээн зөвшөөрөхгүй байгаагаа тухайн үед нь хүний нөөцийн албандаа албан ёсоор мэдэгдсэн боловч байгууллагын удирдлагын зүгээс дотоод журамдаа заасан “...ажилтан сахилгын шийтгэлийг хүлээн зөвшөөрөхгүй байх нь ногдуулахгүй байх үндэслэл болохгүй” гэх заалтыг барьсан гэсэн тайлбар өгчээ. Түүнчлэн Б.С “Дотоод журамд зааснаар сахилгын шийтгэлийг эхлээд а) сануулах, б) сануулах, в) цалинг 10 хувиар бууруулж оногдуулах гэсэн дарааллыг зөрчсөн” гэж мэдүүлсэн. Харин давтан сахилгын шийтгэлийн хувьд нэхэмжлэгч мөн л удирдлагын үүрэг даалгаврыг биелүүлээгүй гэх үндэслэлийг эс зөвшөөрч байгаа бөгөөд үүнийг нотлох боломж нь хаагдсан буюу түүний албаны цахим хаяг руу нэвтрэх эрхийг түдгэлзүүлж, холбогдох цахим шууданг устгасан гэжээ. Иймээс нэхэмжлэгч Б.С нь хариуцагч “МСМ” ХХК-д холбогдуулан ажилд эгүүлэн тогтоолгох, ажилгүй

<sup>18</sup> Ажилд эгүүлэн томилуулж, ажилгүй байсан хугацааны цалинг шүүхийн шийдвэр гарах хүртэлх хугацаагаар тооцон гаргуулж, нийгмийн даатгалын дэвтэр болон эрүүл мэндийн даатгалын дэвтэрт нөхөн бичилт хийлгүүлэхийг даалгах тухай Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх 2019 оны 6 дугаар сарын 18-ны өдөр 183/ШШ/2019/01415 дугаартай шийдвэр гаргаж нэхэмжлэлийн шаардлагыг хангахгүй орхиж шийдвэрлэсэн байна. [https://shuukh.mn/single\\_case/93746?daterange=2019-06-18%20-%202019-06-20&id=1&court\\_cat=1&bb=](https://shuukh.mn/single_case/93746?daterange=2019-06-18%20-%202019-06-20&id=1&court_cat=1&bb=) .

байсан хугацааны цалинтай тэнцэх олговор гаргуулж, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын дэвтэрт нөхөн бичилт хийхийг даалгах тухай нэхэмжлэлийн шаардлага гаргажээ. Хариуцагч “МСМ” ХХК нь нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь эс зөвшөөрч “Нэхэмжлэгчийг ажлаас чөлөөлсөн тушаал хууль зүйн үндэслэлтэй тул нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож өгнө үү” гэжээ.

**Шүүхийн шийдвэр:** Хариуцагч хөдөлмөрийн гэрээг цуцлахдаа сахилгын шийтгэлтэй байх хугацаандаа давтан зөрчил гаргасан гэх шалтгаанаар ХтХ-ийн 38.1.2, 40 дүгээр зүйлийн 40.1.4, 131 дүгээр зүйлийн 131.1.3, “МСМ” ХХК-ийн дотоод журмын тавдугаар зүйлийн 5.49, зургаадугаар зүйлийн 6.4, 6.5, 6.5.4, хөдөлмөрийн гэрээний зургаадугаар зүйлийн 6.1, долоодугаар зүйлийн 7.3.2.1-д заасныг тус тус үндэслэсэн ажээ. Анхан шатны шүүх уг маргааныг хэлэлцэж хэрэгт авагдсан баримт болох цагийн бүртгэлийн хуудас, холбогдох цахим шууданг нягталснаар Б.С-ийг сахилгын шийтгэлтэй байх хугацаандаа давтан зөрчил гаргасан, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй нь хариуцагч байгууллагын дотоод журмаар (7.3.2.1 болон 7.3.2.6) ноцтой зөрчилд тооцогдон ажлаас халах хууль зүйн үндэслэл болсон гэж үзжээ. Шүүх уг шийдвэрийг хэрэгт авагдсан нотлох баримтад тулгуурлан гаргасан байна.

Давж заалдах шатны шүүхэд Б.С гомдол гаргахдаа анхан шатны шүүх хэрэгт авагдах нотлох баримтыг эргэлзээгүй, үнэн зөв талаас нь үнэлж дүгнэлгүйгээр нэхэмжлэгчийг ноцтой зөрчил гаргасан гэж дүгнэснийг хууль зүйн үндэслэлгүй гэж үзжээ. Давж заалдах шатны шүүх хэргийг хянаж анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээх нь зүйтэй гэж шийдвэрлэсэн байна. Учир нь Б.С нь 1000 орчим минут хоцорч нэг сарын цалинг 10 хувиар бууруулах сахилгын шийтгэл авснаа хүлээн зөвшөөрсөн нь ХтХ-ийн 129 дүгээр зүйлийн 129.1

дэх хэсэгт зааснаар шүүхэд гомдол гаргаагүйгээр батлагдаж буй бөгөөд сахилгын зөрчилтэй байх хугацаандаа удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй нь цахим шуудан болон түүнд үзлэг хийсэн тэмдэглэлээр тогтоогджээ. Харин Б.С ажил үүргээ гүйцэтгэсэн гэдгээ нотлоогүй бөгөөд хариуцагч байгууллага сахилгын шийтгэл ногдуулахдаа алгасах зарчмыг баримталсан, нэхэмжлэгчийн цахим шууданг устгасан гэх тайлбарыг үндэслэлгүйд тооцон, гомдлыг хангахгүй орхисон байна.

Хяналтын шатны шүүхэд Б.С гомдол гаргахдаа “Шийдвэр магадлалыг эс зөвшөөрч, хэрэглэх ёсгүй хууль хэрэглэсэн, хуулийг буруу тайлбарласан, хэрэглэх ёстой хуулийг хэрэглээгүй” хэмээн үндэслэлээ гаргажээ. Шүүх шийдэхдээ “Сахилгын шийтгэлийг хүлээн зөвшөөрөхгүй бол шүүхэд гомдол гаргах эрх нь нээлттэй учир хэрэв энэ эрхээ эдлээгүй бол хууль мэдэхгүй буюу буруу ойлгосон нь хуулийг хэрэглэхгүй байх, хуульд заасан хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй тул энэ гомдлыг хангах боломжгүй” гэсэн байна.

**Дүн шинжилгээ:** Ажилтан ажлаас буруу халагдсан гэж үзвэл ажил олгогчийн шийдвэрийг гардаж авсан эсхүл ажил хүлээлцсэн сүүлчийн өдрөөс хойш нэг сарын дотор шүүхэд гомдол гаргах эрхийнхээ дагуу Б.С хөдөлмөрийн гэрээг цуцалсан шийдвэрийг 2018 оны 12 дугаар сарын 18-ны өдөр гардан авч, 2019 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр шүүхэд нэхэмжлэл гаргасан нь хуулийн хугацааг хэтрүүлээгүй байна.

Талууд эвлэрүүлэн зуучлалын журмаар маргаан шийдвэрлүүлэх хүсэлт гаргаагүй тул гомдол нь ХтХ-ийн 128 дугаар зүйлийн 128.1.2-т зааснаар шүүхээр хянан шийдвэрлэх маргаанд харьяалагдах зохицуулалтын дагуу ХУД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд хэлэлцэж шийдвэрлэгдсэн нь формаль шаардлагыг хангаж байна.

Шүүхийн шийдвэрт дурдсанаас үзэхэд нэхэмжлэгч Б.С нь дараах хоёр үйл баримттай холбоотойгоор хариуцагч байгууллагыг хууль зүйн үндэслэлгүй шийдвэр гаргаж ажлаас халсанд гомдол гаргажээ. Үүнд:

- Ажлаас 1000 минут хоцорсныг үгүйсгэн, хүлээн зөвшөөрөхгүй буюу эхний сахилгын шийтгэл болох цалинг 10 хувиар бууруулсныг үндэслэлгүй гэж үзэж буй бөгөөд сахилгын шийтгэлийг дотоод журамд заасны дагуу шат дараалалтайгаар ногдуулаагүй;
- Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй гэсэн сахилгын давтан шийтгэлийг хүлээн зөвшөөрөхгүй. Хариуцагч байгууллага үүрэг даалгавар биелүүлснийг нотлох баримтыг буюу бүх холбогдох цахим шууданг устгасан.

ХтХ-ийн 40 дүгээр зүйлийн 40.1.4-т “Ажилтан хөдөлмөрийн сахилгын зөрчлийг давтан гаргасан тохиолдолд ажил олгогчийн санаачилгаар хөдөлмөрийн гэрээг цуцалж болно” гэж заасан. Б.С нь өөрт оноосон хөдөлмөрийн сахилгын зөрчлүүдийн алийг нь ч хүлээн зөвшөөрөхгүй буюу зөрчил гаргаагүй гэж үзэж буй учир ажлаас үндэслэлгүй халж, хуулийг зөрүүтэй хэрэглэсэн гэж гомдол гаргасан. Судалгааны хүрээнд энэхүү гомдлыг гурван шатны шүүх хэрхэн хянан шийдвэрлэсэн талаар дүн шинжилгээ хийлээ.

Юуны өмнө 1000 минутын хоцролтыг хөдөлмөрийн сахилгын зөрчилд тооцох эсэх нь хариуцагч байгууллагын дотоод журам, хөдөлмөрийн гэрээ, бусад дүрэм журмаар тодорхой зохицуулагдсан үгүйг нягтлах нь зүйтэй. Гэтэл анхан шатны шүүхийн шийдвэрт энэ асуултыг огт авч хэлэлцээгүй эсхүл шүүхийн шийдвэрт тусгаагүй байгаагаас Б.С-ийн гаргасан зөрчил сахилгын зөрчилд тооцогдох эсэх нь эргэлзээтэй байна. Энэ асуудлыг давж заалдах болон хяналтын шатны шүүхийн аль аль нь дүгнээгүй бөгөөд авч хэлэлцэлгүй

шууд сахилгын зөрчилд хамаатуулсан нь хуулийг буруу хэрэглэсэн байх магадлалтай. Хэрвээ 1000 минутын хоцролтыг ямар ч баримт бичгээр сахилгын шийтгэлд тооцох зохицуулалт байхгүй бол үүнийг сахилгын шийтгэлд тооцох үндэслэлгүй.

*Сахилгын шийтгэлийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа* тухайд хариуцагч талаас анхан шатны шүүхэд өгсөн тайлбартаа Б.С-ийг 2018 оны 6-8 сарын хооронд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажлаас 1000 орчим минут хоцорсон нь цагийн бүртгэлээр баталгаажсан гэж үзсэн ба Б.С үүнээс үүдсэн цалингийн 10 хувиар бууруулсан сахилгын шийтгэлийг 2018 оны 9 дүгээр сарын 25-нд хүлээн зөвшөөрч, гарын үсэг зурж хүлээн авсан гэжээ. Гэтэл Б.С сахилгын шийтгэлийг хүлээж авахгүй гэж хүний нөөцийн албандаа мэдэгдсэн боловч дотоод журамд заасан “...ажилтан сахилгын шийтгэлийг хүлээн зөвшөөрөхгүй байх нь ногдуулахгүй байх үндэслэл болохгүй” гэх заалтыг хүний нөөцийн ажилтан хариу тайлбараар өгсөн гэв.<sup>19</sup> Гэвч мэдээллээс харахад анхан шатны шүүх Б.С-ийн эсэргүүцлийг огт харгалзаж үзээгүй бөгөөд харин давж заалдах шатны шүүхээр нэхэмжлэгч нь үндсэн цалинг бууруулсан сахилгын шийтгэлийг зөвшөөрөөгүй бол ХтХ-ийн 129 дүгээр зүйлийн 129.1.7-д заасан хугацаанд шүүхэд гомдол гаргах эрхээ ашиглаагүй учир сахилгын шийтгэлийг хүлээн зөвшөөрсөнд тооцно гэжээ. “МСМ” ХХК-ийн дотоод журамд тусгасан ажилтныг сахилгын шийтгэл хүлээн зөвшөөрсөн үгүйгээс үл хамааран сахилгын шийтгэл оногдуулж байгаа нь хүний эрхийг бүдүүлгээр зөрчсөн, ардчиллын үнэт зүйлтэй үл нийцсэн зохицуулалт гэж үзэж байна. Гэтэл энэ асуудлыг аль ч шатны шүүх харгалзаж үзэлгүй орхижээ.

Давтан зөрчил болох *удирдлагаас өгсөн цүрэг даалгаврыг биелүлээгүйн* тухайд анхан шатны шүүх хариуцагч талын дотоод журмын 7.3.2.6-д зааснаар буюу “шууд удирдах дээд

<sup>19</sup> Шүүхийн нэгдсэн цахим хуудсанд хэргийн тухай товч танилцуулгад өгөгдсөн мэдээлэл бөгөөд хэргийн дэлгэрэнгүй мэдээлэлд энэ тухай огт дурдаагүй.

албан тушаалтны өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй нь ноцтой зөрчилд тооцно” гэснийг баримтлан ажил олгогч хөдөлмөрийн гэрээг өөрийн санаачилгаар цуцалсан нь үндэслэлтэй байна гэжээ. Үүнийг давж заалдах шатны шүүгч хэвээр үлдээсэн бол хяналтын шатанд ноцтой зөрчилтэй холбоотой ямар ч дүгнэлт хийгээгүй. Гэтэл удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй нь ноцтой зөрчилд орох хангалттай үндэслэл болох эсэх нь сонирхол татаж байна. Учир нь ХтХ-ийг тайлбарласан Улсын Дээд шүүхийн 33 дугаар тогтоолын 15.4.2-т “Хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.4-т заасан “ноцтой зөрчил” гэдгийг ажил олгогчид эд хөрөнгийн хохирол учруулах, бизнесийн ба ажил хэргийн нэр хүндийг нь гутаах зэргээр түүний эрх, ашиг сонирхолд нь нөлөөлөхүйц сөрөг үр дагаврыг буй болгосон, уг ажилтны хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүрэгт нь харш үйлдэл, эс үйлдэл байна гэж ойлговол зохино...” гэжээ. Хариуцагч талын тайлбараар нэхэмжлэгч Б.С нь ажлын байрны чиг үүргийн дагуу хүнд даацын автомашин, автобуснуудын үнийн жагсаалт гаргах, шинэчлэх үүргийг хугацаанд нь гүйцэтгээгүй буюу хугацааг удаа дараа сунгасан ч ямар ч үр дүн гараагүй гэжээ. Б.С нь шаардлагатай техник тоног төхөөрөмжийн үнийн санал нэгтгэж гаргаагүй нь ажил олгогчид ямар нэг эд хөрөнгийн хохирол учруулсан эсэх эсхүл бизнесийн ба ажил хэргийн нэр хүндийг нь гутааж түүний эрх, ашиг сонирхолд нь нөлөөлөхүйц сөрөг үр дагавар буй болгосон тухай хэрэгт авагдсан мэдээлэлд огт дурдаагүйгээс харахад үүнийг тогтоогоогүй байна. Иймээс “МСМ” ХХК-ийн дотоод журмын 7.3.2.6-д тусгайлан заасан ноцтой зөрчил нь хуульд нийцэхгүй байгаа буюу Б.С-ийн үйлдлийг ноцтой зөрчилд тооцох хангалттай баримт нотолгоо бүрдээгүй байна.

Б.С нь давж заалдах шатны шүүхэд гаргасан гомдолдоо 2018 оны 6 дугаар сараас 8 дугаар сарын хооронд ажлаас 1000 минут хоцорсон гэж үзэн цалинг нь 10 хувиар бууруулсан нь *сахилгын шийтгэлийг алгасаж* оноосон гэжээ. “МСМ” ХХК-

ийн дотоод журмын 6.5.1-д сануулах, 6.5.2-т сануулах, 6.5.3-т үндсэн цалинг 20 хүртэл хувиар гурван сар хүртэл хугацаагаар бууруулах, 6.5.4-т ажлаас халах сахилгын шийтгэл тус тус оногдуулна гэж заасан байна. Анхан шатны шүүхийн шийдвэрт сахилгын шийтгэлийг алгасаж оноосон тухай дурдаагүй буюу ямар ч мэдээлэл ороогүй. Харин давж заалдах шатны шүүхээр энэхүү гомдлыг хянаж үзээд ажил олгогч сахилгын шийтгэлийг шат дараалан оногдуулах үүрэг байхгүй тул хүлээн авах боломжгүй гэжээ.

Улсын Дээд шүүхийн ХтХ-ийг тайлбарласан тогтоолын 29 дүгээрт “Хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1.1-д заасан сахилгын шийтгэл нь ажилтны гэм буруу, зөрчлийн шинж чанар, үр дагаварт тохирсон байх бөгөөд шийтгэлийг заавал шат дараалан оногдуулсан байхыг шаардахгүй” гэх тайлбарын гол ач холбогдол, зорилгыг харгалзан дүгнэхэд хөдөлмөрийн сахилгын аливаа шийтгэлийг шат дараалалгүй оногдуулах эсэхийг тухайн сахилгын зөрчлийн шинж чанар, үр дагавар, ажилтны гэм буруутайг хэмжиж үнэлсний үндсэн дээр шийдвэрлэхийг заасан гэж үзэж байна. Хөдөлмөрийн эрх зүйчдийн байр суурийг судалбаас ажил олгогч ажилтанд сахилгын шийтгэлийн төрлөөс сонгон оногдуулахдаа дараах зарчмыг баримтална гэжээ. Үүнд сахилгын шийтгэл нь:

- Хууль ёсны байх;
- Шударга ёсыг хангасан буюу учруулсан гэм хохиролдоо таарсан шийтгэл байх;
- Зөрчил гаргасан этгээдийн гэм бурууг нотолсон байх;
- Тодорхой хугацаатай байх;
- Нэг зөрчилд давхардсан шийтгэл оноохгүй гэсэн зарчмууд орно.<sup>20</sup>

<sup>20</sup> Л.Баасан, Монгол Улсын хөдөлмөрийн эрх зүй, УБ., 2010, 294 дэх тал.



Шүүхийн тайлбар болон судлаачдын байр суурийг авч үзэхэд сахилгын шийтгэлийн хэлбэрийг ажил олгогч заавал шат дараалан сонгохгүй ба харин төрлүүдээс сонгохдоо тухайн зөрчилд тохирсныг хэрэглэх дээр саналын зөрүүгүй байна.

Хоёр сарын хугацаанд 1000 минут буюу нийт 16 цагийн (ажлын хоёр өдөр) хоцролттой байгааг цагийн бүртгэлээр ажил олгогч илрүүлсэн гэх боловч Б.С нь хүлээн зөвшөөрөхгүй байгаа бөгөөд өөр салбар дээр ажил үүргээ гүйцэтгэж явсан тухай хүний нөөцийн ажилтанд тухай үед нь мэдэгдсэн боловч түүний бүх цахим шууданг ажил олгогч устгасан гэх учир нотолж чадаагүй. Давж заалдах шүүх Б.С-ийн 1000 минутын хоцролт уг байгууллагад ямар үр дагавар авчирсан болон нэг сарын цалинг 10 хувиар хасах нь учруулсан гэм хохиролдоо таарсан эсэхийг огт шалгаж үзээгүй шийдвэр гаргасныг хяналтын шатны шүүх хяналгүйгээр хэвээр үлдээсэн байна.

Хэрэгт авагдсан нотлох баримтуудыг хяналтын шатны шүүх хянаж үзээд “...тал бүрээс нь бодитойгоор харьцуулан үзсэний үндсэн дээр тухайн хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, үнэн зөв, эргэлзээгүй талаас нь үнэлсэн байх ба уг үнэлгээнд үндэслэн үгүйсгэх үндэслэл тогтоогдсонгүй” гэжээ. Хэрэгт авагдсан баримтууд зөвхөн ажил олгогчийн гаргаж өгсөн баримтууд байх ба нэхэмжлэгчийн цахим шуудангийн нэвтрэх эрхийг хааж, зарим чухал баримт болох мэйлийг устгасан гэх мэдэгдлийг огт авч үзээгүй бөгөөд ажил олгогчийн давуу эрхээр цугларсан баримтын хүрээнд хэрэг шийдэгдсэн гэх дүгнэлтэд хүргэж байна.

Түүнчлэн хяналтын шатны шүүх Б.С-ийн гомдлын дагуу баримт гаргуулах, үзлэг хийх ажиллагаа явуулсны үр дүнд 2018 оны 11 дүгээр сарын 19, 20-ны өдрүүдэд удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг дутуу гүйцэтгэсэн, бүрдэл дутуу болохыг удирдлагаас мэдэгдэж байсан үйл баримтаар тогтоогдсон гэсэн нь асуулт дагуулж байна. Учир нь нэхэмжлэгчид ногдуулсан



давтан зөрчил нь удирдлагаас өгсөн үүрэг даалгавар огт биелүүлээгүй гэдэгт үндэслэсэн. Гэтэл шүүх баримтыг хянаж үзээд үүрэг даалгаврыг дутуу биелүүлсэн гэдгийг нотолсон. Дутуу юм уу огт биелүүлээгүй хоёрын хооронд маш том ялгаа байгааг шүүх мөн л харгалзаж үзээгүй байна.

**Дүгнэлт:** Б.С-д ногдуулсан сахилгын шийтгэлүүдийг дараах учир шалтгаанаар хүчингүй болгох, ажлаас үндэслэлгүй халсан гэж үзэх үндэслэлтэй гэж үзэж байна.

- *Нотлох баримтыг тал бүрээс нь үнэлж дүгнэсэн эсэх*

Хэрэгт авагдсан нотлох баримтууд зөвхөн хариуцагч талын байр суурийг бэхжүүлэх үйл баримтууд байв. Нэхэмжлэгчийн бүрдүүлэх шаардлагатай баримтууд хариуцагчийн бүрэн мэдэлд байгаа нь баримтын тэнцвэртэй байдал алдагдаж, баримтыг тал бүрээс үнэлж дүгнэх боломж бүрэлдээгүй.

- *Шүүх өөр хуулийг эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн эсэх*

Дээр хийсэн дүн шинжилгээний үр дүнд Б.С-ийн хоцорсон 1000 минут сахилгын зөрчилд тооцогдох хууль зүйн үндэслэл нь хэрэгт авагдсан мэдээллээс тодорхойлох боломжгүй байгаагаас энэхүү үйл баримтыг хөдөлмөрийн сахилгын зөрчилд хамруулан үзэх нь хуульд нийцэхгүй. Тиймээс Б.С-д сахилгын эхний шийтгэл ногдуулсан захирлын тушаал хүчингүйд тооцох нөхцөл бүрэлдсэн гэж харж байна.

- *Хэрэгт авагдсан нотлох баримтыг үнэн зөв, эргэлзээгүй үнэлсэн эсэх*

“МСМ” ХХК нь Б.С-ийг удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг удаа дараа шаардаад биелүүлээгүй гэх үндэслэлээр сахилгын давтан шийтгэл ногдуулан,

ХтХ-ийг баримтлан ажлаас халсан бол шүүхэд авагдсан баримтаар Б.С-ийг удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг дутуу биелүүлсэн гэсэн дүгнэлтэд хүрсэн атал уг тушаалыг хууль зүйн үндэслэлтэй гэж үзсэн нь нотлох баримтыг үнэн зөв, бодитой үнэлээгүйг харуулж байна. Иймд давтан сахилгын шийтгэл оноосон захирлын тушаал үндэслэлгүй.

Сахилгын шийтгэлийн улмаас хөдөлмөрийн гэрээг цуцалсантай холбоотой маргаануудад давамгайлж байгаа асуудлуудыг тоймловол:

- Сахилгын шийтгэлийг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд гомдлоо шүүхэд гаргах эрх нь нээлттэй (ХтХ, 128.1.7) боловч үүнийг бодит байдалд хэрэгжүүлэх магадлал нь маш бага. Учир нь сахилгын шийтгэл нь сануулах, цалин бууруулах, ажлаас халах хэлбэртэй байх ба аль ч хэлбэрийн шийтгэл оногдуулсан хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд шүүхэд хандаж байж л сахилгын шийтгэлтэй холбоотой асуудлыг шийдвэрлүүлэх боломжтой. Гэтэл практикт сануулах арга хэмжээ авсан эсхүл цалинг 20 хүртэлх хувиар бууруулсан сахилгын шийтгэлээр шийтгүүлсэн ажилтан ажил олгогчоо тэр болгон шүүхэд өгөх магадлал хэр их вэ гэдэг асуулт гарч ирнэ. Ялангуяа цаашид удирдлага доор нь ажиллах төлөвлөгөөтэй байгаа бол магадлал бага юм. Гэвч ямар ч сахилгын шийтгэлийн шууд ба шууд бус үр дагавар буюу түүний үргэлжлэх хугацаа болон давтан зөрчил гаргахад ажлаас шууд халагдах эрсдэлийг тооцвол сахилгын шийтгэл ногдуулах буюу хүлээн зөвшөөрөх процессыг хялбарчлах, бодит байдалд нийцүүлэх, илүү нухацтай авч үзэх шаардлагатай гэж дүгнэж байна. Сахилгын шийтгэл оногдуулахдаа тухайн байгууллагын хариуцагч этгээд уг ажилтанд өөрийнх нь заргалдах эрхийг хамтад

нь тайлбарлаж өгөх шаардлагатай гэж үздэг байхад<sup>21</sup> Б.С-ийн жишээн дээрээс харахад ажил олгогч нь сахилгын шийтгэлийг хүлээн зөвшөөрөх эсэхийг үл харгалзан ногдуулж байгаа нь хүний эрхэнд халдсан явдал гэж дүгнэлээ.


- Сахилгын шийтгэл оногдуулснаас хойших нэг жилийн хугацаанд сахилгын шийтгэл үйлчилж байгаатай холбоотойгоор байгууллагууд (төрийн болон хувийн) энэ хугацаанд нийтлэг туршлагаараа<sup>22</sup> дотоод журамдаа сахилгын шийтгэлтэй ажилтныг үр дүнгийн нэмэгдлээс хасах, тухайн жилийн шагнал урамшууллаас хасахаар зохицуулсан нь үндэслэлгүйгээр нэмэлтээр шийтгэж байгаатай агаар нэг юм.
- Түүнчлэн сахилгын давтан зөрчлийн тодорхойлолтыг илүү тодорхой болгох шаардлагатай байна. Хэдийгээр Улсын Дээд шүүх тайлбарлахдаа ХтХ-ийн 40 дүгээр зүйлийн 40.1.4-т заасан “Ажилтан хөдөлмөрийн сахилгын зөрчлийг давтан гаргасан” гэдэгт хөдөлмөрийн сахилгын зөрчлийг хоёр буюу түүнээс дээш удаа гаргасан байхыг ойлгоно гэсэн боловч адил үйлдлээ давтан гаргахыг эсхүл өөр өөр үйлдэл гаргасан нь давтан зөрчил болох эсэх нь тодорхой бус байгаагаас ажилтны эрх ашиг хохирч байна. Учир нь давтан сахилгын зөрчлийн гол зорилго нь ажилтан нэг үйлдлээ мэдсээр байж давтан үйлдвэл ажлаас халах хүртэл арга хэмжээ авах нь үндэслэлтэй байх ба харин хоёр өөр зөрчил (том жижгээс үл шалтгаалан) гаргасны үр дагаварт ажлаас халагдах хүртэл шийтгэх нь тэнцвэртэй бус шийдвэр болно.

<sup>21</sup> Л.Баасан, Монгол Улсын хөдөлмөрийн эрх зүй, УБ., 2010, 294 дэх тал.

<sup>22</sup> Тухайлбал, томоохон аж ахуйн нэгжид тооцогдох “Сүү” ХХК-ийн 2020 онд мөрдөгдөж буй хөдөлмөрийн дотоод журмын 26.5.6, “Бодь” группийн охин компани болох “Инкон” ХХК-ийн 2020 онд мөрдөгдөж буй дотоод журмын 8.7, Иргэний нисэхийн ерөнхий газрын дотоод журмын 6.2.5.1 гэх мэт.

## 2.4. ШҮҮХ ЦАЛИН ХӨЛСТЭЙ ХОЛБООТОЙ МАРГААНЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХДЭЭ ХЭРГИЙГ УРЬДЧИЛАН ХЯНАН ШИЙДВЭРЛҮҮЛСЭН БАЙХ ШААРДЛАГЫГ ХЭРЭГЛЭЖ БАЙГАА БАЙДАЛ

Хөдөлмөрийн ганцаарчилсан маргааныг хянан шийдвэрлэх харьяаллын байдлыг ХтХ-д заасныг Бүдүүвч 1-д зураглан харуулав. Үүнээс харахад ХтХ-ийн 126 дугаар зүйлд зааснаас бусад маргааныг заавал урьдчилан хянан шийдвэрлүүлэхээр заажээ.



### Хөдөлмөрийн маргаан таслах комисс

Шүүхээр шийдвэрлэхээр зааснаас бусад маргааныг шийддэг хамгийн анхан шатны нэгж бол аж ахуйн нэгж, байгууллага дахь хөдөлмөрийн маргаан таслах орон тооны бус комисс юм. Энэ нь ажил олгогч болон ажилтны тэнцүү тооны төлөөлөгчдөөс бүрдсэн комисс байх бөгөөд ажилтныг төлөөлж тухайн байгууллагын Үйлдвэрчний эвлэл (олон улсын жишигт ч

элбэг тохиолддог)<sup>23</sup>, хэрэв байхгүй бол нийт ажилтны хурлаас сонгогдсон ажилтны төлөөлөл байхаар журамдаа заажээ.<sup>24</sup> Комиссын хурлын шийдвэр олонхын саналаар гарах ба эрхээ хамгаалуулж буй ажилтан уг шийдвэртэй санал нэгдэхгүй тохиолдолд маргаан шүүх рүү явах үндэслэл болно. ХтХ-ийн 128 дугаар зүйлд заасан төрлийн маргаанаас бусад бүх маргаан энэхүү нэгжид харьяалагдах зохицуулалттай. Практикаас харахад жижиг аж ахуйн нэгж буюу ес хүртэлх тооны ажилтантай байгууллагуудад ХМТК гэх нэгж огт байдаггүй ба энэ хэмжээний аж ахуйн нэгж нийт аж ахуйн нэгжийн 86.5 хувийг<sup>25</sup> эзэлж байна. Үлдсэн 13.5 хувьд мөн л бүрэн утгаараа ажилладаг ХМТК байдаггүй нь хуулийн хэрэгжилтэд асуудал байгааг харуулж байна. Ийнхүү хөдөлмөрийн маргаан анхан шатны нэгж дотроо шийдвэрлэгдэхгүй байгаагаас дараагийн шат болох шүүх рүү очих эсхүл маргааны гэм хор, гомдлын хэмжээ, шүүхийн ачаалал, урт хугацаа зарцуулах зэргээс маргааныг оржин, хохирол амсах тохиолдол олонтаа гардгийг үйлдвэрчний эвлэлийн өмгөөлөгч ярьж байна.<sup>26</sup>

ХМТК-ын үйл ажиллагаанд гарч буй асуудлуудын нэг бол ажилтан, ажил олгогчоос бүрдсэн баг аливаа маргаанд ижил тэгш байр суурьтай оролцох, хандах байдал сул буюу ажил олгогч давуу байдлаа ашиглан өөрийн талд албадан шийдвэр гаргуулдгийг Үйлдвэрчний эвлэлийн гишүүд уулзалтууд дээр хөндөж байсан.<sup>27</sup>

<sup>23</sup> Resolving individual labour disputes: A comparative overview, ILO, 2016. file:///Users/mama/Downloads/Resolving%20Individual%20Labour%20Disputes%20%20A%20comparative%20overview.pdf

<sup>24</sup> Хөдөлмөрийн маргаан таслах комиссын дүрэм, Монгол Улсын Засгийн газрын 1999 оны 122 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт.

<sup>25</sup> Аж ахуйн нэгжийн статистик, www.1212.mn

<sup>26</sup> МҮЭ-ийн дэргэдэх Хуульч өмгөөлөгчдийн багийн гишүүн М.Саранцацралтай хийсэн уулзалтын тэмдэглэл.

<sup>27</sup> 2013-2014 онд Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчлэлийн хүрээнд хийгдсэн уулзалтууд дээр хийгдсэн судлаачийн өөрийн дүгнэлт, ажиглалт (Ц.Уянга).

### **Хөдөлмөрийн мэргэжлийн хяналт**

Ажилтан өөрийн хөдөлмөрлөх эрх, түүнээс үүдсэн эрх зөрчигдөж байна гэж үзвэл Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль (ЗШШТХ)-ийн 6.10-т заасны дагуу хөдөлмөрийн хяналтын байцаагчид хандах боломжтой ба асуудал хариуцсан хөдөлмөрийн байцаагч Зөрчлийн тухай хууль (ЗТХ)-ийн 10.16, 10.17-д заасан 11 зөрчлийн хүрээнд (тухайлбал, хөдөлмөрийн гэрээ хийгээгүй, илүү цагийн хөлс олгоогүй гэх мэт) зөрчил гарсан эсэхийг шалган тогтоон, зөрчил гаргасан ажил олгогчид акт тавьж, торгох, нөхөн төлүүлэх, хохирлыг барагдуулах гэх мэт арга хэмжээ авна.

### **Шүүхийн бус харьяаллын маргаан**

Цалин хөлстэй холбоотой маргаан нь хуулиараа шүүхэд шууд хандах маргааны төрөлд ордоггүй (ХТХ-ийн 128 дугаар зүйл). Харин ИХШХШТХ-ийн 65.1.3-ын дагуу урьдчилан хянан шийдвэрлүүлэх механизм буюу ХМТК эсхүл ЗТХ-ийн 10.16, ЗШШТХ-ийн 6.10-ын дагуу мэргэжлийн хяналтад хандахаар тусгажээ. ХМТК байхгүй тохиолдолд иргэд цалин хөлстэй холбоотой асуудлаар мэргэжлийн хяналтад хандахад ихэнх тохиолдолд шууд шүүхэд нэхэмжлэл гаргахыг зөвлөдгөөс<sup>28</sup> ийнхүү цалин хөлстэй холбоотой маргаан дээр шинжилсэн Тохиолдол №4-ийн адил шүүхээр шийдвэрлэгддэг.

Гэтэл өмгөөлөгчдөд үүссэн бүртгэлээс<sup>29</sup> харахад шүүх өөрийн шууд харьяаллын бус маргааныг зарим тохиолдолд хүлээж авахгүй захирамж гарган буцаах тохиолдол цөөнгүй. Энэ тохиолдолд иргэд гомдлоо цааш хэнд хандаж, хэрхэн барагдуулах талаар мухардалд ордог байна. Энэ байдал нь

<sup>28</sup> МҮЭ-ийн холбооны дэргэдэх Хуульч өмгөөлөгчдийн багийн гишүүн М.Саранцацралтай хийсэн уулзалтын тэмдэглэл.

<sup>29</sup> МҮЭ-ийн холбооны дэргэдэх Хуульч өмгөөлөгчдийн багийн гишүүн М.Саранцацралтай хийсэн уулзалтын тэмдэглэл.

эргээд чирэгдэл, бухимдал учруулж, асуудлыг шийдвэрлэхгүй тэр чигт нь орхиход хүргэдэг байна.

### **Эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагаа үр нөлөө, асуудал**

Манай улс Япон Улсын шүүхийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлах системийг удаан хугацаанд судалж, холбогдох байгууллагуудын практик туршлагыг хэрэгжүүлсний эцэст 2012 онд Эвлэрүүлэн зуучлах тухай хууль (ЭЗтХ) батлуулан 2014 оноос хойш иргэний, гэр бүлийн, хөдөлмөрийн гэсэн эрх зүйн гурван салбарт мөрдөж байна. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа дэлхий дахинд маргааныг шүүхийн бус замаар шийдвэрлэх нэгэн алтернатив арга хэмээн хүлээн зөвшөөрөгдөж, олон жилийн өмнөөс албан ёсоор иргэн хоорондын маргаан таслахад түлхүү хэрэглэж заншжээ.

2019 оны байдлаар шүүхэд нийт ирсэн 17,284 өргөдлөөс шийдвэл зохих 12,860 өргөдлийг шийдвэрлэсний 71.7 хувьд нь эвлэрэл амжилттай явагджээ. Гэвч үүний зөвхөн 12 маргаан буюу нийт өргөдлийн 0.1 хувь нь л хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан байх ба түүний 10 нь амжилттай эвлэрүүлэн зуучлагджээ. 2019 онд шүүхийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлалаар орсон нийт маргаан нь шүүхэд ирсэн нийт маргааны 20 хувьтай тэнцэж байгаа бөгөөд төдий хэмжээгээр шүүхийн ачааллыг бууруулсан үзүүлэлт юм.

Эвлэрэгч талуудын хувьд ч мөн адил цаг хугацаа, мөнгө хэмнэх, аль алиндаа ашигтай нөхцөл бүрдүүлэх, эвлэрлийн гэрээний үүргээ биелүүлэх шүүгчийн захирамж авах гэх мэт давуу талууд үүсдэг. Гэсэн хэдий ч 2016 оноос 2019 оны хооронд шүүхийн мэдээллийн сангийн статистикаас харахад эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар шийдэгдэж буй хөдөлмөрийн харилцааны маргааны тоо жилээс жилд буурсан дүнтэй байна (График 2). Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа 2014 оноос хэрэгжиж эхлэх үед иргэдийн хандалт эрс өндөр буюу

хүснэгтээс харахад 2016 онд гэхэд 80 маргаан шийдвэрлэсэн бол энэ үзүүлэлт түүнээс хойш жил ирэх тусам багассаар байгааг харж болно. Гэтэл доорх статистик тоонд тодорхой шалтгааны улмаас хүлээж аваагүй өргөдлийн тоо ороогүй болохыг анхаарах хэрэгтэй.



Эх сурвалж: Монгол улсын шүүхийн тайлан, 2016, 2017, 2018, 2019.  
[www.judcouncil.mn](http://www.judcouncil.mn)

Шүүхийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлах ажиллагааг шүүхийн ачааллыг бууруулах, иргэдэд чирэгдэл багатайгаар хурдан шуурхай үйлчилгээ үзүүлэх зорилготойгоор анх 2014 онд иргэний болон гэр бүлийн эрх зүйн салбар, хөдөлмөрийн ганцаарчилсан маргаанд нэвтрүүлэн хэрэглэж байна. Үүнээс хойших жилүүдэд эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар шийдэгдсэн хөдөлмөрийн ганцаарчилсан маргааны тоо тогтмол буурсаар байгаагийн учир шалтгааныг олж илрүүлэх нь энэхүү судалгааны хувьд ач холбогдолтой гэж үзлээ. Учир шалтгааныг судлах явцад дараах хэд хэдэн асуудал гарч байна:



### **Эвлэрүүлэн зуучлалын төлбөр ба тэмдэгтийн хураамжийн давхар төлөлт**

Эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагааны төлбөр болох 30,000 төгрөгийг (2020 оны байдлаар) өргөдөл гаргагчид нэг удаа төлдөг бөгөөд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилтгүй болж маргаан шүүх рүү шилжих тохиолдолд шүүхийн тэмдэгтийн хураамж нэмж төлөх шаардлага гардаг. Учир нь эвлэрүүлэн зуучлах ажиллагаатай холбоотойгоор Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.5-д зааснаар тэмдэгтийн хураамжаас чөлөөлдөг гурван төрлийн маргаан байх ба хэрэв үүнд харьяалагдахгүй бол тэмдэгтийн хураамж төлөх учиртай. Практикт санхүүгийн боломж бололцооноос шалтгаалан давхар төлбөр төлөхөөс зайлсхийж иргэд эвлэрүүлэн зуучлах шатыг алгасаж шүүхэд шууд хандах явдал цөөнгүй байна.

### **Хөдөлмөрийн харилцааны “тэгш бус” шинж чанартай сөрөг нөлөө**

Хөдөлмөрийн харилцаанд оролцогч субъектүүд буюу ажил олгогч ба ажилтан нь нийгэм, эдийн засгийн хувьд харьцангуй тэгш бус байр сууринаас хөдөлмөрийн харилцаанд анхнаасаа ордог гэсэн ойлголт дэлхийн эдийн засаг болоод эрх зүйн салбарт ноёрхож ирсэн үзлийг хэдийгээр няцаах оролдлого<sup>30</sup> гарч байгаа ч Монгол Улсад бодит байдал дээр энэхүү тэгш бус байдал оршсоор байгаа. Өөрөөр хэлбэл, ажил олгогч нь өмчийн эзэн, ажлын байр бий болгогч, санхүүгийн чадвар өндөр гэх мэт факторуудаас улбаалан эрх мэдэл нь их<sup>31</sup> тул ажилтантай хөдөлмөрийн нөхцөл дээр хэлэлцээрийн ширээний ард суух бус харин тогтсон хөдөлмөрийн гэрээгээр тулгах

<sup>30</sup> Goeff Hogbin, Power in Employment relationships: Is there an imbalance? p.2. <http://archive.hrnicholls.com.au/articles/hrn-hogbin1.pdf>

<sup>31</sup> Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Хөдөлмөрийн удирдлагын тогтолцоо, 2013, 7 дахь тал. [https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---asia/---ro-bangkok/---ilo-beijing/documents/publication/wcms\\_745431.pdf](https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---asia/---ro-bangkok/---ilo-beijing/documents/publication/wcms_745431.pdf)

байдал манай нийтлэг. Практикаас харахад<sup>32</sup> эвлэрүүлэн зуучлагч энэ шалтгаанаар ажил олгогчийг эвлэрлийн ширээнд авч ирэх магадлал маш бага, зуучлах үйл ажиллагаа анхнаасаа бүтэлгүйтэх шинжтэй тул өргөдлийг хүлээн авахгүй, шууд шүүхэд хандахыг зөвлөх болсон байна. Эвлэрүүлэн зуучлалын өргөдөл гаргах үед эсхүл бүр гаргахаас өмнөх шатанд энэхүү “татгалзал” явагддаг учир яг хэдэн маргаан энэхүү үндэслэлээр шууд шүүх рүү очиж байгаа тоо баримтыг олох боломжгүй юм.

### **Төвийг сахих зарчмын алдагдал**

ЭЗТХ-д эвлэрүүлэн зуучлалын ажиллагаанд эвлэрүүлэн зуучлагч нь маргааныг шийдвэрлэх талаар талуудад амаар болон бичгээр зөвлөмж өгөх (ЭЗТХ, 14.1.3) ба эвлэрлийн санал гаргах эрхтэй (ЭЗТХ, 14.1.5) гэж тусгажээ. Өөрөөр хэлбэл, эвлэрэгч талуудад зуучлагч өөрийн байр сууринаас хамгийн зөв гэсэн хувилбарыг санал болгож буйн илрэл юм. Энэ нь эвлэрүүлэн зуучлагчийн төвийг сахих зарчим (ЭЗТХ, 5.2.3) буюу хөндлөнгөөс шүүн таслах үйлдэл хийхгүйгээр зуучлах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах үүрэгтэй нь харшилж байна гэж үзэхээр байна.

Түүнчлэн практикаас харахад хэдийгээр хуулиар шаардаагүй ч (ЭЗТХ, 9) эвлэрүүлэн зуучлагчдын дийлэнх олонх нь хуульч, өмгөөлөгч мэргэжилтэй хүмүүс эсхүл тэтгэвэрт гарсан шүүгчид байх нь элбэг<sup>33</sup> байна. Гэхдээ энд зуучлагчдын арга барил асуудлын шийдлийг хэт хууль эрх зүйн хүрээнээс харах буюу дүгнэх хандлагатай байх магадлал өндөр.

Аль ч улсад хуульч, өмгөөлөгч, шүүгчид нь байнгын мэргэжлийн сургалт, мэдээлэл, мэдлэг, туршлагын хүрээнд ажиллаж, амьдарч буй нь эргээд аливаа асуудалд хандаж буй хандлагыг мэргэжлийн чиг рүү хөтөлдөг гэдгийг Австрали,

<sup>32</sup> МҮЭ-ийн холбооны дэргэдэх Хуульч өмгөөлөгчдийн багийн гишүүн М.Саранцацралтай хийсэн уулзалтын тэмдэглэл.

<sup>33</sup> Ники Цүнэо, Монгол Улсын эвлэрүүлэн зуучлах тогтолцооны онцлог болон түүний зарим асуудал, “Шүүх эрх мэдэл” сэтгүүл, 2019, Дугаар 2, 22 дахь тал.

Америк, Англи улсуудын эвлэрүүлэн зуучлалын практикт гарч буй томоохон асуудал гэж үзэж байна.<sup>34</sup> Гэвч улс бүр энэ хандлагыг засах, сайжруулах арга хэмжээ авахыг оролдож буй жишээ цөөнгүй байгаа бөгөөд тухайлбал, Япон Улсад эвлэрүүлэн зуучлагч нь 45-аас дээш насны хүн байхыг тусгайлан заасан ба үүгээрээ зуучлагч заавал мэргэжлийн хүн байх албагүй бөгөөд амьдралын арвин баян туршлагатай, хүний итгэлийг хүлээхуйц,<sup>35</sup> эв зүйтэй харилцах чадвар суусан хүн байх шаардлагатай гэж үздэг аж.

### **Эвлэрлийн гэрээ шүүгчийн захирамжаар баталгаажих нь**

Эвлэрүүлэн зуучлуулагчийн статистик буурсан дараагийн нэг асуудал нь эвлэрлийн гэрээг шүүхээр хянан баталгаажуулдаг (ЭЗтХ-ийн 27.2, ИХШХШтХ-ийн 74 дүгээр зүйлийн 74.1 дэх хэсэг) явдалтай холбоотой. Хэдийгээр анхан шатны шүүгчийн захирамжаар баталгаажуулсан эвлэрлийн гэрээ нь хууль эрх зүйн хүрээнд хүчин төгөлдөр болсныг хянуулж улмаар гэрээний үүргийн гүйцэтгэлд эергээр нөлөөлж буй ч практикаас харахад олон тохиолдолд шүүхээс эвлэрлийн гэрээг нотлох баримт дутуу гэсэн үндэслэлээр баталгаажуулдаггүй<sup>36</sup> байна. Энэ нь эргээд хоёр тал харилцан тохиролцох, өөр өөрсдийн хүсэл зоригийн дагуу маргаанаа эвлэрлийн замаар шийдэж буй процесст хөндлөнгөөс оролцож байгаа нэг хэлбэр юм. Ийнхүү эвлэрэл хүчин төгөлдөр болох эсэх нь шүүгчээс буюу шүүхээс хамаарч байгаа бөгөөд энэ процесс нь шүүхийн бус аргаар маргаан шийдвэрлэх механизмын ач холбогдол, үр нөлөөг багасгаж буй хэрэг юм.

<sup>34</sup> Katja Funken, Comparative Dispute Management: Court-connected Mediation in Japan and Germany, German Law Journal (2002), 3-р дэвтэр. <http://www.germanlawjournal.com/index.php?pagelD=11&artID=130> 111 дэх тал.

<sup>35</sup> Katja Funken, Comparative Dispute Management: Court-connected Mediation in Japan and Germany, German Law Journal (2002), 3-р дэвтэр. <http://www.germanlawjournal.com/index.php?pagelD=11&artID=130> 113 дахь тал.

<sup>36</sup> Ники Цүнэо, Монгол Улсын эвлэрүүлэн зуучлах тогтолцооны онцлог болон түүний зарим асуудал, "Шүүх эрх мэдэл" сэтгүүл, 2019, Дугаар 2, 22 дахь тал.

## ГУРАВ. НЭГДСЭН ДҮГНЭЛТ

2.1. Цалин хөлсний маргааныг шүүх хянан шийдвэрлэхдээ ХтХ-д заасан хэргийн харьяаллын асуудлыг нэг мөр хэрэглэх шаардлагатай байгаа нь харагдлаа. Учир нь энэ судалгаанд авч үзсэн Тохиолдол 1 болон 2-т дүн шинжилгээ хийхэд хууль хэрэглээний хувьд (хэргийн харьяаллын хувьд) шүүх өөр өөрөөр шийдвэрлэж байгаа нь харагдаж байна. Тухайлбал, Тохиолдол 1-д шүүх цалин хөлсөө авч чадаагүй ажилтны нэхэмжлэлийг шийдвэрлэхдээ ХтХ-д заасан гомдлыг урьдчилан хянан шийдвэрлэх ажиллагаа хийгдсэн эсэх, хугацаандаа гомдол гаргасан зэрэгт огт дүн шинжилгээ хийлгүйгээр шийдвэр гаргасан байгаа бол Тохиолдол 2-ын тухайд шүүх хэрэгт авагдсан бүх нотлох баримтыг нэг бүрчлэн үнэлж хууль хэрэглээтэйгээ хослуулан, нэхэмжлэгч, хариуцагчдын тайлбарт нухацтайгаар хандан шийдвэрээ гаргасан болох нь дээр дурдсан дүн шинжилгээнээс харагдаж байна. Энэ утгаараа хэдийгээр манай улс шүүхийн жишиг прецедент ашигладаггүй ч иргэдийн шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлэх зорилгоор хуульд тусгагдсан ерөнхий зарчмын зохицуулалтыг нэг мөр хэрэглэж хэвших үүднээс зарим жишиг шийдвэрийг сонгон авч шүүгчдийн болоод хуульчдын сургалтад тогтмол ашиглаж байх нь зүйтэй гэсэн дүгнэлтэд хүрч байна.

2.2. Шүүх цалин хөлс олгоогүй эсхүл хугацаанд нь олгоогүй тухай маргааныг хянан хэлэлцэж шийдвэрлэхдээ нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож буй тохиолдолд тухайн нэхэмжлэл гаргаж буй иргэнийг өөрийн хөдөлмөр, цаг хугацаагаар эрх ашиг нь хохирсноос гадна нэмээд эдийн засгийн байдлаараа хохирохоос урьдчилан сэргийлэх чиглэл баримтлах нь зүйтэй. Учир нь энэхүү судалгааны хүрээнд шүүхийн шийдвэрүүдийг уншиж судлах явцад энэ төрлийн хэргийг шийдвэрлэхдээ ажилтныг тухайн газар ажиллаж байсан нь тогтоогдсонгүй, хөдөлмөрийн гэрээ байгуулалгүй ажил үүрэг гүйцэтгэсэн байна эсхүл нэхэмжилж буй цалингийн хэмжээгээ нотолж чадсангүй гэх мэт үндэслэлээр нэхэмжлэлийн шаардлагыг голчлон хэрэгсэхгүй болгож байгаа нь тухайн хүний хөндөгдсөн эрх ашгийг хамгаалж чадахгүй, шүүх дахин хохироох нөхцөл байдалд хүргэж байна. Иймд шүүх энэ төрлийн маргааныг шийдвэрлэхдээ хэрэгт авагдсан нотлох баримтыг тал бүрээс нь судалж үнэлэн, нэхэмжлэгч, хариуцагчдын гаргаж буй тайлбарыг хууль хэрэглээтэйгээ сайтар уялдуулах замаар хэргийг шийдвэрлэхийг зорих нь зүйтэй юм гэсэн дүгнэлтэд хүрч байна.

2.3. Сахилгын шийтгэл ногдуулахтай холбоотой ажиллагаанд дараах дүгнэлтийг хийж байна. Нэгдүгээрт, сахилгын шийтгэлтэй холбоотой маргаан нь ажилтны нэг жилийн шагнал урамшууллаас хасахаас эхлээд хөдөлмөрийн харилцааг шууд цуцлах хүртэл үр дагавартай тул шүүх маргаж буй зүйлийг зөрчил эсэх, ногдуулсан сахилгын шийтгэл нь зохих зарчимтай нийцэж буй эсэх, нотлох баримтыг тал бүрээс нь үнэлсэн эсэхийг маш нарийн нягтлах шаардлагатай. Ийм учраас энэ төрлийн маргааныг

зөвхөн хууль хэрэглээний үүднээс хэрэгт авагдсан нотлох баримтын хүрээнд явцуу утгаар бус, шүүхийн шийдвэр хөдөлмөрийн харилцааны цаашдын хөгжилд шууд нөлөөлөх чадвартай ба үүгээрээ зохистой хөдөлмөрийг баталгаажуулахад хувь нэмэр оруулж, нийгмийн харилцаанд, иргэдийн ажил амьдралын замд шударга ёсны чиг хандлагыг зааж өгөх ач холбогдолтой гэдэг утгаар нь илүү нухацтай тунгааж шийдэх нь шүүгчдэд тулгарч буй сорилт гэж харж байна. Сахилгын шийтгэл хүртэх нь ажилтны хувьд нэгэнт томоохон сөрөг үр дагавар дагуулах тул ажилтан тухайн сахилгын шийтгэлийг хүлээн зөвшөөрөхгүй бол түүнд зарга үүсгэх эрхээ шүүхээс өмнөх шатанд илүү хялбар, бодитой, хурдан шуурхай эдлэх боломжоор хангах нь чухал юм. Мөн сахилгын давтан шийтгэлийн тодорхойлолтыг илүү тодорхой, ойлгомжтой болгох болон аж ахуйн нэгж, байгууллагын сахилгын шийтгэлтэй байх хугацаанд шагнал, урамшуулал, үр дүнгийн урамшуулал зэргээс хасдаг зохицуулалт нь хуульд нийцэхгүй гэдгийг тайлбарлах нь зүйтэй. Энэ асуудлуудыг ХтХ-ийн шинэчилсэн найруулгад санал оруулах аргаар шийдэх боломжтой.

- 2.4. Одоогийн байдлаар хөдөлмөрийн маргааныг шүүхээс өмнөх шатанд буюу хялбаршуулсан байдлаар шийдэж болох хэд хэдэн механизмыг хуульчлан хэрэглэж байгаа боловч тухайн зохицуулалт практикт хэрэгжих нь ховор байна. Тухайлбал, ХтХ-ийн дагуу ХМТК аж ахуйн нэгж, байгууллага бүрд байхаар хуульчлагдсан боловч уг комисс нэг бүрчлэн байдаггүй болох нь харагдаж байна. Түүнчлэн эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд иргэд хандах боловч эвлэрүүлэн зуучлах ажиллагаа дээр дурдсанчлан зохих зарчмын дагуу явагддаггүйгээс иргэдийн итгэлийг төдий л

олохгүй байгаа сөрөг тал ажиглагдаж байна. Энэхүү дутагдалтай тал нь иргэдэд маргаанаа шууд шүүхээр шийдвэрлүүлж мөнгө, цагаа хэмнэх хүсэл эрмэлзлийг илүү төрүүлж байна.

2.5. Энэхүү судалгааны хүрээнд шүүхийн шийдвэрийг түүвэрлэх, хайлт хийх явцад тодорхой бэрхшээл гарч байсан тул санг сайжруулахад дараах зүйлийг санал болгож байна. Үүнд:

- *Хайлтын системийг боловсронгуй болгох буюу илцү нарийвчилсан байдлаар хайх боломжийг нэмэгдүцлэх.* Тухайлбал, маргаан гарсан салбараар, хэрэглэсэн хуулийн зүйл, заалт гэх мэт үзүүлэлтээр олон төрлөөр ялган харуулдаг байх нь хайлтыг хялбарчлах давуу талтай.
- *Шүцхийн шийдвэрүд системд бүрэн бүртгэгдэн орж байгаа эсэхийг хянах, шалгах болон цүнтэй холбоотой иргэдээс ирэх санал, хүсэлт, гомдлыг шуурхай шийдвэрлэх суваг нээн ажиллуулах.* Одоогийн байдлаар зарим шүүхээр шийдэгдсэн маргаан хайлтын илэрцээр гарч ирэхгүй байгаа тул ийм суваг нээн ажиллуулах санал гаргаж байна.
- *Шүцхийн дэргэдэх эвлэрүцлэн зуучлах ажиллагаа хийгдсэн маргааныг оролцогчдын нууцыг хадгалах зарчмын дагуу зөвхөн маргааны төрлөөр нь тоон үзүцлэлтийн мэдээллийг төвлөрүцлэх.* Энэ нь уг эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үр дүнг судлахад түлхэц болох юм.

## ДӨРӨВ. НОМ ЗҮЙ

### 1. Хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992.
2. Иргэний хууль, 2002.
3. Хөдөлмөрийн тухай хууль, 1999.
4. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002.
5. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, 2012.
6. Зөрчлийн тухай хууль, 2017
7. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, 2017.
8. Хөдөлмөрийн тухай хуулийн зарим зүйл заалтыг тайлбарлах тухай Улсын Дээд шүүхийн тогтоол, 2006.

### 2. Ном, гарын авлага

1. С.Болормаа, Хөдөлмөрийн эрх зүйн үндсэн асуудлууд, УБ., 2016.
2. Л.Баасан, Монгол Улсын хөдөлмөрийн эрх зүй, УБ., 2010.
3. Н.Лүндэндорж *Jurisprudence*, УБ., 2011.
4. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Олон улсын сургалтын төв, Хөдөлмөрийн маргааны удирдлагын тогтолцоо, УБ., 2020.
5. Б.Уранцэцэг, С.Ганцэцэг, “Хөдөлмөрийн эрх зүй” хичээлийн сургалтын гарын авлага, УБ., 2012.
6. Б.Уранцэцэг, “Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчлэл ба шүүхийн практик” илтгэл, Эрх зүй ба эдийн засаг (Илтгэл, шийдвэрийн эмхэтгэл), УБ., 2018.



### 3. Бусад судалгаа, академик эссэ

1. Л.Галбаатар, Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх арга зүй, УБ., 2020.
2. ХНХЯ ба ОУХБ, Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийн төлөв байдлын судалгаа, УБ., 2014.
3. Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн, Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх аргачлал, УБ., 2015.
4. Ники Цүнэо, Монгол Улсын эвлэрүүлэн зуучлах тогтолцооны онцлог болон түүний зарим асуудал, “Шүүх эрх мэдэл” сэтгүүл, УБ., 2019.
5. Goeff Hogbin, Power in Employment relationships: Is there an imbalance? 2 дахь тал., <http://archive.hrnicholls.com.au/articles/hrn-hogbin1.pdf>, зочилсон огноо: 2021.09.06.
6. Resolving individual labour disputes: A comparative overview, ILO, 2016. <file:///Users/mama/Downloads/Resolving%20Individual%20Labour%20Disputes%20-%20A%20comparative%20overview.pdf>, зочилсон огноо: 2021.09.06.
7. Katja Funken, Comparative Dispute Management: Court-connected Mediation in Japan and in Germany, German Law Journal, 3-р дэвтэр (2002), <http://www.germanlawjournal.com/index.php?pageID=11&artID=130>, зочилсон огноо: 2021.09.06.

### 4. Вэб хуудас

1. [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)
2. [www.judoinstitute.mn/](http://www.judoinstitute.mn/)
3. [www.shuukh.mn/](http://www.shuukh.mn/)
4. <https://www.1212.mn>
5. [www.supremecourt.mn](http://www.supremecourt.mn)



# ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА ХАРИУЦСАН РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН ТАНИЛЦУУЛГА

## ДАШНЯМЫН ЗОЛЖАРГАЛ (LL.M.)

Өмгөөллийн DB&GTS ХХН-ийн гишүүн хуульч



Монголын санхүү, хөрөнгийн зах зээлийн чадварлаг мэргэжилтнүүдийн нэг бөгөөд компанийн эрх зүй, эрчим хүч, эрдэс баялгийн салбараар мэргэшсэн хуульч юм. Хуулийн фирмээ байгуулж ажиллахаасаа өмнө тэрээр Монголын томоохон арилжааны банканд хуульчаар ажилласан туршлагатай.

МУИС-ийн ХЗС-ийн Олон улсын эрх зүйн бакалавр, 2004 онд АНУ-ын Оклахомагийн Их сургуулийг Бизнесийн удирдлагын магистр, Харвардын Их сургуулийн Хуулийн сургуулийг хууль зүйн магистр зэрэгтэй тус тус дүүргэсэн.

## АЛТАНГЭРЭЛИЙН БЯМБАЖАРГАЛ (S.J.D.)



МУИС-ийн ХЗС-д төрийн захиргаа, Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүй, Үндсэн хуулийн процессын эрх зүй, харьцуулсан эрх зүйн хичээл заадаг. ХЗС-ийн эрдэмтэн нарийн бичгийн даргын хувиар эрдэм шинжилгээний ажил, бүтээл түүрвил, улирал тутмын “Эрх зүй” сэтгүүлийг эрхлэн гаргах ажил хариуцан ажиллаж байв. 2021 оноос Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөхөөр томилогдон ажиллаж байна.

МУИС-ийн ХЗС-ийг дүүргэж, БНСУ-ын Күүкминий Их сургуульд хууль зүйн докторын зэрэг хамгаалсан.

## НАРАНЧУЛУУНЫ ОТГОНЧИМЭГ (LL.M.)



Захиргааны эрх зүйн чиглэлээр мэргэшсэн хуульч, судлаач бөгөөд УИХ-ын Тамгын газар, олон улсын хөгжлийн хөтөлбөрүүдэд зөвлөх зэргээр мэргэжлээрээ 22 жил ажилласан туршлагатай хуульч юм. 2021 оноос УДШ-ийн дэргэд байгуулагдсан Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирлаар ажиллаж байна.

МУИС-ийн ХЗС-ийг магистрын зэрэгтэй, Лондоны Kings college-ийг хууль зүйн магистр зэрэгтэй төгссөн.

## ГАНЧУЛУУНЫ ОЮУНБОЛД (LL.M.)



Криминологи, эрүүгийн болон эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй, шүүхийн шийдвэр биелүүлэх эрх зүйн чиглэлээр мэргэшиж судалдаг ба практикийн болон судалгааны байгууллагад 18 жил ажилласан туршлагатай.

Цагдаагийн академийг эрх зүйн бакалавр зэрэгтэй төгсөж “Эрүүгийн байцаан шийтгэх хугацаа” сэдвээр хууль зүйн ухааны магистрын зэрэг хамгаалсан. Тэрчлэн Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн мэргэжлийн англи хэлний ангид суралцаж менежментийн бакалаврын зэрэгтэй төгссөн.

## СҮХЭЭГИЙН БИЛГҮҮН (LL.M.) ШЕЗ-ийн Тамгын газрын дарга



Хууль зүйн судалгаа, сургалт, шүүхийн захиргааны чиглэлээр ажилладаг.

МУИС-ийн ХЗС-д суралцаж, “Монгол Улсад эрх зүйн зайлшгүй процессыг төлөвшүүлэх нь” сэдвээр, Япон Улсын Кюсюгийн Их сургуульд суралцаж “Монгол Улс дахь нийтийн ашиг сонирхлыг шүүхэд төлөөлөн хамгаалах тогтолцоог бэхжүүлэх нь” сэдвээр хууль зүйн магистрын зэрэг тус тус хамгаалсан.

Харьцуулсан эрх зүй, хүний эрхийн чиглэлээр судалгаа хийдэг.



ISBN 978-9919-9812-6-6



9 789919 981266